



дэмжлэгтэйгээр
бэлтгэв.

БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛЫН УДИРДАМЖ

МОНГОЛЫН КОМПАНИУДАД ЗОРИУЛАВ





АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
Удирдамжийн бүтэц	7
1. УДИРТГАЛ	11
1.1 Үндэслэл	11
1.2 Удирдамжийн зорилго, зорилтот хэрэглэгчид	15
1.3 Тогтвортой байдлын тайлагналын ашиг тус	16
2. ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН АРГАЧЛАЛ, СТАНДАРТУУД БА НИЙЦЭЛ	20
3. ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ	29
Алхам 1: Компанийн мэдэгдэл болон удирдлагын дэмжлэг	29
Алхам 2: Тайлагналын ажлыг хариуцах албан тушаалтнуудыг томилох	30
Алхам 3: Тайлагнавал зохих материаллаг асуудлуудыг тодорхойлох	31
Алхам 4: Тайлангийн агуулга, гол үзүүлэлтүүдийг тодорхойлох	33
Алхам 5: Төлөвлөх, мэдээлэл цуглуулах	35
Алхам 6: Баталгаа гаргуулах	36
Алхам 7: Тайланг боловсруулах, хянах, тайлагнах	37
Алхам 8: Тогтмол сайжруулах төлөвлөгөө	40
4. ЮУГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ВЭ	41
4.1 Удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд	43
4.2 Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд	50
4.3 Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд	60
4.4 Засаглалын шалгуур үзүүлэлтүүд	68
4.5 Салбарын шалгуур үзүүлэлтүүд	73
ХАВСРАЛТ	81
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	94

ӨМНӨХ ҮГ



Монгол Улс Парисын хэлэлцээр, Алсын хараа-2050 зорилтуудын хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийн нийт ялгарлыг 22.7%-иар бууруулж, байгаль орчин нийгэмд ээлтэй, хүртээмжтэй, хүний хөгжилд анхаарсан, сайн засаглалтай, чанартай боловсрол олгоход чиглэсэн томоохон амлалтуудыг аваад байна. Эдгээр томоохон зорилтуудыг биелүүлж, хэрэгжилтийг хангахад их хэмжээний нэмэлт санхүүгийн эх үүсвэр нэн шаардлагатай тул бүх төрлийн санхүүгийн урсгалуудыг зөв чиглэл рүү хөдөлгөх нь чухал болоод байна. Санхүүжилтийн энэхүү хэрэгцээ шаардлага, ач холбогдолд үндэслэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Үндэсний Тогтвортой Санхүүжилтийн Замын Зураг”-ийг баталлаа. Замын зураг нь 2030 он хүртэл Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтуудыг санхүүгийн системийн тогтвортой өсөлт хөгжилд түшиглэн хурдасгах нэгдсэн, олон талуудын оролцоотой стратегийн суурь баримт бичиг болж байна.

Замын зурагт орсон нэг чухал зорилт нь хөрөнгийн зах зээлд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын үзүүлэлт, ил тод байдлын стандартыг нэвтрүүлэх ажил юм. Өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой хөгжлийн асуудал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад гол шалгуур болж буй тул бүртгэлтэй компаниудын хувьд БОНЗ нь орхигдуулж боломгүй асуудал юм. Монголын хөрөнгийн зах зээлд эзлэх нийт бүртгэлтэй компаниудын тоо 180 хүрч 2021 оны байдлаар нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээг 5.98 их наяд төгрөгт хүргээд байна. Энэ нь хөрөнгийн зах зээл Монгол

Улс тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд манлайлах үүрэгтэй оролцох боломжтойг харуулж байна. Тэр дундаа, бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа, шийдвэр нь илүү том зах зээлд шууд нөлөөлөх боломжтой юм. Энэ нь хөрөнгийн зах зээлийн оролцогч талууд болон Санхүүгийн зохицуулах хорооноос өндөр хариуцлагыг шаардаж байгаа юм.

Олон улсын жишигт нийцүүлэн БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг нэвтрүүлснээр бид БОНЗ-ын удирдлагыг сайжруулж, ил тод байдлыг хөрөнгийн зах зээлийн аливаа оролцогч, үнэт цаас гаргагчид болон бизнесийн байгууллагууд цаашлаад Монгол Улсад урт хугацааны үнэ цэнийг бий болгох ач холбогдолтой гэж харж байна. Мөн түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлснээр дотоод гадаадын хөрөнгө оруулагчдад итгэлцлийг бий болгож, өгөөжийг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болно гэдэгт бид итгэл дүүрэн байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь бичил санхүү, даатгал, бондын зах зээл зэрэг санхүүгийн системийн бусад хэсэгт тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийг мөн адил дэмжин ажилладаг билээ. Тухайлбал, Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн шинэ журамд ногоон даатгалын тогтолцоо, ногоон бонд гаргах зохицуулалт, стандартыг нэвтрүүлээд байна. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг нэвтрүүлэх ажлыг цаашид бусад талуудтай хамтран хэрэгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Энэхүү удирдамж нь 2022 он болон урт хугацаанд хөрөнгийн зах зээлийг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн шинэчлэх олон алхмуудын эхлэл болж буйг цохон тэмдэглэе.

Энэхүү удирдамжийг боловсруулахад тасралтгүй дэмжлэг үзүүлж, бидэнтэй хамтран ажилласан Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо, Монголын Хөрөнгийн Бирж, Олон улсын санхүүгийн корпораци, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой байдлын санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр байгууллагуудад гүнээ талархал илэрхийлье. Бид монголын хөрөнгийн зах зээлд тогтвортой хөгжлийн хурдасгуур болж, бидний нийтлэг ирээдүйг хангах урт хугацааны тогтвортой хөгжлийн асуудлуудыг хамарсан нэгдсэн хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэхэд хичээнгүйлэн ажиллах болно.

Д.Баярсайхан
Санхүүгийн зохицуулах хорооны Дарга

ЗОРИЛТОТ ХЭРЭГЛЭГЧИД

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй компаниуд, цаашид бүртгүүлэхээр төлөвлөж буй үнэт цаас гаргагчид болон тайлагнал хийх хүсэлтэй бүх төрлийн байгууллагуудын үйл ажиллагааг илүү нээлттэй, ил тод болгохыг дэмжих зорилгоор байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) буюу Тогтвортой байдлын тайлагналын стандарт, удирдамжийн баримт бичиг (Удирдамж)-ийг боловсруулсан болно. Энэхүү удирдамж нь компаниудад Тогтвортой байдлын тайлангаа бэлтгэх, БОНЗ-ын мэдээллээ ил тод болгоход нь туслах үүднээс холбогдох суурь мэдээлэл, заавраар хангахыг зорьж буй. Иймд компаниуд зөвхөн энэхүү удирдамжид туссан шаардлагаар хязгаарлагдахгүйгээр өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар нээлттэй, ил тод тайлагнахыг зөвлөж байна.

УДИРДАМЖИЙН ТУХАЙ

Энэхүү удирдамжийг СЗХ, Монголын хөрөнгийн бирж (МХБ), Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо), Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ (ТБТСТОУС) тус тус хамтран, Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС) болон НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сангийн дэмжлэгтэйгээр боловсруулсан болно. Удирдамж боловсруулсан төслийн багт: Баттулгын Дөлгөөн, Хангайн Алтай, Иванов Жавхлан, Энхтөрийн Номиндарь, Даваахүүгийн Төмөрхүү, Бэгзийн Дэлгэрмаа, Батболдын Батмөнх, Алиев Анар, Ралица Германова, Дамбажанцангийн Энхзул, Төмөртоогогийн Дэлгэрнаран, Стефен Нолан, Флоренсия Балди, Делфина Монтеверди, Махинау Агха, Нана-Офори Окөрэ, Маркос Манчини, Баатархүүгийн Болортуяа, Баасансүрэнгийн Баярмагнай нар тус тус оролцсон.

ТАЛАРХАЛ

Удирдамжийг үнэт цаас гаргагчдын дунд хийсэн суурь судалгаа, ярилцлага болон оролцогч талуудын санал хэлэлцүүлэгт үндэслэн боловсруулсан болно. Энэ удирдамжийг боловсруулах явцад санал зөвлөмж өгсөн бүх байгууллагууд, мэргэжилтнүүдэд талархал илэрхийлж байна. Баримт бичгийн үндсэн агуулгыг боловсруулахад оролцогч талуудын санал бодол үнэтэй хувь нэмэр оруулсныг мөн тэмдэглэж байна. Удирдамжийг боловсруулахдаа олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагнал, ил тод байдлын стандарт, эх сурвалжуудыг ашигласан болно. Удирдамжтай холбоотой асуулт, санал хүсэлтийг info@frc.mn хаягаар ирүүлнэ үү.

УДИРДАМЖИЙН БҮТЭЦ

Энэхүү удирдамж нь дараах 4 бүлэгтэй.

- Бүлэг 1. Удирдамжийн удиртгал хэсэг ба үндэслэл.
- Бүлэг 2. Олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын стандарт, аргачлалууд.
- Бүлэг 3. Тогтвортой байдлын тайлагналын тогтолцоог бүрдүүлэх алхмууд.
- Бүлэг 4. БОНЗ-ын тайлагналын үзүүлэлтүүд болон тэдгээрийг хэрхэн тайлагнах нарийвчилсан заавар.
- Хавсралт хэсэгт Тогтвортой байдлын тайлан боловсруулахдаа компаниуд цаашид судалж ашиглавал зохих эх сурвалжууд.

Хэвлэлийн эрх © Санхүүгийн зохицуулах хороо. Бүх эрх хамгаалагдсан. 2022 .

Анхааруулга

Энэхүү тайланд туссан дүгнэлт, санал зөвлөмж нь ОУСК, Дэлхийн Банк, НҮБ-ын байгууллагууд, түүний Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлууд болон тэдгээрийн төлөөлж буй улс орнуудыг хамаарахгүй бөгөөд тэдний үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Энэхүү удирдамжид орсон мэдээллийн найдвартай байдлыг ОУСК, Дэлхийн банк, НҮБ-ын байгууллагуудын зүгээс баталгаажуулаагүй бөгөөд тайлангийн мэдээллийг ашигласнаас үүдэх аливаа үр дагаварт хариуцлага хүлээхгүй болно.

ТОВЧИЛСОН ҮГС

ЕБХ	Business-as-Usual	Ердийн бизнесийн хувилбар
БХЭ	Biological Oxygen Demand	Биологийн хүчилтөрөгчийн эрэлт
НЯМТ	Carbon Disclosure Project	Нүүрстөрөгч ялгаруулалтыг нийтэд ил тод мэдээлэх төсөл
УАӨМСЗ	Climate Disclosure Standards Board	Уур амьсгалын өөрчлөлтийг мэдээлэх стандартын зөвлөл
МСШ	Chartered Financial Analyst	Мэргэшсэн санхүүгийн шинжээч
КНХ	Corporate Social Responsibility	Компанийн нийгмийн хариуцлага
БОН	Environmental and Social	Байгаль орчин, нийгэм
БОНЗ	Environmental, social, and governance	Байгаль орчин, нийгэм, засаглал
БОНУТ	Environmental & Social Management System	Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоо
ТБТСТОУС	UNDP International Network of Financial Centres for Sustainability	НҮБХХ-ийн Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ
СЗХ	Financial Regulatory Commission	Санхүүгийн зохицуулах хороо
БЦЭ	Full-time Equivalents	Бүтэн цагийн эквивалент
ДНБ	Gross Domestic Product	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДДБОС	Global Environment Facility	Даян дэлхийн байгаль орчны сан
ХХ	Greenhouse Gas	Хүлэмжийн хий
МУЗГ	The Government of Mongolia	Монгол Улсын Засгийн газар
ТОУС	Global Reporting Initiative	Тайлагналын олон улсын санаачилга
ДДТБСЗ	Global Sustainability Standards Board	Даян дэлхийн тогтвортой байдлын стандартын зөвлөл
ДДТБ	Global Warming Potential	Дэлхийн дулаарлын төлөв байдал
ЕХ	European Union	Европын холбоо
БОНУ	Environmental Impact Assessment	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
ОУСК	International Finance Corporation	Олон улсын санхүүгийн корпораци
СТОУС	The International Financial Reporting Standards	Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд
ҮЦХОУБ	The International Organization of Securities Commissions	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага
ОУНББСХ	The International Accounting Standard Board	Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хороо
ОУТБСХ	International Sustainability Standards Board under IFRS Foundation	СТОУС Санд харьяалагддаг Олон улсын тогтвортой байдлын стандартын хороо
ОУНТЗ	The International Integrated Reporting Council	Олон улсын нэгдсэн тайлагналын зөвлөл
НТ	Integrated Reporting	Нэгдсэн тайлагнал

УАУХЗ	Intergovernmental Panel on Climate Change	Уур амьсгалын асуудлаарх улс хоорондын зөвлөл
МУУМТ	Mongolian National Tugrik	Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт
СОУБ	International Organization for Standardization	Стандартчиллын олон улсын байгууллага
ОУШХБ	International Labor Organization	Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага
МУС	Mongolian National Standard	Монгол Улсын стандарт
МХБ	Mongolian Stock Exchange	Монголын хөрөнгийн бирж
МТХБС	Mongolian Sustainable Stock Exchange Initiative	Монголын тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга
ТоС Холбоо	Mongolian Sustainable Finance Association	Монголын тогтвортой санхүүгийн холбоо
ҮТХН	Nationally Determined Contributions	Үндэсний тодорхойлсон хувь нэмэр
ТББ	Non-government Organization	Төрийн бус байгууллага
ЭЗХАХБ	Organization for Economic Co-operation and Development	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ХАБЭА	Occupational Health and Safety	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал
ТБНББСЗ	The Sustainability Accounting Standards Board	Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл
ТХЗ	Sustainable Development Goals	Тогтвортой хөгжлийн зорилгууд
ННУ	Social Impact Assessment	Нийгмийн нөлөөллийн үнэлгээ
ТХБ	Sustainable Stock Exchange	Тогтвортой хөрөнгийн бирж
ТБУТ	Sustainability Management System	Тогтвортой байдлын удирдлагын тогтолцоо
УАӨСМТАХ	Task Force on Climate-Related Financial Disclosures	Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсэг
БОТСМТАХ	Task Force on Nature-Related Financial Disclosures	Байгаль орчны төлөөх санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсэг
НТХБ	Total Suspended Solids	Нийт түдгэлзүүлэх хатуу бодис
НҮБХХ	United Nations Development Programme	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮББОХ	United Nations Environment Programme	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮББОХ СС	United Nations Environment Programme Finance Initiative	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Санхүүгийн санаачилга
ДНИ	World Resources Institute	Дэлхийн нөөцийн институт
ДТХТБЗ	World Business Council for Sustainable Development	Дэлхийн Тогтвортой хөгжлийн төлөөх бизнесийн зөвлөл





1

УДИРТГАЛ

1.1 ҮНДЭСЛЭЛ

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавар, тогтвортой хөгжилд тулгарах эрсдэлүүд эрчимжихийн хэрээр тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх нь нэн чухал болохыг зохицуулагчид, хөрөнгө оруулагчид, олон нийт ухамсарлан хүлээн зөвшөөрч Монгол Улсад төдийгүй дэлхий дахинаа тогтвортой хөгжлийн талаарх бодлого, санаачилгууд хурдацтай хэрэгжиж байна. Тэр дундаа, улс орнууд хамтран [Тогтвортой хөгжлийн зорилгууд \(ТХЗ\)](#) болон [Парисын хэлэлцээрийг](#) баталсан нь Тогтвортой бизнес болон тайлагналыг хөгжүүлэхэд томоохон түлхэц өгсөн хүчин чармайлтуудын нэг болсон юм. Хөгжлийн төлөөх эдгээр агуу зорилгуудыг дэмжин Монгол Улсын Засгийн газар [Алсын хараа 2050](#) болон [Үндэсний тодорхойлсон хувь нэмэр \(ҮТХН\)](#) зэрэг үндэсний хөгжлийн томоохон бодлогын баримт бичгүүдийг боловсруулан баталсан юм. Монгол Улсын хувьд үндэсний хэмжээний хүлэмжийн хийн нийт ялгарлыг (ХХЯ) ердийн бизнесийн хувилбар (ЕБХ)-тай харьцуулахад 22.7 хувиар бууруулж, эдийн засгийн өсөлт, байгаль орчны тэнцвэр, нийгмийн тогтвортой байдал зэргийн аль алиныг нь хангасан хөгжлийн замд хүрэхийг эрмэлзэж байна.

Зураг 1. Тогтвортой хөгжлийн зорилгууд, Парисын хэлэлцээр



Эх сурвалж: НҮБХХ; НҮБ-УАӨСК/UNFCCC

Тогтвортой, ногоон хөгжил рүү шилжих энэхүү шинэ замналыг даган бизнесийн хэтийн төлөв ч өөрчлөгдөж байна. Бизнесийн зорилго нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг бий болгоход бус компаниудын үйл ажиллагаанаас БОНЗ-д үзүүлэх үр нөлөөг тооцсон оролцогч талуудын урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэж буй. Үүнтэй зэрэгцэн тогтвортой байдлын хүчин зүйлс нь санхүүгийн шийдвэр гаргах чухал бүрэлдэхүүн хэсэг болж өөрчлөгдөж байна. Хөрөнгө оруулагчид ч компаниудын үйл ажиллагаанаас үүдэлтэй учирч болзошгүй БОНЗ-ын эрсдэлүүд, тэдгээрийг удирдах, даван туулах чадавх, улмаар бизнесийн үнэ цэнийг бий болгох чадварыг нь илүү сайн ойлгохын тулд компаниудын тогтвортой байдлын стратеги, арга хандлагад илүүтэй анхаарах болсон. Ийнхүү БОНЗ-ын асуудлаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид ихээхэн анхаарах болсон нь энэ чиглэлийн мэдээллийн эрэлт хэрэгцээг эрс нэмэгдүүлж байна. Оксфордын их сургууль болон Харвардын их сургуулиас хөрөнгө оруулалтын байгууллагуудын дунд дэлхийн хэмжээнд явуулсан судалгааны үр дүнгээс ажиглахад хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд санхүүгийн чухал ач холбогдолтой учраас БОНЗ-ын асуудлаарх мэдээллийг ашигладаг хэмээн “Судалгаанд оролцогчдын дийлэнх (82%) нь хариулжээ”¹. **БОНЗ-ын асуудлыг санхүүгийн асуудалтай зэрэгцүүлж судлах бизнесийн удирдлагын цогц арга хандлага бол тухайн бизнесийг тасралтгүй явуулах, улмаар урт хугацаанд өрсөлдөх чадварыг нь дэмжих бизнесийн сайн загвар байх болно.**

Гэхдээ БОНЗ-ын мэдээллийг санхүүгийн дүн шинжилгээнд нэгтгэж ашиглахад БОНЗ-ын мэдээллийн чанар сул байгаа нь ихээхэн бэрхшээл учруулж байна. Мэргэшсэн санхүүгийн шинжээчдийн хүрээлэн (CFAI)-гийн саяхны судалгаагаар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа хөрөнгө оруулагчдын санхүүгийн бус мэдээллийг ашиглах боломжийг хязгаарлаж буй гол хүчин зүйл нь БОНЗ-ын тоо мэдээлэл хязгаарлагдмал байгаа явдал юм. Иймээс компани хоорондын харьцуулалт хийх боломжгүй, тоо мэдээллийн чанар,

баталгаажуулалт хангалтгүй байна хэмээн дүгнэсэн байна. НҮБХХ-ийн ТБТСТОУС-нээс гаргасан сүүлийн үеийн судалгаа, тайлангаас² үзэхэд мэдээллийн чанар, хүртээмж нь ихэнх санхүүгийн төвүүдэд тулгардаг байнгын сорилт болж байна. 2020 болон 2021 онуудад судалгаанд хамрагдсан (24 болон 29) санхүүгийн төвүүдийн гуравны хоёр нь мэдээллийн чанар, хүртээмж нь тогтвортой санхүүжилтийг нэмэгдүүлэхэд тулгарч буй гол гурван саад тотгорын нэг гэж мэдээлсэн. Хүртээмжтэй байдал, найдвартай байдал, бүрэн бус байдал, харьцуулах боломжгүй байдал, түүнчлэн шаардлагатай ур чадвар, аналитик чадвар дутмаг зэрэг асуудлууд одоогоор улс орнуудад тогтвортой санхүүжилтийг нэвтрүүлэхэд саад болж байна.


ШИГТГЭЭ 1: ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУДЫН ТАЙЛАГНАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУУРЬ ҮНЭЛГЭЭ

Төслийн багаас Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын өнөөгийн нөхцөл байдалд 2021 оны 4-р сард суурь үнэлгээ хийсэн.


Үнэлгээнд нийт 42 компани (хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын 25 орчим хувь) хамрагдсан бөгөөд үнэлгээний дүнгээс дүгнэхэд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын тогтвортой байдлын тайлагнал хязгаарлагдмал байгаа бөгөөд засаглалтай холбоотой үзүүлэлтүүд харьцангуй ил тод болж байгаа хэдий ч компаниуд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл гэх зэрэг байгаль орчин, нийгмийн асуудлаар тайлагнах талаар мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг байна. Гэсэн хэдий ч, судалгаанд оролцогч **компаниуд тогтвортой байдлын тайлан гаргах хүсэл эрмэлзэлтэй** бөгөөд тодорхой удирдамж заавраар ханган, чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх аваас холбогдох мэдээллийг цуглуулж, ил тод тайлагнах боломжтой гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Түүнчлэн БОНЗ-ын асуудлыг тайлагнах заавар журмыг амжилттай хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хараахан хүрэхгүй байгаа мэдээллийг ил тод болгоход тус дөхөм болохоос гадна тайлагналын чанар, компаниудын ур чадварыг сайжруулж, улмаар хөрөнгө оруулагчдад компаниудын БОНЗ-ын гүйцэтгэлийг жиших боломжийг олгоно хэмээн үнэт цаас гаргагчид онцлон тэмдэглэсэн байна. Зөвхөн тайлагнах, ил тод мэдээлэхтэй холбоотой асуудлаар хязгаарлалгүй **тогтвортой байдал, байгаль орчин болон нийгмийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх**, хэрэгжүүлэхэд чиглэсэн чадавх бэхжүүлэх болон техникийн дэмжлэг туслалцааг компаниудад үзүүлэх шаардлага байгааг онцолсон байна. Компаниудын дунд мэдлэг мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмол явуулах, жил бүр чуулга уулзалт зохион байгуулах нь компаниудын үйл ажиллагааг дэмжиж, улмаар тэдгээрийн хамтын ажиллагаа, тайлагналын хэрэгжилтийг өргөжүүлэхэд тустай байх болно.

Зураг 2. Бүртгэлтэй компаниудын тогтвортой байдлын удирдлагын тогтолцоо



Зураг 3. БОНЗ-ын үзүүлэлтүүдийн тайлагналын өнөөгийн байдал



Эх сурвалж: Төслийн багийн үнэлгээ (2021)

Тайлагналын дутуу орон зайг нөхөх, мэдээллийн эрэлт хэрэгцээг хангах замаар үйл ажиллагааныхаа БОНЗ, тогтвортой байдлын талаар тодорхой бөгөөд үнэн зөв мэдээлэл өгөх нь компаниудын хувьд улам бүр чухал болж байна. СЗХ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, бизнесийн сайн загвартай компаниудтай хамтран ажиллаж, тэдэнд хөрөнгө санхүүжилт татахад нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн ажилладаг. Үүний зэрэгцээ СЗХ нь ил тод, тогтвортой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэн дэмжихийн зэрэгцээ үнэт цаас гаргагчдын эрсдэлийн төлөв байдал, өсөлтийн чиг хандлагыг тууштай, харьцуулахуйц байдлаар бүх төрлийн компаниуд, салбарыг хамруулан судлахад нь шаардагдах мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангах замаар тэднийг үндэслэлтэй, тогтвортой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Дээрх зорилгын үүднээс СЗХ нь МХБ, ТоС Холбоо, ОУСК, ТБТСТОУС, НҮББОХ, НҮБХХ-тэй хамтран энэхүү тайлан, тодруулгын удирдамжийг боловсруулсан. Энэхүү удирдамжийг Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (ТБНББСЗ) стандарт, Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах ажлын хэсэг (УАӨСМТАХ)-ийн зөвлөмж, ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт болон Компанийн засаглалын арга зүй зэрэг тайлагналын олон улсын гол гол стандарт, аргачлалтай нийцүүлэн боловсруулсан болно.

Тогтвортой байдлын тайлагнал гэдэг нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын дагуу байгууллагынхаа үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж байх байгууллагын хэвшүүлэх дадал юм. Ийнхүү ил тод байснаар байгууллагууд БОНЗ-д үзүүлж буй өөрийн нөлөөллийг тодорхойлох, танин мэдэх, мэдээлэх, улмаар зорилгоо тодорхойлох, өөрчлөлтийг илүү үр дүнтэй удирдах боломжийг бүрдүүлнэ. –ТОУС

1.2 УДИРДАМЖИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТОТ ХЭРЭГЛЭГЧИД

Удирдамж нь дараах үндсэн зорилгуудыг агуулсан. Үүнд:

- Үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид болон олон нийтийн тогтвортой байдлын тайлагналын ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, үнэт цаас гаргагчдад хурдацтайгаар хөгжиж тогтвортой байдлын тайлагналын орчинд хөл нийлүүлэхэд нь туслах,
- БОНЗ буюу тогтвортой байдлын жилийн тайлан гаргахад нь компаниудад тус болох ерөнхий алхмуудыг тоймлон харуулах,
- Компаниуд тайлан гаргахдаа анхаарал хандуулбал зохих БОНЗ-ын үндсэн үзүүлэлтүүдийн багцыг зөвлөмж болгох,
- Тогтвортой байдлын тайланг гаргах явцдаа компаниуд судалж ашиглавал зохих бодит туршлага, эх сурвалжуудаар хангах,
- Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, НҮБ-ын ТХЗ зэрэг үндэсний болон олон улсын тогтвортой хөгжлийн амлалт, тэргүүлэх зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулахад туслах зэрэг юм.

НҮБ-ын Брундландын Хороо “өнөөгийнхөө хэрэгцээ шаардлагыг хангахдаа хойч үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүй байх хөгжил”-ийг “Тогтвортой хөгжил” хэмээн тодорхойлсон байдаг.

Компанийн хувьд тогтвортой байдал гэдэг нь байгууллагын олон талын оролцогчид, түүний дотор ажилтнууд, үйлчлүүлэгчид, эрх ашиг нь хөндөгдөж буй орон нутгийн хэсэг бүлгүүд, хүрээлэн буй орчин зэрэг бүхий л талуудын ашиг сонирхлыг тооцсон эдийн засгийн үнэ цэнийг бий болгохыг хэлнэ. Үүнд ихэвчлэн компаниудын үйл ажиллагаанаас нийгэм болон байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл хамаарах бөгөөд энэ нь тэдний урт хугацааны гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй юм.

Энэхүү удирдамжийг үнэт цаас гаргагчид, тогтвортой байдлын чиглэлээр урт удаан түүхтэй байгууллагууд, гараагаа дөнгөж эхэлж буй компаниуд гээд бүх төрлийн том, жижиг хэмжээний компаниуд ашиглах боломжтой. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын хувьд тогтвортой байдлын дадал үйлийг хэвшүүлэх, жилийн тайлангаа гаргахдаа энэхүү удирдамжийг нэгдсэн журмаар мөрдөх юм. Цаашлаад, хөрөнгийн биржид бүртгэлгүй байгууллагууд (тухайлбал, хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд) тогтвортой байдлын тайлагналын нөхцөл байдалдаа үнэлгээ хийх, асуудлыг олж илрүүлэх, шийдвэрлэхдээ тус удирдамжийг ашиглаж болно.

Зөвхөн энэ удирдамжид туссан мэдээллээр хязгаарлагдахгүйгээр компаниуд илүү дэлгэрэнгүй үзүүлэлтүүд болон цар хугацааг хамруулан тайлагнахыг дэмжих бөгөөд олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын сайн туршлага, стандарт, аргачлалын талаар Хоёрдугаар бүлэгт тоймлон өгүүлсэн болно.

1.3 ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛЫН АШИГ ТУС

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтын дагуу БОНЗ нь байгууллагын үнэ цэн харин тогтвортой байдлыг компанийн гүйцэтгэл болон түүний оролцогч талуудад нөлөөлж болох БОНЗ-ын өргөн хүрээний асуудал хэмээн тодорхойлсон. Тогтвортой байдлыг удирдах, тайлагнах сайн туршлагыг нэвтрүүлсэн компаниуд нь доор дурдсан өргөн хүрээний санхүүгийн эрсдэлүүдийг удирдаж мөн шинэ боломжуудыг нээх давуу талтай.



САНХҮҮГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС:

Хөрөнгө оруулагчдын чиг хандлагад нийцүүлэх: Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа БОНЗ-ын асуудлыг уялдуулж авч үздэг хариуцлагатай хөрөнгө оруулагчдын тоо өсөн нэмэгдэж байна. Эдгээр хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой байдлын тайлан нь тухайн компанийн менежментийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, гүйцэтгэлийг нь урьдчилан тооцоолоход тус болдог аж. Тухайлбал, Монголын банкууд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг³ нэвтрүүлснээр байгууллагаас ирж буй зээлийн хүсэлтийг судлахдаа зарчмууд дээр тулгуурлан байгаль орчин, нийгмийн эрсдэлийг нь үнэлж байна. Түүний адилаар хөрөнгийн зах зээлийн олон хөрөнгө оруулагчид компаниудиа БОНЗ-тай холбоотой эрсдэл, боломжуудаа хэрхэн удирдаж буй талаар мэдээлэл авах болсон⁴.

"БОНЗ" нь хөрөнгө оруулалтын салбарт голчлон "байгууллагын үнэ цэн" гэсэн ойлголтоор өргөн тархсан байдаг. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ)-ын тодорхойлолтоор: "БОНЗ-ын үнэлгээ, зэрэглэл, оноо нь ижил зорилготой бөгөөд компани эсвэл үнэт цаас гаргагчийн БОНЗ-ын эрсдэл болон боломжийн нөлөөллийг үнэлэх тухай юм." "БОНЗ" нэр томъёог зөвхөн байгууллагын үнэ цэн гэдгээр голлон авч үзэж хязгаарлах нь маргаантай хэдий ч хөрөнгө оруулалтын салбарт энэ утгаар нь түлхүү ашигладаг.

"Тогтвортой байдал" нь илүү өргөн хүрээний ойлголт бөгөөд экологийн нөөцийн хязгаарлагдмал байдалд илүү тэгш нийгэм, эдийн засгийг бий болгох системийн өөрчлөлтийг хийх шаардлагатайг онцолдог. Өөрөөр хэлбэл, тогтвортой байдлын талаарх ойлголт нь байгууллагын нийгэм, байгаль орчин, эдийн засагт ("хүмүүн төрөлхтөн, эх дэлхий, хөгжил цэцэглэлт") үзүүлэх нөлөөллийн тухай бөгөөд ингэснээр байгууллагын зүгээс НҮБ-ын ТХЗ гэх мэт олон улсын амлалтуудад хувь нэмэр оруулах боломжтой юм. Энэхүү арга нь Даян Дэлхийн Тогтвортой Байдлын Стандартын Зөвлөл (ДДТБСЗ)-өөс боловсруулсан ТОУС Тогтвортой байдлын тайлагналын стандартад тусгагдсан байдаг. Мөн Европын Холбооны тогтвортой санхүүгийн журамд "байгаль орчин болон нийгмийн зорилтод хувь нэмэр оруулах эдийн засгийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт"-ийг "тогтвортой хөрөнгө оруулалт" гэжээ. Нийгмийн зорилтод нийцсэн гэдэгт тэгш бус байдлыг арилгах, нийгмийн эв нэгдлийг бүрдүүлэх, нийгмийн хүртээмжтэй байдал, хөдөлмөрийн харилцааг дэмжих зэрэг арга хэмжээнүүд орно.

Санхүүгийн хүртээмж: Тогтвортой байдлын үзүүлэлтүүдээ нээлттэй, чанартай мэдээлж нийтэлдэг компаниуд нь хөгжлийн санхүүжилтийн байгууллагууд, ногоон хөрөнгө оруулагчдаас төрөл бүрийн, урт хугацаатай санхүүжилт татах боломжоо нэмэгдүүлж байна. Мэргэшсэн Санхүүгийн Шинжээч (МСШ)-ийн хүрээлэнгийн судалгаагаар судалгаанд оролцогчдын 73 хувь нь хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ хийх болон шийдвэр гаргахдаа БОНЗ-ын асуудлыг авч үздэг хэмээн хариулжээ⁵. Тогтвортой байдлын тайланг гаргаснаар компаниуд БОНЗ-ын эрсдэл, боломжийн үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх бөгөөд тогтвортой, ногоон төслүүдийг санхүүжүүлэх чиглэлээр олон эх үүсвэрээс хөрөнгө татах боломжтой. Цаашлаад компанийн үнэ цэнийг өсгөх, инновацыг хөгжүүлэх, зах зээлд шинэ байр суурь бий болгож өрсөлдөх чадвараа дээшлүүлснээр ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх, компанийнхаа зорилготой нийцүүлсэн удирдлага, менежментийг сайжруулах боломжтой.



ЭРСДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛС:

Эрсдэлийн удирдлага: Тогтвортой байдлын тайлагналыг уламжлалт эрсдэлийн удирдлагын тогтолцооноос илүү өргөн хүрээнд компанийн БОНЗ-тай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх удирдлагын арга хэрэгсэл болгон ашиглаж болно⁶. БОНЗ-ын асуудлыг сайтар тусгасан эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагыг хэрэгтэй мэдээллээр хангахын зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, зах зээлд шинээр гарч болзошгүй стандарт дүрэм, технологийн

өөрчлөлт гэх зэрэг мега чиг хандлагаас үүдэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, улмаар эдгээр эрсдэлийг шийдвэрлэх, цаг хугацааны туршид гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн дотоод үүрэг хариуцлага, тогтолцоог хөгжүүлэхэд тусална. Нөгөөтээгүүр, БОНЗ-ын асуудлыг үнэлэхдээ хайхрамжгүй хандах аваас компанийн нэр хүндэд эрсдэл учирч, улмаар санхүүжилт авах чадварт нь муу үр дагавар авчрах магадлалтай. Иймээс тогтвортой байдалтай холбоотой асуудлууд нь үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага, болзошгүй өр төлбөр, түүний үнэ цэнд ихээхэн нөлөөлнө⁷.

Хууль тогтоомжийн нийцэл: Улс орнуудын засгийн газрууд БОНЗ-ын талаарх мэдээллийн эрэлт хэрэгцээг хангахын тулд компанийн тогтвортой байдлыг ил тод тайлагнах журмыг нэвтрүүлэх арга хэмжээ авч байна⁸. Олон улсын энэхүү чиг хандлагатай нийцүүлэн БОНЗ-ын асуудлыг багтаасан Үнэт цаас гаргагчдаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын төслийг боловсруулаад байна. Түүнчлэн МХБ нь үйл ажиллагаагаа ТХЗ-ын зорилтуудад нийцүүлэн явуулж буй компаниудыг талархалтайгаар дэмжин, эдгээр компаниудад захиргааны хэд хэдэн хөнгөлөлт үзүүлж байна. Тогтвортой байдлын тайлагналын дадлыг бий болгох замаар компаниудад тайлагналын дагаж мөрдөх шаардлагуудыг шийдвэрлэх, санхүүгийн мэдээллийг ил тод болгох, холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд гарах эрсдэлийг бууруулах, зохицуулалтын шинэ өөрчлөлт хийхээс урьтах, зохицуулалтын урамшуулал, үр өгөөжийг хүртэхэд нь туслах юм.



БОЛОМЖТОЙ ХОЛБОГДОХ ХҮЧИН ЗҮЙЛС

Брэндээ бий болгох, харилцагчаа нэмэх: Тогтвортой байдлын гүйцэтгэлийн тайлан гаргадаг компаниуд нь компанийн ёс зүйн стандарт, хууль журам, түүнчлэн олон улсын болон үндэсний хэмжээний тогтвортой хөгжлийн зорилтуудыг дагаж мөрдөж байгаагийн тод илэрхийлэл юм. Ингэснээрээ оролцогч талуудын итгэлийг төрүүлж, яриа хэлцлийг өрнүүлж компанийнхаа ч нэр хүндийг өсгөж байна. Дэлхийн өнцөг булан бүрд оршин суугаа хэрэглэгчдийн хувьд тогтвортой хөгжлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх хүсэл эрмэлзэл нь улам бүр нэмэгдсээр байна. Жишээ нь судалгаанд оролцсон хэрэглэгчдийн 70 хувь нь хэдийгээр илүү үнэтэй байсан ч байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдаж авсан, 66 хувь нь байгаль орчинд ээлгүй байсан учир тодорхой зарим бүтээгдэхүүн, брэндээс татгалзсан гэж хариулжээ⁹.

Зах зээлийн шинэ боломж, сайн нөөцийн хэмнэлт: Хаана асуудал гарч байна тэнд бас боломж ч байх нь гарцаагүй. Тогтвортой байдалд тулгарч буй сорилтууд нь компаниудад шинэ зах зээл, хэрэглэгчдийн шинэ эрэлт хэрэгцээг нээж, бизнесийг хөгжүүлэх шинэлэг боломжуудыг ч төрүүлдэг. Манлайлагч компаниуд тогтвортой байдлын чиг хандлагыг алдахгүй дагахын

тулд бизнесийн багцаа шинэчилж байна¹⁰. Мөн компаниуд ус, эрчим хүчний хэрэглээгээ бууруулснаар зардлаа хэмнэх боломжыг эрэлхийлж байна. Ингэснээр тэд БОНЗ-ын асуудлууд, нөлөөллийг шинэ зах зээл, орлогоо нэмэгдүүлэх боломж болгон хувиргах арга замыг нээн илрүүлэхийн зэрэгцээ нийгэмд илүү үнэ цэнийг бий болгож байна.

Хүсэл эрмэлзэлтэй ажиллах хүч: Тогтвортой байдлын тайланг гаргахад компаниудын нийт ажилтны нэгдмэл хүчин чармайлт шаардагдах учир компанийнхаа тогтвортой хөгжлийн төлөөх зорилтуудыг нийт ажилтнууддаа сайтар ойлгуулсан байх нь чухал. Байгаль орчны нөлөөлөл болон ажилтнуудын сэтгэл ханамжийн хооронд мэдэгдэхүйц эерэг хамаарал байгааг зарим судалгаа нотолсон байна¹¹. Ажиллаж байгаа компанийнх нь үйл ажиллагаа байгаль орчин, нийгэмд ээлтэй болохыг мэдрэх тусам ажилтнуудын урам зориг, эрч хүч сэргэж, компанийнхаа төлөө илүү хүсэл эрмэлзэлтэй ажилладаг болох нь нотлогдож байна.

Мэдээллийн урсгалыг сайжруулах: Ил тод байдал, тайлагналыг сайжруулснаар компанийн богино, дунд, урт хугацаанд бүтээх үнэ цэнийн талаар мэдээллийг гол оролцогч талуудад хүргэх ба энэ нь тэдний шийдвэр гаргалтад тус болдог. Мөн удирдах зөвлөл болон удирдлагын баг хоорондын мэдээллийн урсгалыг сайжруулдаг.

БОНЗ-ын нэгдсэн тайлан нь **хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудад** тухайн компанийн нөхцөл байдлыг тодорхойлох, стратеги, гүйцэтгэлийн талаар илүү өргөн хүрээтэй ойлголттой болоход нь туслах төдийгүй тухайн бизнесийн загварын (Тайлагналын төрлүүдийг Хүснэгт 5. Нийтлэг ашиглагддаг тайлагналын загвараас үзнэ үү.) урт хугацааны оршин тогтнох чадварт итгэх итгэлийг нь ч төрүүлнэ. Ажилтнуудын тогтвор суурьшил, бүтээгдэхүүний чанар зэрэг зарим санхүүгийн бус гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ч санхүүжилтийн өмнөх буюу урт хугацааны санхүүжилтийн гүйцэтгэлийн чухал үзүүлэлт хэмээн үзэх боломжтой юм.

БОНЗ-ын тайланг гаргаснаар бусад оролцогч талууд болон хөрөнгө оруулагчдад тухайн компани цаг хугацааны явцад үнэ цэнийг хэрхэн бүтээж байгаа, энэ нь нийгэмд эерэг хувь нэмэр оруулж байгаа эсэхийг үнэлэхэд нь тусалж чадна. Ялангуяа нөлөөллийн хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж байгаа энэ үед нийгэмд эерэг хувь нэмэр оруулах гэдэг нь маш чухал хүчин зүйл бөгөөд тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийг бий болгох нийгэм, эдийн засгийн хөгжилд аж ахуйн нэгжүүдийн оролцоо маш чухал гэсэн үзэл нэмэгдсээр байна. Тогтвортой байдлын тайлагналаас компанийн эдийн засаг, санхүүгийн гүйцэтгэлээр зогсохгүй хүний нөөц, харилцаа холбоо, байгалийн баялгийг сүйтгэж, аль эсвэл хамгаалж байгаа эсэх, цаашлаад нийгмийн аж байдалд ямар нөлөө үзүүлж байгаа зэрэг компанийн үйл ажиллагааг цогцоор нь илэрхийлэх мэдээллийг авч болно.

2

ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН АРГАЧЛАЛ, СТАНДАРТУУД БА НИЙЦЭЛ



Олон улсын туршлагаас харахад бизнесийнхээ бүхий л чухал асуудлыг удирдах, тайлагнахдаа БОНЗ-ын асуудлуудыг орхигдуулахгүй байхыг зорьдог болсон. Гэвч Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-тай дүйцэхүйц БОНЗ-ын тайланг гаргахад ашиглах нэгдсэн стандарт хараахан гараагүй байна (Хүснэгт 1-ээс стандартын тайлбарыг харна уу). БОНЗ-ын тайлангийн олон төрлийн стандарт, хэм хэмжээ байгаа хэдий ч БОНЗ-ын хүрээ хурдацтай хувьсан өөрчлөгдөхийн хэрээр бэрхшээл үүсэж байна. БОНЗ-ын асуудал нь зарим оролцогч талууд болон салбарт ихээхэн нөлөө үзүүлдэг учир ихээхэн хамааралтай байж болох ч заримд нь хамааралгүй эсвэл бүр нөлөөлөхгүй буюу ач холбогдлын хувь хэмжээ нь харилцан адилгүй байж болно. Гэсэн хэдий ч чиглэл чиглэлийн оролцогч талууд хамтран энэ төрлийн стандартыг оновчтой болгох, нийцүүлэх зорилгоор хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид, зохицуулагчид болон зах зээлийн бусад оролцогчдын цуглуулан хэлэлцүүлэг өрнүүлж буй нь сайшаалтай.

Олон улсад хэрэглэгдэж буй аргачлал,










стандартууд нь оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээг хангах үүднээс ашиг тустай, цогц, ил тод мэдээлэл гаргахад компаниудад туслах гол хэрэгсэл болж байна. Тайлагналын бүх аргачлал, стандартууд тогтсон нэг ижил үр дүнд хүрэхийг эрэлхийлдэггүй бөгөөд тайлан гаргаж байгаа янз бүрийн байгууллагууд ч мөн л өөрийн онцлог зорилготой байдаг. Иймээс компаниуд тайлагналын аргачлал, стандартыг сонгохдоо дараах асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд, тайлан гаргаж буй байгууллагын төрөл, тайлан гаргаж буй байгууллагын зорилго, өөрийн зах зээл буюу салбарын тайлан гаргахад тавигдах шаардлага, компанийн оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээ болон мэдээлэл харилцааны сонголт зэргийг анхаарах нь чухал.

Өнөөдрийг хүртэл түгээмэл хэрэглэгдэж буй олон улсын тайлагналын аргачлал, стандартуудын талаарх ерөнхий тоймыг энэ бүлэгт танилцуулахыг зорилоо. Тухайлбал, компаниуд тайлан бэлтгэхдээ **ОУСК-ийн Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах**¹ зэрэг олон улсын байгууллагуудын санал болгож туршлагаа суралцах боломжтой². Доорх хүснэгтэд олон улсын тайлагналын төрөл бүрийн аргачлал, стандартуудыг тоймлон үзүүлээ.

¹ ОУСК-ийн Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нээлттэй болгож, ил тод байдлыг сайжруулахад зориулсан шинэлэг арга зүйн хэрэгслүүдийн хамгийн сүүлийн хувилбар юм. Үүний гол зорилго нь хөрөнгө оруулагчдын үнэн зөв мэдээлэл авах хэрэгцээг хангахад оршино. Уг гарын авлагыг хөгжиж буй зах зээлд оруулж буй ОУСК-ийн хөрөнгө оруулалтын туршлага дээр үндэслэн байгаль орчин, нийгэм, засаглалын хэрэгжилтийн үнэлгээг иж бүрэн, шинэлэг, нэгдсэн арга барил боловсруулсан болно. Гарын авлагын дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор авна уу: https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/ifc+cg/resources/toolkits+and+manuals/beyond+the+balance+sheet+ifc+toolkit+for+disclosure+and+transparency





² Санхүүгийн бус болон БОНЗ-ын мэдээллийн үнэн зөв, ил тод байдал, чанарыг хангах, баталгаажуулахад нь компаниудад туслах зорилгоор ОУСК-аас тайлагналын заавар удирдамжийг арга зүйн гарын авлага болон цахим сургалтын модуль хэлбэрээр гаргасан. ОУСК-ийн тайлагналын удирдамжид нөлөөллийн асуудлуудыг хэрхэн тодорхойлох, үнэлэх, эдгээр нөлөөллийн мэдээллийг нээлттэй болгох, эрэмбэлэхдээ хэрхэн ашиглах талаарх асуудлыг мөн хамруулсан болно.

Хүснэгт 1. Олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тайлагналын аргачлал, стандартууд

Удирдамж/Аргачлал	Зорилго	Давуу тал	Сул тал	Ашигтай тал
Өргөн хүрээг хамарсан аргачлал				
НҮБ-ЫН ДАЯН ДЭЛХИЙН ГЭРЭЭ 	НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10 зарчмыг баримталснаар тогтвортой байдлын гүйцэтгэл, явцаа жил бүр тайлагнах үүрэг хүлээдэг.	Байгаль орчин, нийгэм, хүний эрхийн асуудлыг хамруулна.	Зарчимд суурилсан учир гүйцэтгэлийг хэмжих, харьцуулалт хийх тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг зөвлөмж болгодоггүй.	Өргөн хүрээг хамарсан олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх хариуцлагыг бий болгох. Хөгжиж буй зах зээл болон жижиг компаниудад тохиромжтой асуудлыг хамарсан, уян хатан аргачлал.
СТАНДАРТЧИЛЛЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА 	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг дээд зэргээр нэмэгдүүлэх. Нийгмийн хариуцлагын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн гадаад харилцааг өргөжүүлэх.	Нийгмийн хариуцлагын үндсэн асуудлууд. Байгууллагын хэмжээнд нийгмийн хариуцлагын нэгдсэн бодлого баримтлах.	Тайлагналын талаарх удирдамж заавар хязгаарлагдмал.	Тайлан гарагчдад олон улсын сайн туршлагыг дагуу тайлагнахад уян хатан нөхцөлөөр хангадаг. Хөгжиж буй зах зээлд тохиромжтой, уян хатан аргачлал
ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН САНААЧИЛГА 	Байгууллагын тогтвортой байдлыг сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих. Удирдамжийг оролцогч талуудын оролцоотойгоор боловсруулах.	Нийт компаниудын эдийн засаг, нийгэм, байгаль орчны талаарх мэдээллийг ил тод болгоход чиглэсэн тайлангийн стандартууд. Тодорхой салбаруудын мэдээллийг ил тод болгоход чиглэсэн нэмэлт удирдамжуудтай.	Тогтвортой байдлын тайланг дангаар нь гаргахад голчлон ашигладаг.	Тогтвортой байдлын буюу санхүүгийн бус удирдлагын өргөн хүрээний асуудлыг маш олон төрлийн оролцогч талуудад сурталчлах. Хөгжиж буй зах зээлд тохиромжтой асуудлуудыг хамарсан.
НЭГДСЭН ТАЙЛАГНАЛ³ 	Компаниудад урт хугацааны цогц сэтгэлгээг нэмэгдүүлэх, санхүүгийн хөрөнгийн хуваарилалтыг сайжруулах. Тайланг бүх оролцогч талуудад зориулан гаргадаг хэдий ч хөрөнгө оруулагчдад эн тэрүүнд шаардлагатай.	Үндсэн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн асуудлыг тусгаж, дотоод өөрчлөлтийг хийхэд туслах зорилготой.	Зарчимд суурилсан тайлагналын тогтолцоо нь гүйцэтгэлийн гол гол шалгуур үзүүлэлтүүдийг (KPIs) зөвлөмж болгодоггүй	Үнэ цэнийг бий болгох үйл явцын талаар тайлагнаж, тогтвортой байдлын асуудлыг хэрхэн стратегийн дагуу удирдаж байгааг тайлбарлах. Хөгжиж буй зах зээлд тохиромжтой.
Зорилтот аргачлал - Тодорхой асуудлын хүрээнд зорилтот бүлэгт зориулсан				
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 	Нягтлан бодох бүртгэлийн стандарт нь компанийн санхүүгийн тайланг олон улсын хэмжээнд ойлгомжтой, зэрэгцүүлэхүйц байхаар сайжруулах, тайлан гаргагчдад санхүүгийн гүйцэтгэл, байр сууриа бодитой илэрхийлэхэд нь туслах.	Хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн гүйцэтгэлийн олон улсын стандарт.	Биет бус болон санхүүгийн бус гүйцэтгэлийн тайлагналд хязгаарлагдмал хэрэглэгддэг.	Санхүүгийн мэдээллийн нээлттэй, зэрэгцүүлэхүйц байх, итгэлцэл, ил тод байдлыг дэмжих.
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СТАНДАРТЫН ЗӨВЛӨЛ⁴ 	Тогтвортой байдлын мэдээлэл дээр суурилсан шийдвэрийг дэмжих. Зорилтот бүлэг нь хөрөнгө оруулагчид юм.	Салбар, дэд салбараар тусгайлан бэлтгэсэн. Санхүүгийн тайланд тусгалаа бүрэн олсон.	Үндсэндээ АНУ-д бүртгэлтэй компаниудад зориулан боловсруулагдсан. Тогтвортой байдлын талаарх мэдээлэл болон санхүүгийн зохицуулалтын асуудлыг уялдуулсан; Тайлангийн загвар ашиглахад хялбар бус.	Хөрөнгө оруулагчдад тогтвортой байдлын удирдлага, гүйцэтгэлийг тайлбарлах. АНУ-д бүртгэлтэй компаниудад зориулагдсан.
НҮБ-ЫН ТАЙЛАГНАЛЫН УДИРДАХ ЗАРЧМУУД / АРГАЧЛАЛ 	НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн удирдах зарчмуудыг нэвтрүүлэх, хүний эрхийн талаарх гүйцэтгэлийн ил тод байдлыг сайжруулах	Хөндөгдөж буй хүний эрхийн асуудлын засаглал, удирдлагын арга хандлагад анхаарлаа хандуулсан. Бусад удирдамжууд, арга зүйн хүрээтэй хамтад нь ашиглах боломжтой.	Үйл явцад түлхүү анхаарсан. Чанарын үзүүлэлт ашигладаг.	Хүний эрхийн удирдлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн удирдах зарчмуудыг нэвтрүүлэх. Хөгжиж буй зах зээлд тохиромжтой асуудлуудыг хамарсан.

³ Нэгдсэн тайлагнал нь 2022 оны 6-р сард Олон улсын тогтвортой байдлын стандартын хороо (ОУТБСХ)-нд нэгдэхээр болсон.

⁴ Нэгдсэн тайлагналтай адилаар ТБНББСЗ нь 2022 оны 6-р сард ОУТБСХ-нд нэгдэхээр байна.

Удирдамж/Аргачлал	Зорилго	Давуу тал	Сул тал	Ашигтай тал
<p>НҮҮРСТӨРӨГЧ ЯЛГАРУУЛАЛТЫГ ИЛ ТОД ТАЙЛАГНАХ ТӨСӨЛ⁵</p> 	Институцийн хөрөнгө оруулагчдын нэрийн өмнөөс дэлхийн томоохон хөрөнгийн биржид бүртгэлтэй зарим компаниудад жил бүр асуулга илгээх замаар уур амьсгалын өөрчлөлт, ус, ойн асуудлаарх стандартчилсан мэдээллийг цуглуулдаг.	Байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол үзүүлэлтүүдийн талаар харьцуулж болохуйц болон нэгдсэн мэдээллээр хангана.	Жилийн тайланд тусгагдаагүй, тусгайлсан тодруулга тайлан. Нарийн төвөгтэй, олон талт цогц учир том хэмжээний компаниудаар хязгаарлагддаг	Тусгайлан хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл. Уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг салбарууд болон/эсвэл уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар заавал мэдээлэх үүрэг хүлээсэн салбарууд. Томоохон болон бүртгэлтэй компаниудад хамааралтай.
<p>УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД СТАНДАРТЫН ЗӨВЛӨЛ</p> 	Стратеги, гүйцэтгэл, хэтийн төлөвт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж буй талаар хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх. Санхүүгийн тайланд ашиглахад зориулагдсан.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаарх тодруулга, хавсралт мэдээлэл, санхүүгийн тайланг хөрөнгө оруулагчдад зориулан бэлтгэх.	Тайлангийн загвар хөрөнгө оруулагчдаас бусад оролцогч талуудад ашиглахад хялбар бус байх магадлалтай.	Томоохон болон бүртгэлтэй компаниуд нэгдсэн тайлан гаргах. Уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг салбарууд болон/эсвэл уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар заавал мэдээлэх үүрэг хүлээсэн салбарууд.
<p>УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САНХҮҮЖИЛТИЙГ НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХЭСЭГ</p> 	Сайн дурын үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэж болзошгүй санхүүгийн эрсдэлийн талаарх мэдээллийг боловсруулах, тэдгээрийг компаниуд ашиглан оролцогч талуудад мэдээлэл өгөх.	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн засаглал, стратеги, эрсдэл, гүйцэтгэлд учрах эрсдэлийн талаар иж бүрэн, нэгдсэн мэдээллийг боловсруулах. Үүнд төлөвлөлтийн хувилбарууд, салбарын онцлогт тохирох шалгуур үзүүлэлтүүд мөн хамаарна.	Нарийн төвөгтэй, олон талт байдал нь том хэмжээний компаниудын хэрэглээгээр хязгаарлагдах магадлалтай.	Томоохон болон бүртгэлтэй компаниуд нэгдсэн тайлан гаргах. Уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг салбарууд болон/буюу уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар заавал мэдээлэх үүрэг хүлээсэн салбарууд.
<p>БАЙГАЛЬ ОРЧИНТОЙ ХОЛБОГДОХ САНХҮҮЖИЛТИЙГ НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХЭСЭГ</p> 	Компаниудад байгаль орчинтой холбоотой эрсдэлийн талаар мэдээлэх, арга хэмжээ авах эрсдэлийн удирдлага, ил тод байдлын тогтолцоог бий болгох.	БОТСМАТАХ тогтолцооны анхны бета хувилбар нь байгаль орчны доройтлын эрсдэлтэй тэмцэх, эрсдэл, боломжийн шинжилгээг корпорацын болон санхүүгийн шийдвэр гаргах түвшинд оруулахад төвлөрч буйн хувьд зах зээлд чухал алхам болж байна.	Нарийн төвөгтэй, олон талт байдал нь том хэмжээний компаниудын хэрэглээгээр хязгаарлагдах магадлалтай.	G7-ийн Сангийн сайд нар болон G20-ийн Тогтвортой санхүүжилтийн замын зурагт нь БОТСМАТАХ-ийг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн билээ.

Эх сурвалж: Стандарт бүрийн холбогдох вебсайт болон ОУСК-ийн Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлагаас нэгтгэн бэлтгэв.

Ерөнхий зарчмын хувьд компанийн жилийн тайланд зөвхөн материаллаг буюу тухайн компанид хамгийн их нөлөөтэй асуудлыг тусгах ёстой. Санхүүгийн нөлөөлөл ихтэй мэдээлэл нь хөрөнгө оруулагчдад компанийн талаар үндэслэлтэй шийдвэр гаргахад нь туслах мэдээлэл болдог. Харин тогтвортой байдлын хүрээнд энэ нь байгууллагын стратеги, засаглал, гүйцэтгэл болон оролцогч талуудад бодитойгоор нөлөөлж буй буюу нөлөөлөх боломжтой БОНЗ-ын асуудлуудтай холбогдоно. БОНЗ-ын асуудал нь тухайн байгууллагын хувьд хэр нөлөөтэй болох нь чухамдаа түүний оролцогч талууд болон үйлдвэрлэлийн салбар зэргээс хамаарна.

Компаниудад тайлагналын аргачлал, стандартуудаас сонголт хийхэд нь тус болох нэмэлт мэдээллийг дараах хүснэгтэд үзүүллээ. Тухайлбал,

⁵ УАӨМСЗ нь 2022 оны 2-р сард ОУТБСХ-нд нэгдсэн.

Хүснэгт 2. Тайлагналын аргачлал, стандартуудын харьцуулалт: Оролцогч талууд болон Тайлагналын зорилго

	ОУСК-ын Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)	Тайлагналын олон улсын санаачилга (ТОУС)	Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)	Үнэ цэнийн тайлагналын сан (ҮЦТС) ОУНТЗ-ийн Нэгдсэн Тайлагналын арга зүйн хүрээ ⁶	Үнэ цэнийн тайлагналын сан (ҮЦТС) ТБНББСЗ-ын стандартууд	Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсэг (УАӨСМТАХ)
Тайлагналын аргачлал, стандартын үндсэн зорилго юу вэ?	Эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд нэмэлт хөрөнгө оруулагч болон хөрөнгө татах зорилгоор компаниуд хөгжиж буй зах зээлд эрсдэлээ хэрхэн удирдах, боломжуудыг хэрхэн эрэлхийлэх тухай ойлголтыг сайжруулах.	Хөрөнгө оруулагчдыг чанартай, ил тод, зэрэгцүүлэхүйц мэдээллээр хангах, олон улсын хөрөнгийн зах зээлд нийтлэг аргачлалтай санхүүгийн тайлагналын тогтолцоог бий болгох, санхүүгийн ил тод тайлагналыг хэвшүүлэх замаар хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих, тогтсон стандартыг тууштай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Хэмжээ, салбар, байршлаас үл хамааран бүх төрлийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар тайлагнах боломж олгох.	Аж ахуйн нэгж, байгууллагууд нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах талаар заавар өгөх	Олон төрлийн хөрөнгө нөөцийг тооцсон нэгдмэл, урт хугацааны, цогц хандлагатай сэтгэлгээг хөгжүүлж, санхүүгийн хөрөнгийн хуваарилалтыг сайжруулах.	Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй урт хугацааны үнэ цэнд учруулж болзошгүй тогтвортой хөгжлийн нөлөөллийн талаарх бүрэн мэдээллийг хөрөнгө оруулагчдад өгөх.	Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавраас үүсэж болзошгүй эрсдэл, боломжийг сайтар тооцоолж, санхүүгийн үнэлгээг хийхдээ ашиглах хэрэгцээт хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид болон даатгалын андеррайтеруудад тодорхойлж өгч туслах.
Тайлагналын аргачлал, стандартыг хэнд зориулсан бэ?	Нийт оролцогч талууд, ялангуяа хөгжиж буй зах зээлийг сонирхож буй хөрөнгө оруулагчид	Хөрөнгө оруулагчид	Олон талт оролцоо	Олон талт оролцоо	Нийт оролцогч талуудыг дэмжих, гэхдээ хөрөнгө оруулагчдад тэргүүлэх ач холбогдол өгөх	Үндсэндээ хөрөнгө оруулагчид	хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид болон даатгалын андеррайтеруудад
Ямар мэдээллийг авч үзэх?	Нийт оролцогч талууд, ялангуяа хөгжиж буй зах зээлийг сонирхож буй хөрөнгө оруулагчид	Тайланд нөлөөллийн мэдээллийг орхигдуулсан буюу буруу тайлагнасан, мөн ийм мэдээлэлд үндэслэж тухайн аж ахуйн нэгж санхүүгийн шийдвэр гаргасан тохиолдолд нөлөөллийн мэдээллүүд	Дараах асуудлуудыг: <ul style="list-style-type: none"> Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд ихээхэн нөлөө үзүүлэх Оролцогч талын шийдвэрт нөлөөлөх үзүүлэлтүүд 	Байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны нөлөөлөл болон оролцогч талуудад үзүүлэх нөлөө зэрэгт хийсэн үнэлгээндээ тулгуурлаж гаргасан гол чухал асуудлын жагсаалтаас холбогдох сэдвийг сонгох.	Богино, дунд, урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход ихээхэн нөлөөлдөг асуудлууд	Салбараар ялгаатай	Хөрөнгө оруулалт, зээл олгох, даатгалын андеррайтерийн шийдвэр гаргахад дэмжлэг болох судалгаа сайтай мэдээлэл нь эргээд оролцогч талуудад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлд системтэйгээр өртөж байгааг ойлгох боломж олгох мэдээллүүд.

Эх сурвалж: ОУСК. Тайлан баланс болон нэмэлт үзүүлэлтүүд: Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах

Компанийн талаар үндэслэлтэй шийдвэр гаргахад нь хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад туслах бас нэг чухал хүчин зүйл бол БОНЗ-ын талаарх чанартай тоо мэдээлэл юм. Хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудыг илүү чанартай мэдээллээр хангахын тулд зах зээлийн зохицуулагч байгууллагуудаас компаниудад хандаж компанийнхаа БОНЗ-ын асуудлыг ил тод тайлагнахыг уриалах хэрэгтэй. БОНЗ-ын аргачлал, стандартууд нь байгууллагуудын тайландаа тусгавал зохих тоо мэдээллийн хамрах хүрээ, чанарын талаар (жишээ, жилийн тайлангийн агуулга, байгаль орчин, нийгэм, компанийн засаглалын асуудлыг нээлттэй мэдээлэх зэрэг) чиглүүлж өгсөн удирдамж заавар болно.

⁶ Олон улсын нэгдсэн тайлагналын зөвлөл (ОУНТЗ) болон ТБНББСЗ нь 2021 оны 6-р сард нэгдэж, Үнэ цэнийн тайлагналын Сан (ҮЦТС)-г байгуулснаа албан ёсоор зөрлөсөн. Үнэ цэнийн тайлагналын сан нь бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргах үйл явцыг Цогц сэтгэлгээний зарчим, Нэгдсэн тайлагналын аргачлал, ТБНББСЗ стандарт гэсэн гурван үндсэн эх сурвалжийг үндэслэн дэмждэг.

Хүснэгт 3. Тайлагналын аргачлал, стандартуудын харьцуулалт: Бүрэн болон үнэн зөв байдал

	ОУСК. Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах	Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт	Тайлагналын олон улсын санаачилга	Стандартчиллын олон улсын байгууллага	Үнэ цэнийн тайлагналын сан ОУНТЗ-ийн нэгдсэн тайлагналын аргачлал	Үнэ цэнийн тайлагналын сан ТБНББСЗ-ийн стандартууд	Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсэг
Үйл ажиллагаа, үйл явцтай холбоотой асуудлыг тайлагнах							
Үйл ажиллагаа явуулах буюу гадаад орчин	✓		✗	✗	✓		✗
Бизнесийн загвар	✓		✗	✗	✓		✗
Оролцогч талуудын оролцоо	✓		✓ (тогтвортой байдалтай холбоотой)	✓ (компанийн хариуцлагатай холбоотой)	✓		✗
Стратеги, стратегийн зорилгууд	✓		✓ (тогтвортой байдлыг стратеги, зорилгуудтай холбоотой)	✓ (компанийн хариуцлагатай холбоотой)	✓		✓ (зөвхөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлээс үүсэх санхүүгийн нөлөөлөлтэй холбоотой)
Эрсдэлийн үнэлгээ, шийдвэрлэх арга замууд	✓		✓ (тогтвортой байдлын эрсдэлтэй холбоотой)	✓ (компанийн хариуцлагатай холбоотой)	✓		✓ (зөвхөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлээс үүсэх санхүүгийн нөлөөлөлтэй холбоотой)
Засаглал	✓					✗	✓
Гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг тайлагнах							
Санхүүгийн гүйцэтгэл/ Ашигт ажиллагаа/ Санхүүгийн үнэ цэнийг бий болгох		✓		✗	✓	Санхүүгийн тайлангийн ХҮРЭЭНД нээлттэй болгох.	Санхүүгийн тайлангийн ХҮРЭЭНД нээлттэй болгох
Нийгмийн нөлөө/ хүний нөөц/ нийгмийн үнэ цэнийг бий болгох	✓	✗		✓	✓	Салбараас хамаарна	✗ (байгаль орчин орчин санхүүгийн нөлөөллөөс үүдсэн нийгмийн нөлөөлөл хамаарахгүй)
Байгаль орчны нөлөөлөл/ байгалийн нөөц/байгаль орчны үнэ цэнэ бий болгох	✓		✓	✓	✓	Салбараас хамаарна	✓ (байгаль орчны нөлөөлөл санхүүгийн гүйцэтгэлтэй хэр холбогдож байгаа тэр хэмжээгээр тусгагдсан)

Эх сурвалж: ОУСК. Тайлан баланс болон нэмэлт үзүүлэлтүүд: Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах

Зөвхөн нэг стандартыг мөрдлөг болгохгүй байхын зэрэгцээ зөвхөн нэг оролцогч бүлэгт төвлөрч тайлагнахгүй байх олон улсын туршлагауд улам бүр нэмэгдэх болсон. БОНЗ-ын асуудлыг тайлагнах санаачилга, байнгын шинэчлэгдэж буй чиг хандлага нь санхүүгийн бус буюу БОНЗ-ын мэдээллийг гуравдагч талуудаар баталгаажуулах хандлага руу шилжиж буйг онцлох хэрэгтэй. Европын холбоо болон Франц, Итали, Испани зэрэг улсууд заавал баталгаажуулах горимыг мөрдөж эхэлсэн бөгөөд цаашид баталгаажуулалт хийлгэх нь улам бүр түгээмэл болж, улмаар ирэх жилүүдэд заавал мөрдөх шаардлага ч болох хандлагатай байна.

Хэтийн төлөв

Олон улсын хэмжээнд хэрэглэгдэж буй тайлагналын стандартуудыг өөр хооронд нь сайтар уялдуулан нийцүүлэх, оновчтой болгох чиглэлээр олон санаачилга гарч байна. Тогтвортой байдлын тайлагналын олон улсын стандартуудыг олон талаас нь судалж талууд хамтран боловсруулж, нэвтрүүлэх замаар ийм ажлыг тууштай хэрэгжүүлэх боломжтой.

Хамтран боловсруулах гэдэг нь харилцан ялгаа бүхий аргачлалуудыг өөр хооронд нь уялдуулан нийцүүлэх, нөхөж орлуулах зэргээр хамтран ажиллах арга хэлбэр юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр илүү цогц өргөн хүрээг хамарсан, уялдаа холбоотой стандартуудыг мөрдөх нь тайлан гаргаж байгаа байгууллагууд, тайланг хэрэглэгчдийн аль алинд нь тун чухал болж байна.

Эдгээр санаачилгууд нь тайлагналын хэтийн төлөвийг мэдээлж буй бөгөөд 1) хувьсан өөрчлөгдөж буй тайлагналын шаардлага бий болохоос өмнө урьтаж эхлэх болон 2) манлайлал үзүүлэх зэрэг цаашид анхаарах чухал асуудлуудыг онцолсон байна.

Үндсэн хоёр санаачилга хэрэгжиж байна. Үүнд:

СТОУС Сан нь олон улсын тогтвортой байдлын тайлагналын боломжит стандартыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгийн эхний ажил нь хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгчдийн байр сууринаас санхүүгийн нөлөөллийг ашиглан байгаль орчны асуудал, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тодорхойлоход чиглэж байна. Энэ ажилд ТОУС, ОУНТЗ, ТБНББСЗ, НЯМТ, УАӨМСЗ, УАӨСМТАХ зэрэг стандартуудыг суурь болгон ашиглаж буйгаар онцлогтой. СТОУС Санаачилга нь БОНЗ-ын бусад асуудлууд болон тогтвортой хөгжлийн нөлөөллийг илүү өргөн хүрээнд хамруулах урт хугацааны зорилт тавьж байна.

- 2020 оны 9-р сард тогтвортой байдал, уур амьсгалтай холбоотой ил тод байдлын талаарх сайн дурын үндсэн болон стандарт тогтоогч таван тэргүүлэх байгууллага болох НЯМТ, УАӨМСЗ, ТОУС, ОУНТЗ, ТБНББСЗ анх удаа хамтарсан алсын хараатай ажиллахаар үүрэг хүлээв.
- 2020 онд Олон улсын нягтлан бодогчдын холбоо (ОУНБХ) нь СТОУС Сангийн ивээл дор Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (ОУНББСЗ)-тэй зэрэгцэн ажиллах Олон улсын Тогтвортой байдлын стандартын зөвлөл (ОУТБСЗ) байгуулахыг уриалав.
- 2021 оны эхээр ОУНТЗ болон ТБНББСЗ хамтран Үнэ цэнийн тайлагналын сан (ҮЦТС)-г байгуулан, 2021 оны 11-р сард ҮЦТС болон УАӨМСЗ нь СТОУС Сантай нэгдэх хүсэлтэй байгаагаа зарлаж, ОУНББСЗ болон ОУТБСХ нөөц бололцоогоо нэгтгэн ажиллахаа мэдэгдэв.

2021 оны 11-р сард болсон COP26-д СТОУС Сан нь дэлхийн санхүүгийн зах зээлд уур амьсгал болон бусад тогтвортой байдлын асуудлаар өндөр чанартай мэдээлэл өгөх гурван чухал хөгжлийн чиглэлийг зарлав.

- Олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн, хөрөнгө оруулагчдын мэдээллийн хэрэгцээг хангах үүднээс тогтвортой байдлын талаарх мэдээллийг ил тод болгох стандартуудын иж бүрэн үндэс суурийг бий болгох зорилгоор ОУТБСЗ-ийг шинээр байгуулах;

- Хөрөнгө оруулагчдад чиглэсэн тогтвортой байдлын мэдээллээ ил тод байлгадаг манлайлагч байгууллагууд шинээр Зөвлөл байгуулан нэгдэх амлалт. СТОУС Сан нь [Уур амьсгалын ил тод байдлын стандартын зөвлөл](#) (УАӨМСЗ—НЯМТ-ийн санаачилга) болон [Үнэ цэнийн тайлангийн сан](#) (ҮЦТС—Нэгдсэн тайлагналын хүрээ ба ТБНБСЗ стандартыг агуулсан)-г 2022 оны 6-р сар гэхэд нэгтгэж дуусгах;
- СТОУС Сангийн Итгэмжлэгчдийн байгуулсан [Техникийн Бэлэн байдлын Ажлын хэсэг](#) (ТББАХ)-ийн боловсруулсан уур амьсгал, ил тод байдлын талаарх ерөнхий шаардлагуудын загварыг нийтлэх.
- 2022 оны 3-р сард ОУТБСХ нь санхүүгийн оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тогтвортой байдлын талаарх глобал цогц суурийг бий болгох хоёр саналыг олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр гаргасан. Нэг нь [тогтвортой байдалтай холбоотой ил тод байдлын ерөнхий шаардлагууд](#), нөгөө нь [уур амьсгалтай холбоотой ил тод байдлын шаардлагууд](#) юм. Мөн 2022 оны 6-р сар гэхэд Үнэ цэнийг тайлагнах сан болон УАӨМСЗ-ийг нэгтгэхээр болов.
- 2022 оны 3-р сард [СТОУС Сан болон ТООС хооронд тогтвортой байдлын ил тод байдлыг уялдуулах](#) зорилгоор хөрөнгийн зах зээл болон олон талт стандартыг уялдуулах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

Европын холбоо (ЕХ) нь дийлэнх бизнес эрхлэгчдээс санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг ил тод, нээлттэй тайлагнахыг шаардахын зэрэгцээ олон төрлийн стандартыг ашиглахыг зөвшөөрдөг. Мөн ЕХ-ны санхүүгийн бус тайлагналын стандартыг боловсруулах бэлтгэл ажил болон багц ажлын зураглалыг саяхан гаргаж дууссан. Гол зорилго нь төрөл бүрийн тайлагналын санаачилгын элементүүд болон шинээр боловсруулах шинэ элементүүдийн хослол бүхий дэвшилтэт нэгдсэн тайлагналын шийдлийг бий болгоход чиглэсэн юм. ЕХ-ны эдгээр хүчин чармайлт нь Европын холбоо төдийгүй дэлхий нийтээрээ тогтвортой байдлын төлөөх үүрэг амлалтаа биелүүлж, санхүүгийн болон тогтвортой хөгжлийн нөлөөллийг аль алиныг давхар харах арга замыг бий болгох үндсэн зорилготой.

ЕХ-ноос Санхүүгийн бус тайлагналын удирдамж (СБТУ)-аа шинэчлэн боловсруулж, Компанийн Тогтвортой байдлын тайлангийн удирдамж (КТБТУ)-ийн саналыг баталж байгаа бөгөөд энэ нь бусад бүх томоохон компаниуд болон зохицуулалттай зах зээлд бүртгэлтэй бүх компаниудад СБТУ-ийн хамрах хүрээг өргөтгөх болно (бичил аж ахуйн нэгжүүдээс бусад). Түүнчлэн ТУОС-ын Тогтвортой байдлын тайлангийн стандарттай нийцүүлэн илүү нарийвчилсан тайлангийн шаардлагыг нэвтрүүлж байна. Европын Green Deal буюу ногоон хэлэлцээрийн амлалтыг биелүүлэх, мөн “тогтвортой” гэдгийг нэгдсэн байдлаар томъёолохын тулд 2020 онд “ЕХ-ны Таксономи”-ийг боловсруулсан. ЕХ-ны Таксономи нь байгаль орчинд ээлтэй эдийн засгийн үйл ажиллагааны жагсаалтыг тогтоодог эдийн засгийн ангиллын систем юм. ЕХ-ны Тогтвортой байдлын ил тод байдлын зохицуулалтуудыг Хавсралт 2-т тоймлов.

ТХЗ-ын Нөлөөллийн Стандартыг¹² хөрөнгө оруулагчид, компаниудад үйл ажиллагаагаа илүү тогтвортой явуулах мөн тогтвортой хөгжил, НҮБ-ын ТХЗ-д өөрсдийн хувь нэмэр оруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБХХ-ийн “ТХЗ-ийн нөлөөлөл” санаачилгаас боловсруулсан. Бусад стандартуудаас ялгаатай нь

уг стандарт нь гүйцэтгэл, тайлагнал бус харин шийдвэр гаргалт дээр төвлөрдөг.

Байгууллагууд дотоод менежмент, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтаа тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцүүлэхийн тулд **ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт**-ыг гарын авлага, өөрийгөө үнэлэх хэрэгсэл болгон ашиглаж болно. Өөрөөр хэлбэл байгууллагууд орхигдол болон нөлөөллийн дүн шинжилгээ хийх, хоцрогдлоо нөхөх, үйл ажиллагаагаа сайжруулахад уг стандартыг нэвтрүүлбэл тохиромжтой. Стандарт нь (1) стратеги, (2) удирдлагын арга барил, (3) ил тод байдал, (4) засаглал гэсэн харилцан уялдаатай дөрвөн сэдвийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд сэдэв тус бүр нь тогтвортой байдлыг үйл ажиллагаандаа уялдуулах, ТХЗ-д эерэгээр нөлөөлөх, байгууллагын менежмент, шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Зураг 4. ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт



3

ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Урьд өмнө нь тогтвортой байдлын тайлан гаргаж байсан туршлагагүй компаниудын хувьд уг тайланг гаргаж хэвшихэд нэлээд цаг хугацаа, хүч нөөц шаардагдана. Гэхдээ тогтвортой байдлын тайлан гаргахад шаардагдах тоо мэдээллийг цуглуулах, шалгах, нээлттэйгээр мэдээлэх үйл явцыг тодорхой болгосноор компаниуд энэ чиглэлийн зардлаа бууруулах, тайлагналын үр өгөөжийг дээд зэргээр ашиглахад нь тус болох нь гарцаагүй юм. Энэ үйл явц нь зөвхөн мэдээлэл цуглуулахаар хязгаарлагдахгүй бөгөөд компанийн удирдлага болон гүйцэтгэлийн түвшинд мэдлэг мэдээллийг сайжруулах, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг ч мөн хамаарна. Компаниуд үр ашигтай, үр нөлөөтэй тайлагналын системийг бүрдүүлэхийн тулд дараах алхмуудыг баримталбал тустай. Үүнд¹³:

Зураг 5. БОНЗ, Тогтвортой байдлын тайлан бэлтгэх алхмууд



АЛХАМ 1: КОМПАНИЙН МЭДЭГДЭЛ БОЛОН УДИРДЛАГЫН ДЭМЖЛЭГ

Тогтвортой байдлын тайлагналыг хэрэгжүүлэх шийдвэр нь компанийн бизнесийн үндсэн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн стратегид туссан байх ёстой бөгөөд удирдах зөвлөл, гүйцэтгэх хороо зэрэг дээд түвшний удирдлагын шийдвэрээр дэмжигдсэн байх шаардлагатай. Энэ нь компанийн тогтвортой байдлын тайланг хэвлэн нийтлэх компанийн алсын харааг тодорхойлох, тогтвортой байдлын тайлангийн бизнесийн үр нөлөөг ажилтнууд болон бусад оролцогч талуудад ойлгуулан тайлбарлах, тайлан бэлтгэх үйл явцыг хариуцан ажиллах хүмүүсийг


томилох, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааны болон санхүүгийн зохицуулалт хийхийг дэмжих, тайлагнах шаардлагатай БОНЗ-ын тэргүүлэх чиглэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, тайлангийн эцсийн хувилбарыг хянаж, гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэх зэрэг бүхий л үйл явцын баталгаа болно.¹⁴ Удирдах зөвлөл, дээд түвшний удирдлага нь тогтвортой байдлын төлөө тэргүүлэх эгнээнд зогсож, компанийнхаа стратеги төлөвлөгөөнд тогтвортой байдлын стратегийг тусгахад нь дэмжлэг, манлайлал үзүүлэх ёстой.

Хэрэв тухайн компани өмнө нь тогтвортой байдлын тайлан гаргасан бол оролцогч талуудаас тайлангийн талаарх санал хүсэлтийг авч, салбарын компаниудын жишиг тайлантай харьцуулж үзэх хэрэгтэй. Мөн тайланд оруулах мэдээлэл цуглуулахаас өмнө өгөгдөл, мэдээллийн бэлэн байдлыг судалж үзэх шаардлагатай.

Компанийн удирдлага удирдах зөвлөлийн амлалт хамгийн чухал бөгөөд удирдлагаас тайланг хянаж, гарын үсэг зурах нь зүйтэй.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Санхүүжилтийн санаачилга (НҮББОХ СС) нь Удирдлагын түвшинд тогтвортой байдлын төлөөх үйлсийг өрнүүлэхэд дараах Зураг 6-д үзүүлсэн гурван үе шатыг дамжиж байгааг тодорхойлсон байдаг. Үүнд:

Зураг 6. Удирдлагын түвшин дэх тогтвортой байдлын төлөөх үйлсийн өрнөл



Чухамдаа байгууллага бүр тогтвортой байдлыг 'ердийн бизнес/business-as-usual' хэмээн үзэж, бизнесийн стратегидаа тусган, удирдах зөвлөлөөрөө ахлуулахыг зорих нь чухал. Тогтвортой байдалд нөлөөлөх аливаа асуудлыг цогцоор нь стратегийн хүрээнд авч үзэх амлалтаа хэрхэн биелүүлж байгаа тухай **Тогтвортой хөгжлийн төлөөх мэдэгдэл**-ийг байгууллага бүр жилийнхээ тайланд оруулж сонирхогч бүх талуудад танилцуулж байх нь зүйтэй. Энэ нь компаниудын дээд түвшний удирдлагын бодлогыг илэрхийлэх юм.

АЛХАМ 2: ТАЙЛАГНАЛЫН АЖЛЫГ ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ ТОМИЛОХ

Тогтвортой байдлын тайлагнал нь олон талт оролцоотой үйл явц билээ. Компанийн дээд түвшний удирдлага нь тайлагналын бүхий л үйл явц болон энэ чиглэлээр дотоод болон хөндлөнгийн оролцогч талуудтай хамтран ажиллах ажлыг удирдах, зохицуулах үүрэг хүлээлгэхэд компани дотроос хэн хамгийн тохиромжтойг тодорхойлох ёстой. Компанийн бүтэц зохион байгуулалтаас хамаарч зохицуулагч буюу тайлагналыг ахлах ажилтан нь тогтвортой байдал, тайлагнал, харилцаа холбоо болон бусад холбогдох чиглэлээр мэргэшсэн

байхын зэрэгцээ дээд түвшний удирдлагад шууд хандах боломжтой хүн байх ёстой. Ихэнх тохиолдолд удирдлагын нарийн бичиг эсвэл хөрөнгө оруулалтын харилцааны ахлах энэхүү албан тушаалыг хашдаг. Тайлагналын ажлыг хариуцан ажиллах хүнийг томилсны дараа тогтвортой байдал, санхүү, хөрөнгө оруулагчдын харилцаа, эрсдэл, комплаенс, харилцаа холбоо, хүний нөөц, борлуулалт, үйл ажиллагаа гэх мэт салбар газар, хэлтсийн төлөөллийг оролцуулсан БОНЗ/тогтвортой байдлын асуудал хариуцсан Ажлын хэсэг байгуулахыг зөвлөж байна. Дээд түвшний удирдлагын байнгын хяналт удирдлага дор ажиллах энэхүү Ажлын хэсгийн үндсэн зорилго нь өөрийн салбар газар, хэлтсүүдэд тогтвортой хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэх, төлөвлөх, жилийн тайланд зориулан тогтвортой байдлын талаарх тоо мэдээллийг цуглуулах зэрэгт оршино.

АЛХАМ 3: ТАЙЛАГНАВАЛ ЗОХИХ МАТЕРИАЛЛАГ АСУУДЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ

МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ: Стандарт тогтоогчид тухайн байгууллагын тогтвортой байдлыг ил тод болгохын тулд материаллаг байдлын асуудалд олон янзын өнцгөөс ханддаг бөгөөд дараах байдлаар тусгасан байдаг.

- Компанийн оролцогч талуудад хамгийн чухал хамааралтай асуудлууд юу болохыг тодорхойлж, шийдвэрлэх болон тухайн компанид юу хамгийн ихээр нөлөөлж байгаа; мөн компанийн үйл ажиллагаа нь юунд хамгийн ихээр өртөж байгаа тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл, тэргүүлэх асуудлуудыг эрэмбэлэх тухай ойлголт юм. – Deloitte
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс “материаллаг” мэдээллийг орхигдуулсан, буруу бичсэн эсвэл тодорхойгүй тохиолдолд уншигчдын эдийн засгийн шийдвэрт нөлөөлж болзошгүй гэж тодорхойлсон.
- Үнэ цэнийн тайлагналын сангийн нэгдсэн тайлагналын тогтолцооны тодорхойлсноор тухайн асуудал нь “байгууллагын богино, дунд, урт хугацаанд үнэ цэнийг бий болгох чадварт бодитойгоор нөлөөлж байвал” түүнийг материаллаг гэж үздэг.
- СТОУС Сангаас ОУТБСХ-нд өгсөн зөвлөмжид тогтвортой байдалтай холбоотой санхүүгийн мэдээлэл нь “хэрэв энэ нь байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний үнэ цэн, цаг хугацаа, тодорхой байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлгээнд нөлөөлж байвал” материаллаг байна гэж үздэг.
- ТОУС-ийн 2021 оны Тогтвортой байдлын тайлангийн стандартад тогтвортой байдлын сэдэв нь “байгууллагын эдийн засаг, байгаль орчин, хүмүүст үзүүлэх хамгийн чухал нөлөөлөл, түүний дотор хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг төлөөлөх” тохиолдолд чухал ач холбогдолтой гэж үздэг.

Ямар ч байгууллагад маш олон төрлийн асуудлаар тайлагнах боломж бий. Иймээс компаниуд тайланд тусгах шаардлагатай БОНЗ-ын талаарх хамгийн чухал асуудлыг тодорхойлж, эрэмбэлэхийн тулд эхлээд материаллаг байдлын үнэлгээ хийх нь чухал юм.

Дор KPMG¹⁵ аудитын компанийн зөвлөмж дээр үндэслэн материаллаг байдлын үнэлгээг хэрхэн хийх явцыг харуулав.

Хүснэгт 4. Лавлах: KPMG-ийн зөвлөсөн материаллаг байдлыг үнэлэх удирдамж

Үе шат	Үйл ажиллагаа
ҮЕ ШАТ 1: Зорилго, хамрах хүрээг тодорхойлох	Танай байгууллагын хувьд хамгийн чухал материал юу болохыг тодорхойлох, ингэхдээ байгууллагын хүрэх зорилго, зорилтот хэрэглэгчдийг нарийвчлан тодорхойлох. Газарзүйн байршлаар нь бүс нутаг, улс орнууд болон таны бизнесийн аль хэсэг (жишээ нь бизнесийн нэгж, бүлгийн түвшин) хамрагдах, аль нь хамрагдахгүй (boundaries) талаар сайтар бодож тодорхойлох.
ҮЕ ШАТ 2: Асуудлуудаа тодорхойлох	Дотоод, гадаад судалгаа, жишиг эх сурвалжуудыг судлах замаар болзошгүй материал асуудлуудын дэлгэрэнгүй жагсаалт гаргах. Болзошгүй эрсдэл дээр нэмээд боломж бий болгох хүчин зүйлсийг мөн оруулах. Дотоод эх сурвалжууд: Байгууллагын өмнөх жилийн тайлан, тогтвортой байдлын тайлан, бизнесийн стратеги, тогтвортой байдлын болон компанийн нийгмийн хариуцлагын стратеги, компанийн алсын хараа, үнэт зүйлс гэх мэт. Гадаад эх сурвалжууд: СЗХ болон МХБ-ийн тавигдах шаардлагууд, үндэсний хууль, тогтоомжууд, НҮБ-ын ТХЗ, ТБНБСЗ (Нөлөөллийн зураглалыг Хавсралтаас харна уу), ТОУС, УАӨСМТАХ, НЯМТ зэрэг стандартууд, Dow Jones Тогтвортой байдлын индекс болон салбарын тайлангууд, тухайлбал, Дэлхийн Банкны Байгаль орчин, Эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаарх удирдамж, зааврууд. Жишиг эх сурвалжууд: Өрсөлдөгч байгууллагууд, ижил төстэй улс орнуудын тогтвортой байдлын стратеги, тайлан.
ҮЕ ШАТ 3: Ангилах	Боломжит материаллаг асуудал, сэдвүүдийн жагсаалтыг ангилж сайжруул. Асуудлуудыг хязгаарлагдмал тооны дээд түвшний ангилалд хувааж, ангиллыг ижил түвшинд байгаа эсэхийг шалгаж, үйл явцад хэнийг орхигдуулахгүй байгааг шалгаж, сэдэв бүр ойлгомжтой эсэхийг нягтлаарай.
ҮЕ ШАТ 4: Асуудлын нөлөөлөл, ач холбогдлын талаар мэдээлэл цуглуулах	Бизнес болон сонирхогч талуудад хамааралтай болохыг ойлгохын тулд материаллаг сэдэв бүрийг нарийвчлан судал. Сэдэв тус бүрээр холбогдох оролцогч талуудыг авч үзэн, ач холбогдлыг үнэлж, оноо өгөх аргачлалыг тодорхойлж, бизнест стратегийн ач холбогдлыг үнэлэх замаар материаллаг сэдэв бүрийн хамаарлын талаарх мэдээллийг цуглуул.
ҮЕ ШАТ 5: Эрэмбэлэх	Бизнесийн стратегийн ач холбогдол, сонирхогч талуудад үзүүлэх ач холбогдол, үнэ цэнийн сүлжээн дэх сэдэв бүрийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөнд үндэслэн материаллаг сэдвүүдийг эрэмбэлэх. Сэдвүүдийг эрэмбэлэхийн тулд холбогдох бизнесийн чиг үүрэг, оролцогч талуудыг тодорхойлж, бизнест үзүүлэх нөлөөллийн үндсэн дээр сэдвүүдийг эрэмбэлэх, тухайн сэдэв бүрийн эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг компанийнхаа үнэ цэнд үнэл. Аль сэдвийг материаллаг гэж үзэхийг тодорхойлох босго буюу хязгаарыг тогтоо.
ҮЕ ШАТ 6: Менежментэд оролцуулах	Үр дүнг баталгаажуулахын тулд материаллаг байдлын үнэлгээний үр дүнг гол дотоод оролцогч талуудад турших. Материаллаг байдлын үнэлгээнд ахлах удирдлага гарын үсэг зурж баталгаажуулж, үйл явц, үр дүнг дотоод болон гадаад найдвартай гэж үзэхийн тулд дахин хянана.
ҮЕ ШАТ 6: Оролцогч талуудын баталгаажуулалт	Ганцаарчилсан уулзалт, онлайн асуулга, утсаар ярилцлага хийх зэргээр дотоод болон хөндлөнгийн гол оролцогч талуудаа тодорхойлж, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулах замаар болзошгүй материал асуудлуудын талаар дэлгэрэнгүй жагсаалт гаргах. Оролцогч талуудад харилцагч үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчид, ханган нийлүүлэгчид, эрх зүйн зохицуулагчид, орон нутгийн хүмүүс, салбарын холбоод, ТББ-ууд зэрэг орно. Оролцогч талуудын санал хүсэлтийн үр дүнг баримтжуулж, цаашдын тайланд үзүүлэх нөлөөллийг тэмдэглэх хэрэгтэй.

Шалгуур үзүүлэлтүүд ч мөн компани бүрд ихээхэн ялгаатай байдаг¹⁶ учир хүчин зүйл бүрийн нөлөөллийг тооцохдоо i) тухайн компани юуг хамгийн чухал, хамаатай зүйл хэмээн үзэж байгаа, ii) сонирхогч талуудын чухал хэмээн үзэж буй асуудал зэрэгт үндэслэх хэрэгтэй¹⁷ Мөн тухайн компани нь тайлагнахаар сонгосон материаллаг асуудлуудыг хэрхэн тодорхойлсон талаарх бүхий л үйл явцыг тайлбарлах чадвартай байх ёстой.

ОУТБСЗ-ийн СТОУС Сангаас саяхан хэвлэгдсэн загварууд болон УАӨСМТАХ зөвлөмжүүд нь олон улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчид болон бусад оролцогчдын компанийн үнэ цэнийн үнэлгээг мэдээлэхэд чиглэгддэг бол ТООУС-ийн Тогтвортой байдлын тайлангийн стандартууд болон ЕХ-ны санал болгож буй Корпорацийн Тогтвортой байдлын тайлангийн удирдамж нь эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх хүчин зүйлсээр материаллаг байдлыг авч үздэг.

ДАВХАР МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ: Ил тод байдал нь ашиг сонирхлын ялгаатай байгааг харгалзан үзэж 2017 онд Европын Холбоо “давхар материаллаг байдал” гэсэн ойлголтыг нэвтрүүлсэн. Үүнд,

- Байгууллагын “хөгжил, гүйцэтгэл болон байр суурь”-д хамаарах санхүүгийн материаллаг байдал; болон
- “Байгууллагын үйл ажиллагааны нөлөөлөл”-д хамаарах байгаль орчин, нийгмийн материаллаг байдал.

АЛХАМ 4: ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТОДОРХОЙЛОХ


Тогтвортой байдлын тайланд ихэвчлэн маш олон тооны нийгмийн хариуцлагын төслүүдийн үйл ажиллагааны тухай болон гоё ганган гэрэл зургуудыг хавсаргасан байдаг хэдий ч тогтвортой байдлын нэн чухал асуудлууд, шалгуур үзүүлэлтүүд дээр тухайн компани бодитой ямар ажил хийж байгаа талаарх мэдээлэл тун хомс байх тал ажиглагддаг. Нэгэнт үүсэж болзошгүй нөлөөллийн асуудлуудаа тодорхойлсон л бол тухайн асуудлуудыг шийдвэрлэх бодит үр нөлөө, ахиц дэвшлийг хэмжих, харуулах тайлангийн агуулга, үзүүлэлтүүдийг тодорхойлох шаардлагатай.

Олон улсын шилдэг туршлагад тулгуурлан төслийн багаас санхүү, тогтвортой байдал, салбарын зэрэг асуудлаар янз бүрийн оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү Удирдамжийн дараагийн бүлэгт өгүүлэх **суурь БОНЗ-ын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг** боловсруулсан. Эдгээр гол үзүүлэлтүүд нь тогтвортой байдлын зэрэгцүүлж болохуйц цөөн тооны суурь мэдээллийг гаргах зорилготой. Иймээс компаниуд зөвхөн эдгээр үзүүлэлтээр хязгаарлалгүйгээр илүү олон мэдээлэл гаргах хэрэгтэй.

Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдээс гадна цаашдын тогтвортой байдлын гүйцэтгэлийг сайжруулах талаарх компанийн төлөвлөгөө, хагас дутуу болон бүрэн бус тоо мэдээллийн талаарх тайлбар, мөн үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудад хүргэхийг хүсэж буй гол чухал

асуудлуудаа тайланд тусгах ёстой.


Зураг 7. ОУСК-ийн санал болгож буй Корпорацийн үнэ цэнэ, тайлагналыг БОНЗ-тай уялдуулах загвар



Зураг 8. Лавлах: ТХЗ-ыг тайлагнах талаар

2015 оны 9-р сард НҮБ-ын гишүүн 193 улс орны тэргүүнүүд санал нэгдэж дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлыг ирэх 15 жилийн хугацаанд шийдвэрлэх төлөвлөгөө болох “2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан. Энэ нь хүртээмжтэй эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдал, хомсдож буй байгалийн нөөц баялаг, байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг өргөн хүрээний сорилт бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн 17 зорилго, 169 зорилтоос бүрдэнэ. Монгол Улс нь 2030 он хүртэлх Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг амлалтаа биелүүлэх зорилгоор ТХЗ-ын зорилтуудыг урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050, үндэсний болон салбарын бодлогын баримт бичигт тусган ажиллаж байна.

ТХЗ-ыг компаниуд өөрсдийн нэр хүнд, имиж, зах зээл дэх стратегийн байр сууриа сайжруулахад нь үнэтэй хувь нэмэр оруулахын зэрэгцээ тогтвортой байдлын эрсдэлээ үнэлж, удирдах их замналын зураглал хэмээн хүлээн авч байна. Ийнхүү ТХЗ-ыг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч дэмжих болсон энэ үед бизнес эрхлэгчид ч холбогдох зорилго, зорилтуудыг батлан бизнесийнхээ стратеги, үйл явцад тусгах замаар засгийн газар, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудад ТХЗ-д оруулж буй хувь нэмрээ харуулахаар шамдах болсон. Үүний нэг жишээ бол компаниуд ТХЗ-ын зорилтуудыг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлээ хэрхэн тодорхойлж байгаа, тэдгээрийг хэрэгжүүлэхээр өөрсдийн дэвшүүлж буй зорилго, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд болон өнөөгийн ахиц дэвшлийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод болгож байгаа явдал юм.



АЛХАМ 5: ТӨЛӨВЛӨХ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Шалгуур үзүүлэлтүүдээ сонгосны дараа тайланд шаардагдах тоон болон чанарын мэдээллийг тодорхойлно. Тогтвортой байдлын сайн тайлан нь оновчтой, найдвартай, харьцуулах боломжтой бүхий л гүйцэтгэлийн тоон мэдээллүүдийг агуулсан байдаг.

БОНЗ-ын ажлын хэсэг нь холбогдох ажилтнуудтай хамтран өнөөгийн гаргаж байгаа мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох буюу гарахгүй байгаа мэдээллийг цуглуулж дараа дараагийн тайланд тусгах үйл явцыг эхлүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд төрөл бүрийн бизнесийн нэгжүүд, бусад оролцогч талуудтай холбоо харилцаа тогтоож хамтран ажиллах шаардлага гардаг. Тоон мэдээлэл олж авахын тулд хайх, тоо мэдээллийг олон өөр хэлбэр, загвараар гаргах, тооцоолол, хувиргалтуудыг хийхдээ алдаа гаргах зэрэг мэдээлэл цуглуулах явцад олон саад бэрхшээл тулгарах нь элбэг. Эдгээр бэрхшээлүүд нь нийтлэг тохиолддог бөгөөд үйл явцын нэг хэсэг гэж үзэх хэрэгтэй¹⁸. Мөн, мэдээлэл цуглуулах, түүнийхээ үнэн зөвийг нь шалгах гэх зэргээр мэдээлэл олж авахад тодорхой хугацаа шаардагдана. Шинээр үзүүлэлтүүд тооцох гэж байгаа бол компаниудад цаг хугацаа нэлээд хэрэгтэй болох нь гарцаагүй. Шинээр мэдээлэл цуглуулах зорилгоор мэдээлэл цуглуулах тогтолцоо, аргачлал нэвтрүүлэх гэж байгаа тохиолдолд тухайн байгууллагын овор хэмжээнээс хамаарч жил, түүнээс ч урт хугацаа шаардагдаж болзошгүй юм. Мэдээллийг цуглуулсны дараа харин компанийнхаа түвшинд нэгтгэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Хэрэв танай компани тайлагналыг анх удаа хийж байгаа бол жилийн тайлангаа хэрхэн тасралтгүй сайжруулах талаар ойрын 2-3 жилийн замын зураг, төлөвлөгөө боловсруулахыг зөвлөж байна.

Олон компаниуд тоон мэдээллийн уялдааг хангах, гүйцэтгэлийн хяналт хийх

зорилгоор **эхлэх цэгийг буюу суурь оныг** тодорхойлдог. Ингэснээр дотоод гүйцэтгэлийг хянах, шийдвэр гаргахад туслах, зорилтот түвшинд хүрэхэд гарч буй ахиц дэвшлийг харуулахад тусална. Суурь оныг сонгохдоо өөрийн байгууллагын түүхэн мэдээллийн чанар болон онцгой тохиолдлууд гарсан эсэх буюу гарах давтамж зэргийг анхаарах шаардлагатай¹⁹. Тодорхой зохион байгуулалтад оруулж **мэдээллийг хадгалахын тулд** компаниуд тогтвортой байдлын мэдээллийг өнөөгийн хэрэглэж байгаа мэдээллийн удирдлагын системд оруулж мэдээллийн сан үүсгэж байхыг зөвлөж байна. Хэрэв ийм дотоод систем одоогоор байхгүй бол компаниуд тайлагналын чадавхыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулж, Ирээдүйд тохирохуйц Хөгжлийн Тооцоолуур (Future-Fit Progress Calculator), [MultiCapital Scorecard](#), [Reporting 3.0 Blueprints](#) зэрэг арга хэрэгслийг ашиглаж болно.

Мэдээллийн нормчилсон утга/ эрчмийн хэмжүүрүүд

Гүйцэтгэлийн мэдээллийг сонирхож буй уншигчид ихэвчлэн хоёр төрлийн үзүүлэлтийн мэдээллийг хайж байдаг. Үүнд:

- **Абсолют утга:** гарц, орц, үр дүнгийн абсолют хэмжээ буюу ерөнхийдөө үндсэн хэмжих нэгжээр нь илэрхийлэн, хөрвүүлэхэд хялбар утгууд. Жишээлбэл, хүлэмжийн хийн ялгаруулалтын бууралтыг тонн CO₂-эквивалент-р илэрхийлнэ.
- **Нормчилсон утга:** ижил буюу өөр төрлийн хоёр абсолют утгуудын хоорондын харьцаа болох харьцангуй утгууд юм. Нормчилсон утгуудыг үйлдвэрлэлийн гарцтай холбож “эрчимжүүлэх хэмжигдэхүүн/intensity measures” гэж нэрлэдэг бөгөөд харьцуулах боломжтой хэмжүүрүүд юм. Жишээлбэл, үйлдвэрлэлийн нэг нэгжид ногдох хүлэмжийн хийн ялгаруулалтыг тонноор илэрхийлэх.

Уур амьсгалтай холбоотой ил тод байдлын ач холбогдол

- Хөрөнгө оруулагчдыг тухайн компани нь хэрхэн уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөц, байгаль орчны боломж, эрсдэлд өртөж буй талаар тодорхой, найдвартай, итгэл төрүүлэхүйц мэдээлэл, хөрөнгийн хуваарилалтын шийдвэрээр хангах. – УАӨМСЗ
- Тухайн компани, түүний ханган нийлүүлэгчид болон өрсөлдөгчдөд учирч болох уур амьсгалтай холбоотой эрсдэлийг илүү үр дүнтэй үнэлэх. – УАӨСМТАХ

АЛХАМ 6: БАТАЛГАА ГАРГУУЛАХ

Тогтвортой байдлын талаарх мэдээлэл үнэн зөв, найдвартай байх нь нотолгоонд суурилсан бизнесийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Тайлагнагч байгууллагууд нь тайлангийн үнэн зөв байдалд ямар төрлийн баталгаа (дотоод буюу хөндлөнгийн) гаргуулахыг хүсэж байгааг оролцогч талуудаасаа (ялангуяа хөрөнгө оруулагчдаас) мэдэж авах хэрэгтэй.

Цаашлаад, аудитын компаниуд, тогтвортой байдлын үнэлгээ хийдэг

байгууллагууд, гуравдагч этгээдийн хөндлөнгийн баталгаа гаргадаг мэргэшсэн байгууллагууд зэрэг нь санхүүгийн аудит хийдэгтэй нэгэн адил тайлангийн үнэн зөв, найдвартай байдалд баталгаа гаргах боломжтой. Баталгаажуулалт хийлгэснээр төөрөгдүүлсэн буюу буруу ташаа мэдээллийг задруулахтай холбоотой компанийн нэр хүндэд учрах эрсдэл болон зах зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд тусална.²⁰

Одоогоор Монгол Улсад үндэсний хэмжээнд БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын мэргэшсэн баталгаа гаргадаг байгууллага байхгүй ч компаниуд тус улсад салбараа нээгээд байгаа олон улсын Том 4 хэмээн нэрлэгддэг аудитын компаниар баталгаа гаргуулах боломжтой. Компаниуд тогтвортой байдлын тайлан гаргаж хэвшихийн хэрээр тайлагналын баталгаа гаргах шинэ зах зээл бий болж байна.

АЛХАМ 7: ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ

Тайлан боловсруулах баг нь урьдчилан тодорхойлсон материаллаг асуудлаар цуглуулсан тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тогтвортой байдлын тайланг боловсруулж бэлтгэнэ. Тогтвортой байдлын тайланг оролцогч талуудын онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн янз бүрийн загвараар бэлтгэж болно. Тайлангийн загвар болон мэдээллийн сувгуудыг зөв сонгосноор хөрөнгө оруулагчдад хэрэгцээт мэдээлэл нь хялбар, хүртээмжтэй, харьцуулж болохуйц байдлаар, цаг алдалгүй хүрэх боломж олгоно. Доорх хүснэгтэд ОУСК-ийн Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлахад зөвлөмж болгосон жилийн нэгдсэн тайлангийн загварын үндсэн агуулгын элементүүдийг тоймлон харуулав.

Хүснэгт 5. Тайлангийн нийтлэг хэрэглэгддэг загварууд

Тайлангийн төрөл	Тайлбар	Жишээ
Жилийн тайлан	Жилийн тайлан нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад компанийн үйл ажиллагаа, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл өгөх зорилготой. Зарим компаниуд БОНЗ-ын асуудлыг жилийн тайландаа нэгтгэж гаргадаг бөгөөд хөрөнгө оруулагчдад БОНЗ-ын талаарх мэдээллийг компанийн дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүргүүлэхийг зорьдог. Гэхдээ хэт нуршуу, ойлгоход төвөгтэй болгохгүйн тулд компаниуд БОНЗ-ын асуудлыг жилийн тайландаа товч тусгаж, зөвхөн хөрөнгө оруулагчдын анхаарал хандуулдаг БОНЗ-ын гол чухал асуудлыг тайлагнах хандлага бий. Түүнчлэн БОНЗ-тай холбоотой хэсгийн агуулга нь жилийн тайлангийн агуулгын бүтэц, бичиглэлтэй тохирохгүй байх ч магадлал бий.	Говь ХК ХААН Банк

<p>Тогтвортой хөгжлийн тайлан</p>	<p>Дийлэнх компаниуд тогтвортой байдлын тайланг тусгайлан бэлтгэхийг илүүд үзэж байна. 2019 оны байдлаар 32700 тайлан ТОУС-ын Тогтвортой байдлын нээлттэй мэдээллийн сан –д бүртгэгдсэн бөгөөд эдгээр тайлангууд нь ТОУС-ын стандартад нийцэж байгаа юм. Компаниуд нэгжүүдийнхээ байршил нэг бүрээр гаргасан БОНЗ-ын мэдээллийг нэгтгэж тогтвортой байдлын тайланг гаргаж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талууд, тухайлбал хэрэглэгчид, иргэний нийгэм зэрэг талуудын хэрэгцээнд нийцсэн БОНЗ-ын мэдээллийг ч мөн гаргаж байна.</p>	<p>Энержи ресурс/ Energy Resource</p> <p>Голомт Банк</p>
<p>Нэгдсэн тайлан</p>	<p>Нэгдсэн тайлан нь байгууллагын стратеги, засаглал, гүйцэтгэл, хэтийн төлөв нь түүнийг хүрээлэн буй гадаад орчин нөхцөлд хэрхэн үнэ цэнийг бүтээхэд чиглүүлж байгаа талаарх тодорхой мэдээллийг өгнө. Ингэхдээ БОНЗ-ын асуудлаарх тоо, мэдээллийг жилийн тайланд нэгтгэсэн байдлаар тайлагнадаг. Энэхүү загвар нь хөрөнгө оруулагчдад бизнесийн гүйцэтгэл, түүнээс үүдсэн богино, дунд, урт хугацааны үр нөлөөний талаар илүү багцалсан, оновчтой бөгөөд цогц ойлголтыг өгөх боломжтой.</p>	<p>IDLC Finance</p>

Тайлагналын янз бүрийн загвар байдаг хэдий ч компаниудад **нэгдсэн тайлагналын аргыг** баримтлахыг зөвлөмж болгож байна. Энэхүү арга нь компанийн стратегийн болоод засаглалын мэдээллийг санхүүгийн үр дүнтэй нь хамт тайлагнаж, хөрөнгө оруулагчдад компанийн хэтийн төлөвийн талаар илүү сайн ойлголт өгөх боломжийг бүрдүүлнэ. Ингэснээр компанийн стратеги, эрсдэлийн төлөв байдал, гүйцэтгэлээс үүдэж байгаль орчин, нийгмийн асуудалд учрах нөлөөлөл, компанийн засаглалын нэг хэсэг болох гол боломж, эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа зэргийг илүү нээлттэй мэдээлэх боломж үүснэ. Доорх хүснэгтэд –д зөвлөмж болгосон жилийн нэгдсэн тайлангийн загварын үндсэн агуулгын элементүүдийг тоймлон харууллаа.

Хүснэгт 6. Жилийн нэгдсэн тайлангийн жишиг загвар

1. Стратеги

- Бизнесийн загвар, стратегийн тойм
- Стратегийн хүрээ: Гадаад орчин, оролцогч талууд
- Стратегийн хэрэгжилт: Зорилго, гол гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, зорилтууд, эрсдэлийн үнэлгээ, материаллаг байдал болон тогтвортой байдлын боломж, эрсдэлүүд

2. Компанийн засаглал

- Манлайлал, соёл: БОНЗ-ын асуудалд хандах хандлага
- Захирлуудын зөвлөлийн бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг
- Хяналтын орчин
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны зохицуулалт

3. Санхүүгийн төлөв байдал, гүйцэтгэл

- Гүйцэтгэлийн тайлан
- Санхүүгийн тайлангууд
- Тогтвортой байдлын тайлангууд
- Аудит, баталгаажуулалт

Эх сурвалж: ОУСК. Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах

ТОУС нь чанарын өндөр түвшинд тогтвортой байдлын тайланг бэлтгэх, танилцуулахыг дэмжих зорилгоор **Тайлагналын багц зарчмуудыг** зөвлөмж болгосон²¹. Үүнд:

Хүснэгт 7. ТОУС-ын Тайлагналын зарчмууд

#	Ерөнхий зарчмууд	Тайлбар
1	Оролцогч талуудын оролцоог хангах	Байгууллага нь оролцогч талуудаа тодорхойлж, тэдний хүлээлт, ашиг сонирхлыг хэрхэн хангасныг тайлбарласан байна.
2	Тогтвортой байдлын агуулгатай байх	Тайланд тухайн байгууллагын тогтвортой байдлын өргөн хүрээний асуудлуудыг тусгасан байна.
3	Материаллаг байх	Тайланд нь байгууллагын эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тусгасан сэдвүүдийг хамарна. Мөн оролцогч талуудын үнэлгээ, шийдвэрт бодитойгоор нөлөөлөхүйц байна.
4	Бүрэн байх	Тайлан нь тайлангийн хугацаанд тухайн байгууллагын эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх томоохон нөлөөллийг багтаасан, оролцогч талууд үнэлгээ өгөх шаардлагыг хангахуйц материаллаг асуудлууд болон хязгаарыг (boundaries) багтаасан байна.
#	Чанарын зарчмууд	Тайлбар
1	Үнэн зөв байх	Тайланд туссан тоон мэдээлэл нь тухайн тайлагнагч байгууллагын гүйцэтгэлд оролцогч талууд үнэлгээ өгөх шаардлагыг хангахуйц үнэн зөв, дэлгэрэнгүй байна.
2	Тэнцвэртэй байх	Тайлагнагч байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэх шаардлагыг хангахын тулд тайлангийн тоо мэдээлэлд тухайн байгууллагын гүйцэтгэлийн эерэг болон сөрөг талуудыг тусгасан байна.
3	Ойлгомжтой байх	Тайлагнагч байгууллага нь тайландаа тоо мэдээллийг маш ойлгомжтойгоор тусгаж, тэдгээр тоо мэдээллийг оролцогч талууд чөлөөтэй хэрэглэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
4	Харьцуулахуйц байх	Тайлагнагч байгууллага нь системтэйгээр тоо мэдээллийг сонгон, нэгтгэж, тайлагнана. Ингэхдээ оролцогч талууд тайланд туссан тоо мэдээллийг ашиглан тухайн байгууллагын үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, мөн бусад байгууллагуудынхтай харьцуулж дүн шинжилгээ хийх шаардлагыг хангасан байна.

5	Найдвартай байх	Тайлагнагч байгууллага нь тайланг бэлтгэхэд ашигласан тоо мэдээлэл, үйл явцыг шалгах тохиолдолд ашиглаж болохуйц байдлаар тоо мэдээллийг цуглуулах, бүртгэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах ажлыг зохион байгуулж мэдээллийн чанар, үр нөлөөллийг тооцсон байна.
6	Цаг хугацааг чанд баримтлах	Тайлагнагч байгууллага нь тогтсон хуваарийн дагуу тайлагнаж байх ёстой бөгөөд ингэснээр оролцогч талууд үндэслэлтэй шийдвэр гаргахад нь шаардагдах тоо мэдээллийг цаг тухайд нь авах боломж бүрдэнэ.

Эх сурвалж: ТОУС (2016)

Түүнчлэн дараах хэд хэдэн нийтлэг бөгөөд тогтсон дэг журам байдгийг компаниуд анхааралдаа авахыг зөвлөж байна:

- Хөрөнгө оруулагчдад БОНЗ-ын мэдээллийн хүрээнд санхүүгийн мэдээллийг хамтад нь авч үзэх боломж олгохын тулд тогтвортой байдлын болон санхүүгийн тайланг ижил хугацаанд нийтэлж байх хэрэгтэй. Тайлангийн хугацаа 12 сар байх нь тохиромжтой.
- Мэдээлэл харилцааны янз бүрийн сувгаар мэдээллийг түгээхдээ үнэн зөв байдалд нь хяналт тавьж байх.
- Тайлангаас хүсэж буй мэдээллээ олоход хялбар болгох. Жишээлбэл, БОНЗ-ын талаарх тодорхой мэдээллийг хаанаас харж болохыг хялбархан хайх цахим индексийн холбоосыг оруулж өгөх. Жишээ үзэхийн тулд www.electroluxgroup.com цахим хуудсанд зочлон тогтвортой байдлын тайлан болон тогтвортой байдлын хамрах хүрээтэй танилцаарай.
- Тайланд ойлгомжтой үг хэллэг ашиглах, ялангуяа гол оролцогч талуудад ойлгомжтой, товч бөгөөд ярьж хэвшсэн үг хэллэг ашиглах²².

АЛХАМ 8: ТОГТМОЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тогтвортой байдлын тайлагнал гэдэг нь компанийн тогтвортой байдлын стратегийг тогтмол сайжруулахад чиглэсэн чухал бөгөөд үргэлжилсэн үйл явц юм. Тогтвортой байдлын эхний тайлангаас олж авсан сургамжийг дараа дараагийн тайлангийн мөчлөгийн төлөвлөлт мөн компанийн тогтвортой байдлын ерөнхий стратеги, засаглалыг шинэчлэн сайжруулахад байнга тусгаж байх хэрэгтэй. Тогтвортой байдлын тайлангийн стандартууд, шалгуур үзүүлэлтүүд ч хурдацтай хөгжиж байна. Иймээс компаниуд эдгээр чиг хандлагыг анхааралтай ажиглан дагаж, шаардлагатай тохиолдолд тогтвортой байдлын тогтолцоо, тайлагналын үйл явцыг шинэчлэн сайжруулж байх нь тун чухал юм.

Өмнө дурдсанчлан, хэрэв компани анх удаа тайлагнаж эхэлж байгаа бол жилийн тайлангаа хэрхэн тасралтгүй сайжруулах талаар ойрын 2-3 жилийн замын зураг, төлөвлөгөө боловсруулахыг зөвлөж байна.

4

ЮУГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ВЭ?

Төслийн багаас БОНЗ-ын тайлангийн загвар нь тайлагналын олон улсын аргачлал, стандартуудын зөвлөмжүүдтэй нийцүүлж, тайлагнавал зохих **БОНЗ-ын 30 үзүүлэлтийг** тодорхойлсон бөгөөд эдгээр нь зайлшгүй тайлагнах шаардлагатай суурь үзүүлэлтүүд юм. Тогтвортой байдлын тайланг илүү дэлгэрэнгүй гаргах зорилт тавьж буй компаниудад зориулан дээрх шалгуур үзүүлэлтүүдийг Тайлагналын ТОУС, ТБНБСЗ, УАӨСМТАХ, СТОУС зэрэг олон улсын стандартууд болон ТХЗ-ын үзүүлэлтүүдтэй харьцуулан судалж боловсруулсан.

‘Үндсэн’ буюу заавал тайлагнах шалгуур үзүүлэлтүүдээс гадна тухайн тайлагнаж байгаа байгууллагын салбарын онцлогт тохируулан нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг зааврын хамт мөн тусгасан болно. Удирдлагын эдгээр арга барил нь байгууллагын бодлого, үүрэг амлалт, зорилго, зорилт, хариуцлага, нөөц, санал гомдол барагдуулах механизм, түүнчлэн үйл явц, төсөл, хөтөлбөр, санаачилга зэргийн аль ч хэлбэртэй байж болно. Удирдлагын арга барилын талаарх нэмэлт зааварчилгааг ТОУС 103-аас үзнэ үү. Байгууллагуудын ил тод байдлын дүрмийн дагуу СЗХ, МХБ-д тайлагнахдаа болон жил бүрийн тогтвортой байдлын тайлан боловсруулахдаа дээрх зааварчилгааг ашиглах боломжтой.

Тогтвортой байдлын мэдээллийн хамрах хүрээ, нарийвчлал нь эдийн засгийн салбар бүрд онцлог байх төдийгүй тухайн компанийн өөрийн үйл ажиллагаанаас хамаарч өвөрмөц байна гэдгийг зохицуулагч байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрч байна. Компаниуд нь зөвхөн дээр дурдсан журмаар хязгаарлалгүй ТОУС буюу Нэгдсэн тайлагналын (НТ)-ын аргачлал, стандарт, журам зааврыг судлан ашиглаж болно. Зарим үзүүлэлтүүдийг ‘нэмэлт/сонголттой’ байдлаар оруулсан. ТБНБСЗ-ийн Тогтвортой хөгжлийн материаллаг байдлын зураглалыг Хавсралт 5-с үзнэ үү. Компаниуд энэ зураглалтай танилцаж, холбогдох салбарын ангиллын дагуу компанийнхаа үйл ажиллагаанаас үүдэж болох ямар материаллаг асуудал байгааг судалж тайлагнахад анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Шалгуур үзүүлэлтүүдийг тайлагнахад шаардагдах тоон мэдээллийг цуглуулахын тулд бүхий л хүчин чармайлтаа дайчлах хэрэгтэй. Шаардлагатай тоон мэдээллийг олж авахад хүндрэлтэй байгаа тохиолдолд дутуу байгаа мэдээллийн тухай тайлбарыг тайланд тусгасан байх шаардлагатай. Түүнчлэн эдгээр дутуу байгаа мэдээллийг гаргаж дараа дараагийн тайланд оруулахын тулд хийж буй алхмуудаа тодорхойлсон байхыг мөн зөвлөж байна.

Хүснэгт 8. Заавал тайлагнах үндсэн үзүүлэлтүүд

ТӨРӨЛ	Код	ТАЙЛАГНАХ АСУУДЛУУД
Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд	MS1	Удирдлагын менежмент, амлалт
	MS2	Тогтвортой байдлын бодлого, зохицуулалт
	MS3	Удирдлагын бүтэц
	MS4	Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ
	MS5	Чадавх бүрдүүлэлт
	MS6	Хяналт шинжилгээ
	MS7	Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт
	MS8	Гишүүнчлэл
Байгаль орчны үзүүлэлтүүд	E1	Эрчим хүч
	E2	Хүлэмжийн хийн ялгарал
	E3	Уур амьсгалын өөрчлөлт
	E4	Ус
	E5	Хог хаягдал
	E6	Биологийн олон янз байдал
Нийгмийн үзүүлэлтүүд	S1	Хүний нөөцийн хөгжил
	S2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
	S3	Эрх тэгш байдал
	S4	Хүртээмжтэй орчин, оролцоо
	S5	Нийгмийн хариуцлага, ил тод байдал
	S6	Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага
Засаглалын үзүүлэлтүүд	G1	Компанийн засаглал
	G2	Авлига, ёс зүй
	G3	Комплаенс/Хууль дүрмийн мөрдөлт
	G4	Оролцогч талуудын оролцоо
Салбарын нэмэлт үзүүлэлтүүд	FS	Санхүүгийн үйлчилгээ
	A	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
	T	Нэхмэлийн салбар
	MA	Боловсруулах үйлдвэрлэл
	MI	Уул уурхай
	CO	Барилга

4.1 УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Удирдлагын тогтолцоо нь бизнесийн зорилгодоо хүрэхийн төлөө тухайн компанийн бодлогоо тууштай хэрэгжүүлэх үйл явц, дэг журмын цогц нэгдэл юм. Үндсэн зорилго нь компанидаа тохирсон бодлого, дүрэм журамтай байхын зэрэгцээ ажиллагсад нь тэдгээрийг тууштай дагаж мөрддөг байхад оршино. Удирдлагын тогтолцоо нь компанийнхаа болзошгүй эрсдэлийг үнэлж, хянаж байхад туслах төдийгүй байнга сайжруулах гол түлхүүр болж өгдөг. Түүний онцлох шинж нь байнга сайжруулахын төлөөх зүтгэл буюу компанийн тогтолцоог хянаж, засаж, сайжруулах байнгын үйл явцаар илэрдэг.

Энэ хэсэгт байгууллагын тогтвортой хөгжлийн асуудал, нөлөөлөл, эрсдэл, боломжуудыг тооцож үйл ажиллагаагаа хэрхэн үр дүнтэй удирдаж байгаагаа харуулах стратеги, үүрэг амлалт, тогтвортой хөгжлийн материаллаг байдлын үнэлгээ, засаглалын зохицуулалт зэрэг тогтвортой байдлын тогтолцооны талаарх мэдээллийг танилцуулна. Тогтвортой хөгжлийн асуудлыг тусад нь салгаж авч үзэхийн оронд үйл ажиллагаандаа амжилттай шингээж чадсан байгууллагууд хамгийн их ашиг хүртэх боломжтой.

MS1. УДИРДЛАГЫН АМЛАЛТ

Юуны талаар вэ?	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	MS1.1 Танай компанийн удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн асуудлаар авсан амлалт/ хийсэн мэдэгдэл бий юу? (Тийм/Үгүй)
Яагаад чухал вэ?	Зөвхөн дэмжигч соёл, хүчтэй манлайлал байсан цагт л байгууллагынхаа эрхэм зорилгод тогтвортой хөгжлийн асуудлыг шингээх боломжтой. Удирдах зөвлөлийн гишүүд болон Гүйцэтгэх захирал зэрэг байгууллагын удирдлагуудын зүгээс байгууллагынхаа бизнесийн стратегид тогтвортой хөгжлийн асуудлыг тусгах, бизнесийн шийдвэр гаргахдаа тогтвортой хөгжлийн өнцгөөс хардаг байх, зөвхөн хууль дүрмийг мөрдөхөөр хязгаарлахгүй алсын хараатай байх зэргээр удирдлагын манлайлал үзүүлэх хэрэгтэй. Байгаль орчин, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд танай компани, ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид зэрэг оролцогч талуудын хэвшсэн дадал зуршлыг ч өөрчлөх шаардлага гарч болзошгүй юм. Энэ нь амаргүй ч байж мэднэ. Байгууллагын хэвшмэл дадлыг өөрчлөх олон өөр стратеги, арга техникүүд байдаг хэдий ч тууштай өөрчлөлт бий болгоход байгууллагын дээд түвшний удирдлагын зүгээс гаргах хүчин чармайлт тун чухал болохыг олон шинжээчид хүлээн зөвшөөрч байна.
Заавар	Энэ үзүүлэлт нь тухайн байгууллагад тогтвортой хөгжлийн асуудал хэр чухал байх тухай болон тус байгууллагын зүгээс тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн стратегийн талаар тухайн байгууллагын дээд түвшний удирдлага буюу хамгийн дээд удирдах албан тушаалтнаас гаргасан мэдэгдэл юм. Мэдэгдэл нь дараах агуулгатай байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> – Байгууллагын тогтвортой хөгжлийн асуудлаарх богино, дунд хугацааны стратегийн тэргүүлэх чиглэлүүд болон гол асуудлууд, түүний дотор олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн зорилго, зорилтууд (тухайлбал, ТХЗ-ууд, Парисын хэлэлцээр)-д хэрхэн хүндэтгэлтэй хандаж байгаа байдал, мөн тэдгээр нь тухайн байгууллагын урт хугацааны стратеги, хүрэх түвшний зорилтуудтай хэрхэн яаж уялдаж байгаа тухай, – Байгууллагын үйл ажиллагаанд болон тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлд нөлөөлж буй өргөн хүрээний чиг хандлага (тухайлбал, макро эдийн засаг буюу улс төрийн байдал) – Тайлангийн хугацаанд тохиосон гол үйл явдал, ололт амжилт, бүтэлгүйтэл – Тогтвортой хөгжлийн нөлөөллийн асуудлууд болон зорилтуудтай холбоотой гүйцэтгэлийн талаарх үзэл бодол – Ирэх жилд байгууллагын үйл ажиллагаанд тохиож болзошгүй гол сорилт, зорилтууд, ирэх 3-5 жилийн хугацаанд тавьж буй гол зорилгууд – Байгууллагын стратегийн арга хандлагатай холбоотой бусад асуудал гэх мэт.

Ашиглах материал

Холбогдох эх сурвалжууд	<p>ТОУС 102-14: Удирдлагаас гаргасан мэдэгдэл</p> <p>ТОУС 102-20: Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудлаар гүйцэтгэх түвшинд хүлээх хариуцлага</p> <p>ТОУС 102-32 Тогтвортой байдлын тайлагналд дээд түвшний удирдлагын гүйцэтгэх үүрэг</p> <p>ОУСК Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (БОНУС/ESMS)-г хэрэгжүүлэх арга зүйн лавлах, гарын авлага ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл</p> <p>ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт</p> <p>ОУСК Компанийн Засаглалын Аргачлал</p>
--------------------------------	---

MS2. Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги ба журам

Юуны талаар вэ?

Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>MS2.1 Танай компани тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа баталсан уу? (Тийм/Үгүй)</p> <p>MS2.2 Танай компани тогтвортой хөгжлийн талаар баримтлах дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)</p>
Яагаад чухал вэ?	<p>Тогтвортой байдлын удирдлагын тогтолцооны тулгын чулуу нь танай байгууллагын баримталж буй бодлогууд юм. Эдгээр бодлогууд нь танай байгууллагын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тогтвортой хөгжлийн асуудлыг зохицуулах амлалт үүргийг илэрхийлнэ. Иймээс танай компанийн эрхэмлэх үнэт зүйлс юу болох, хүмүүсийн үйлдэл ямар байгаасай хэмээн та хүсэж байгаа, хөндлөнгийн оролцогч талууд ч танай байгууллагаас юу хүсэн хүлээж болох талаар хүн бүр нийтлэг ойлголттой байх нь нэн чухал.</p>
Заавар	<p>Энэ үзүүлэлтэд байгууллагын бодлогоор хүлээсэн үүрэг амлалт, хариуцлагатай бизнес эрхлэх олон нийтэд ил тод журам хамаарна. Бодлогоор хүлээсэн үүрэг амлалтыг бие даасан бодлогын баримт бичигт тусгасан байж болох ба дагаж мөрдөх ёс зүйн дүрэм гэх зэрэг хэд хэдэн бодлогын баримт бичигт туссан байж болно. Бодлогын баримт бичиг нь ойлгомжтой, энгийн байх төдийгүй компанийн үйл ажиллагаанд тусгалаа олсон, түүнчлэн танай салбарт тулгарч буй эрсдэл, боломжуудыг ч хамруулсан байх нь чухал. Бодлогын баримт бичигт дараах үндсэн элементүүдийг тусгана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Бодлогын амлалтад тусгасан хүлээлт, үнэт зүйлс, зарчмууд, зан үйлийн хэм хэмжээ, – Компанийн үйл ажиллагаа, бизнесийн харилцааны асуудлаарх бодлогын хамрах хүрээ, – Байгаль орчин, нийгэм, засаглалын зэрэг компанийн тогтвортой хөгжлийн нөлөөллөөс хамаарах бүхий л асуудлууд (МС1.4 Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ, ОУСК-ийн Компанийн бодлогыг боловсруулах хяналтын хуудас зэргийг үзнэ үү), – Компанийн мөрдөж байгаа бусад стандарт, санаачилгуудад тавигдах шаардлагууд, – Хүний эрхийг хамгаалах асуудлууд, ялангуяа нутгийн уугуул иргэд; эмэгтэйчүүд; үндэстэн, ястан, шашин шүтлэг, хэлний цөөнх; хүүхдүүд; хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс; цагаач ажилчид болон тэдний гэр бүл зэрэг хэсэг бүлгийн эрхийг хамгаалах асуудлууд, – Байгууллагын онцгой анхаарал хандуулдаг оролцогч талууд, тухайлбал, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид, ажилтнууд болон бусад ажилтнууд, орон нутгийн иргэд гэх мэт. – Бодлогын баримт бичгийг тухайн байгууллагын хамгийн дээд түвшний удирдлага баталсан байх ёстой.

Ашиглах материал

Холбогдох эх сурвалжууд	<p>ТОУС 102-14: Удирдлагаас гаргасан мэдэгдэл</p> <p>ТОУС 102-20: Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудлаар гүйцэтгэх түвшинд хүлээх хариуцлага</p>
--------------------------------	--

Холбогдох эх сурвалжууд	<p>ТОУС 102-26: Зорилго, үнэт зүйлс, стратегийг тодорхойлоход байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүрэг</p> <p>ТОУС 103-1 Удирдлагын арга барил, түүний бүрэлдэхүүн хэсгүүд</p> <p>ОУСК Байгаль орчин, нийгмийн удирдлагын систем (БОНУС/ESMS)-г хэрэгжүүлэх гарын авлага</p> <p>ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл</p> <p>ISO14001</p> <p>Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Үндэстэн дамнасан компаниудад зориулсан удирдамж, ЭЗХАХБ Хариуцлагатай бизнес эрхлэх ёс зүйн дүрмийг мөрдөх журам болон НҮБ-ын Бизнес болон хүний эрхийн удирдах зарчмууд зэрэг баримт бичгүүдэд туссан байгууллагуудын бодлогын үүрэг амлалтуудтай холбоотой зорилтууд.</p> <p>ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт</p>
--------------------------------	---

MS3. Удирдлагын бүтэц

Юуны тухай вэ?	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>MS3.1 Танай компанид тогтвортой хөгжлийн асуудлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцсан тусгай хороод бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>MS3.2 Танай компанийн ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн/гишүүд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>MS3.3 Танай компанийн Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан захирал/захирлууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>MS3.4 Танай компанийн Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан ажилтан/ажилтнууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>MS3.5 Танай компанийн ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг тогтмол, албан ёсоор тусгадаг уу? (Тийм/Үгүй)</p>
Яагаад чухал вэ?	<p>Байгууллага тогтвортой хөгжлийн асуудлыг үйл ажиллагаандаа хэрхэн тусгаж, удирдах ("тогтвортой хөгжлийн засаглал") нь тогтвортой хөгжлийн асуудлыг компанийнхаа стратегитай амжилттай уялдуулах гол түлхүүр нь юм. Компанийн засаглалын хүчтэй соёл тогтсон байгууллагууд тогтвортой хөгжлийн эрсдэл, боломжуудыг удирдахад илүү бөх бат суурьтай байх болно. Компанийн хүчтэй засаглал тогтоогүй тохиолдолд байгаль орчин, нийгмийн боломж, эрсдэлийн асуудлууд орхигдож компанийн хэмжээнд хариуцлагатай, зөв менежментийг баталгаажуулах шийдвэр гарахгүй байх магадлал үүснэ. Иймд байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцахаар томилогдсон нэгж/хүнийг оролцуулан компанийн засаглалын хүчтэй механизмыг бүрдүүлэх шаардлагатай.</p>
Заавар	<p>Энэ үзүүлэлт нь танай компанийн удирдлагын дээд түвшинд тогтвортой хөгжлийн асуудлыг ямар хэмжээнд авч үзэж байгааг тодорхойлох зорилготой.</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн эдийн засаг, байгаль орчин, хүмүүсийн аж байдалд учирч болзошгүй нөлөөллийн талаар шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг хүлээсэн удирдлагын дээд түвшний хороо, хэсгийн жагсаалтыг гаргана. Танай компанийн ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн/гишүүд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий эсэхэд хариулт өгнө. Тогтвортой хөгжлийн асуудлыг үр дүнтэй, хариуцлагатайгаар байгууллагын бодлогод суулгахын тулд удирдлагынхаа хамгийн дээд түвшинд хүлээн зөвшөөрсөн байх учиртай. Байгууллагынхаа стратегийн чиглэлийг тогтоож өгдөг учир Удирдах зөвлөлийн түвшний оролцоо маш чухал. Ингэснээр байгууллагын хэмжээнд тогтвортой хөгжлийг дэмжих тогтвортой байдлын асуудлыг зохицуулахад шаардагдах хангалттай нөөц, тогтолцоо, үйл явцыг өрнүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Заавар

- Танай компанийн Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан захирал/захирлууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий эсэхэд хариулт өгнө. Гүйцэтгэх удирдлагын түвшний хүчин чармайлт тогтвортой хөгжлийн бодлогыг батлахаас эхлэх бөгөөд үүнээс ч илүүг хийх ёстой. Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд дээд түвшний удирдлагын дэмжлэг маш чухал. Өдөр бүр биш гэхэд тогтвортой хөгжлийн төлөөх үйлс нь компанийн урт хугацааны бөгөөд чухал үүрэг хариуцлага гэдгийг бүх түвшний ажилтнуудад ойлгуулж удирдан чиглүүлэх нь компанийн дээд түвшний удирдлагын үүрэг юм.
- Танай компанийн Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/БОНЗ-ын асуудал хариуцсан ажилтан/ажилтнууд (бүтэн цагийн/хавсран ажилладаг) бий эсэхэд хариулт өгнө. Байгууллагын дээд түвшний удирдлагын хүчин чармайлтаас гадна тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажиллах багийг томилсон байх хэрэгтэй. Бүх компаниуд бүтэн цагаар ажиллах ийм багийг зохион байгуулах шаардлага байхгүй байж болох ч тогтвортой байдлыг тайлагнах үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх үүднээс удирдлагын зүгээс холбогдох ажлыг гүйцэтгэхэд шаардагдах цаг хугацаа, эрх мэдлийг хуваарилан тодорхой хүмүүст хариуцуулсан байх шаардлагатай.
- Танай компанийн ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг эсэхэд хариулт өгнө. Олон улсын шилдэг туршлагаас харахад ТУЗ нь байгаль орчин, нийгмийн (БОН) асуудлыг хурлаараа тогтмол хэлэлцэх асуудлын нэг болгож байгаа бөгөөд БОН-ийн талаар баримтлах бодлого, стратегийг баталж, гүйцэтгэлийг тогтмол хянаж байх шаардлагатай. Удирдах зөвлөл нь гол оролцогч талуудтай хийж буй яриа хэлэлцээнд хяналт тавьж, үр дүнтэй харилцаа холбоог хангах ёстой. Энэ нь ТУЗ нь БОН-ийн удирдлагын тогтолцоонд үнэлгээ хийх болон БОНЗ-ын эрсдэлийг ойлгох мэргэжлийн туршлагатай байх ёстой гэсэн үг юм.

Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан багийн гишүүд мэргэжил туршлагаараа тэнцвэртэй байх нь бусад байгууллагуудын адил төстэй асуудал хариуцсан баг, хүмүүстэй үр дүнтэй хамтран ажиллах урьдчилсан нөхцөл болж өгнө. Багт байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, үйл ажиллагаа, маркетинг, хүний нөөц, худалдан авалт болон бусад бизнесийн нэгжүүдийн мэдлэг чадвартай мэргэжилтнүүд орох нь зүйтэй. Хамгийн гол нь тал бүрийн чиг үүрэг хариуцсан хүмүүсийг татан оролцуулах нь тун чухал.

Ашиглах материал

Холбогдох эх сурвалжууд

ТОУС 102-22: Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, салбар хороод
 ТОУС 102-24: Удирдах албан тушаалтны нэрийг дэвшүүлэх, сонгох
 ТОУС 102-32: Тогтвортой байдлын тайлагналд Удирдах албан тушаалтны гүйцэтгэх үүрэг
 ТОУС 103 Удирдлагын арга барил
[ОУСК БОНУТ-г хэрэгжүүлэх гарын авлага](#)
[ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл](#)
 ОУСК Компанийн Засаглалын Аргачлал
[ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт](#)

MS4. Тогтвортой байдлын материаллаг байдлын үнэлгээ

Юуны тухай вэ?

Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

MS4.1 Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, улмаар зэрэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар хийсэн материаллаг байдлын процесс, үнэлгээ, матриц танай компанид бий юу? (Тийм/Үгүй)

Яагаад чухал вэ?

Тогтвортой хөгжлийн боломж, эрсдэл нь тухайн компанийн бизнесийн загвар, салбар, үйл ажиллагаа, зах зээлийн байршил зэргээс шалтгаална. Нөлөөлөл нь компани бүрд ихээхэн ялгаатай байж болно. Тогтвортой хөгжлийн асуудал нь компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөөлж болох чиг хандлага, боломж, эрсдэлийг бүрдүүлж байдаг.

<p>Яагаад чухал вэ?</p>	<p>Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ нь тогтвортой байдлын тайлагналын салшгүй хэсэг юм. Энэ нь оролцогч талуудад үнэн зөв мэдээллийг хүргэж үр дүнтэй харилцах боломжийг бүрдүүлэхийн тулд тогтвортой байдлын ямар мэдээллийг тайлагнах шаардлагатай байгааг тодорхойлох үндэс суурь болдог. Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээний үйл явцыг иж бүрнээр нь нээлттэй тайлагнах нь тухайн байгууллага тогтвортой байдлын талаар ямар ойлголттой болохыг харуулаад зогсохгүй оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагчдын зүгээс тухайн байгууллага тогтвортой байдлын асуудлыг хэрхэн удирдаж байгаад чанарын үнэлгээ хийх чухал шалгуур болж өгнө.</p> <p>Байгууллагын тогтвортой байдлын материаллаг асуудлуудыг тодорхойлох үйл явц, үнэлгээ хийхдээ дараах зүйлсийг анхаарна.</p> <ol style="list-style-type: none"> I. Байгууллагын богино, дунд, урт хугацаанд эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх хамгийн чухал эерэг ба сөрөг нөлөөлөл II. Байгууллагын нь богино, дунд, урт хугацаанд түүний бизнесийн загвар, стратеги, мөнгөн гүйлгээнд эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлэх хамгийн чухал эрсдэл, боломжууд
<p>Заавар</p>	<p>Танай компанид эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, улмаар эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар хийсэн материаллаг байдлын үйл явц, үнэлгээ, матриц бий эсэхэд хариулт өгнө.</p> <p>Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ хийх зааврыг Бүлэг 3: Хэрхэн тайлагнах вэ – т үзүүлсэн.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>Холбогдох эх сурвалжууд</p>	<p>ТОУС 102-15: Гол нөлөөлөл, эрсдэл, боломж ТОУС 102-29: Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох, удирдан залах ТОУС 102-46: Тайлангийн агуулга, асуудлын хил хязгаарыг тодорхойлох ТОУС 102-47: Нөлөөллийн асуудлыг жагсаах ТОУС 103-1 Нөлөөллийн асуудлууд, тэдгээрийн хил хязгаарын тайлбар Үнэ цэнийн тайлагналын сан ТБНББСЗ-ийн стандарт ОУСК БОНУТ-г хэрэгжүүлэх гарын авлага ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл</p>

MS5. Чадавх бүрдүүлэлт

<p>Юуны тухай вэ?</p>	
<p>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>MS5.1 Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн асуудлаарх сургалтад жилд зарцуулсан дундаж хугацаа (цаг), хүйсээр</p>
<p>Яагаад чухал вэ?</p>	<p>Байгальорчин, нийгэм эсвэл тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоо (БОНУС, Удирдлагын тогтолцоо) нь батлагдсан бодлого, журам дүрмээс илүү өргөн хүрээг хамарна. Удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд танай компани бүх түвшинд бэлтгэгдсэн, тууштай ажиллах хүний нөөцтэй байвал зохино. Ингэхдээ сургалтын дэвшилтэт арга техникийг ч үүнд ашиглах хэрэгтэй. Эхний ээлжид сургалтууд нь оролцогчдынхоо удирдлагын тогтолцооны талаарх үндсэн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэх нь зүйтэй. Дараа нь сургалтанд оролцогчдын зүгээс тогтолцоог хөгжүүлэхэд оруулах хувь нэмрийг дэмжихийн зэрэгцээ тэдэнд тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх талаар зааж сургах хэрэгтэй.</p>
<p>Заавар</p>	<p>Тайлангийн хугацаанд зохион байгуулсан нэг ажилтанд ногдох удирдлагын тогтолцооны талаарх сургалтад зарцуулсан дундаж хугацаа (цаг)-г тодорхойлно. Үүнд дараах томъёог ашиглана:</p> <p>Нэг ажилтанд ногдох удирдлагын тогтолцооны талаарх сургалтад зарцуулсан дундаж хугацаа (цаг) = Нийт ажилтанд зориулан зохион байгуулсан удирдлагын тогтолцооны талаарх сургалтад зарцуулсан нийт хугацаа / Нийт ажилтны тоо</p>

Заавар	Бололцоотой бүхий л тохиолдолд нэг ажилтанд ногдох удирдлагын тогтолцооны талаарх сургалтад зарцуулсан дундаж хугацаа (цаг)-г тодорхойлж байх хэрэгтэй.	
	Сургалтын агуулгад оруулбал зохих гол ойлголтуудын талаар доорх хүснэгтэд тоймлон үзүүлээ.	
	Сургалтын зорилго	Сургалтын сэдэв
	Заавал мэдвэл зохих ТХУТ-ны талаарх асуудлыг оролцогчдод танилцуулах	ТХУТ гэж юу вэ? ТХУТ-ны зорилгууд гэж юу вэ? Бид юу хийх шаардлагатай вэ?
ТХУТ нь зайлшгүй шаардлагатай төдийгүй компанийн үйл ажиллагааг сайжруулах талаар оролцогчдод ойлгуулах	Манай компанид яаж туслах вэ? Манай газарт яаж туслах вэ? Юу өөрчлөгдөх вэ? Эндээс би ямар үр ашиг хүртэх вэ?	
Өөрийн үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд нь шаардагдах үр чадвар, мэдлэгийг оролцогчдод олгох	Шинэ бодлого, журам гэж юу вэ? Би чухамдаа юу хийх шаардлагатай вэ? Би хэрхэн яаж хийх вэ? Би түүнийг хийхгүй бол юу болох вэ?	
Гүнзгийрүүлсэн сургалтыг багаар зохион байгуулахаас гадна компанийн ажилтан нэг бүрийн мэдлэгийг сайжруулах сургалт зохион байгуулж удирдлагын тогтолцооны зорилгын талаар нийтлэг ойлголтыг хэвшүүлсэн байх шаардлагатай.		

Ашиглах материал

Чухал эх сурвалжууд

ТОУС 102-16: Үнэт зүйлс, зарчмууд, стандартууд, ёс зүйн хэм хэмжээ
ОУСК БОНУТ-г хэрэгжүүлэх гарын авлага
[ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл](#)

MS6. Хяналт шинжилгээ

Юуны тухай вэ?

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд

MS6.1 Аудитын хороо (эсвэл ижил төстэй удирдах зөвлөлийн хороо)-ны хийх ажлын хүрээ, дотоод хяналтын чиг үүрэгт тогтвортой хөгжлийн асуудал хамаардаг уу?

Яагаад чухал вэ?

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм. Учир нь эдгээр хоёр үйл ажиллагааны үр дүнд тогтолцоогоо шалгах, засч сайжруулах боломж бүрдэнэ. Үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилт, дүрэм журам зохих ёсоор мөрдөгдөж байгаа эсэхэд та хяналт шинжилгээ хийж байх ёстой. Түүнчлэн танай ТХУТ эн тэргүүнд анхаарвал зохих эрсдэлийн асуудлыг шийдэж, компанидаа ахиц дэвшил авчирч байна уу гэдэгт анхаарал хандуулах шаардлагатай.

Заавар

Тогтвортой хөгжлийн асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг эсэхэд хариулт өгөх.

Мөн санхүүгийн бус болон тогтвортой байдлын мэдээллийн чанарыг хангахад аудитын хорооны гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тайлбарлана. Урамшууллын дотоод тогтолцоо, үүнд аливаа гүйцэтгэлийн хэмжүүр, материаллаг тогтвортой байдлын зорилтуудыг цалин хөлсний бодлогод тусгах зэрэг багтана.

Ашиглах материал

Чухал эх сурвалжууд

ТОУС 102-31: Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн сэдвүүдийн тойм
ОУСК БОНУТ-г хэрэгжүүлэх гарын авлага
[ОУСК БОНУС-ын арга хэрэгсэл](#)

MS7. Тогтвортой байдлын тайлагнал

Юуны тухай вэ?	
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	<p>MS7.1 Танай компани тогтвортой байдлын тайланг (тусгайлан/буюу жилийн тайланд нэгтгэж) хамгийн багадаа жилд нэг удаа гаргадаг уу? (Тийм/Үгүй)</p> <p>MS7.2 Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын стандарт (УАӨСМТАХ & БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу? (Тийм/Үгүй)</p> <p>MS7.3 Тогтвортой байдлын талаарх мэдээлэлдээ хараат бус гуравдагч этгээдээр баталгаа гаргуулдаг уу? (Тийм/Үгүй)</p>
Яагаад чухал вэ?	Тогтвортой байдлын эрсдэл, нөлөөлөл, аюул заналхийллийг хэрхэн үнэлж, хяналт тавьж байгаа төдийгүй илүү тогтвортой, үр дүнтэй, амжилттай ажиллах боломжийг байнга эрэлхийлж байгаа тухайгаа баримтжуулж, байгууллагынхаа оролцогч талуудад ил тод мэдээлж буй тайлагналын систем нь тогтвортой байдлын удирдлагын хүчтэй тогтолцооны гол дэмжлэг байдаг.
Заавар	<p>Танай компани тогтвортой байдлын тайланг (тусгайлан/эсвэл жилийн тайланд нэгтгэж) хамгийн багадаа жилд нэг удаа гаргадаг эсэхээ тайлбарлана. Тайланг компанийн жилийн хурлаас өмнө цаг тухайд нь нийтлэх шаардлагатай. Лавлагаа эх сурвалжийг үзэж болох холбоосыг оруулсан байх хэрэгтэй.</p> <p>Танай компани байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг эсэхээ тодорхой тайлагнана. Лавлагаа эх сурвалжийг үзэж болох холбоосыг оруулсан байх хэрэгтэй.</p> <p>Танай компанийн тогтвортой байдлын мэдээлэлд гуравдагч этгээд баталгаа гаргасан эсэхийг тайлбарлаж бичнэ. Хэрэв танай байгууллагын тогтвортой байдлын тайланд хөндлөнгийн байгууллага баталгаа гаргасан бол холбогдох тайлан, баталгаа гаргасан мэдэгдэл, эх сурвалжийг үзэж болох холбоос буюу эх сурвалжийг тодорхой тэмдэглэсэн байх хэрэгтэй. Баталгаа гаргасан Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг (KPI) илүү тодруулж өгөх нь зүйтэй.</p>
Ашиглах материал	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 102: Ерөнхий тодруулгууд</p> <p>ТОУС 102-56: Хөндлөнгийн баталгаа</p> <p>IIRC Олон улсын нэгдсэн тайлагналын зөвлөл</p> <p>ТБНББСЗ Стандарт</p> <p>ISSB Олон улсын тогтвортой байдлын стандартын хороо</p> <p>УАӨСМТАХ - Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсгийн зөвлөмж</p> <p>БОТСМТАХ Байгаль орчны асуудлаарх санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсгийн зөвлөмж</p> <p>НЯМТ Нүүрстөрөгч ялгаруулалтыг ил тод тайлагнах төсөл</p> <p>ОУСК Мэдээллийг нээлттэй ил тод тайлагнах арга зүйн лавлах</p> <p>ТХЗ-ын Нөлөөллийн Стандарт</p> <p>ТХЗ 12.6, ТХЗ 13</p>

MS8. Гишүүнчлэл

Юуны тухай вэ?	
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	MS8.1 Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг (бизнес, хүний эрх гэх мэт) олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?
Яагаад чухал вэ?	Тогтвортой байдлын чиглэлээр ажилладаг холбоод, сүлжээнд гишүүнчлэлээр орсноор нь оролцогч талуудад компанийн тогтвортой байдлыг байгууллагынхаа хүрээнд нэгтгээд зогсохгүй холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах замаар салбарын, үндэсний болон дэлхийн түвшинд тогтвортой байдлын асуудлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна.

Заавар	<p>Байгууллагынхаа идэвхтэй хамтран ажилладаг тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмлэг, холбоод, сүлжээ, үндэсний болон олон улсын түвшний нөлөөлөл сурталчилгааны байгууллагуудын тоог тодорхойлж тайлбарлана.</p> <p>Байгууллагууд зарим тохиолдолд тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмлэг, холбоод, сүлжээ, нөлөөлөл сурталчилгааны байгууллагууд зэрэгт удирдах зөвлөл, төсөл, хороодод нь орж хамтран ажиллах, гишүүнчлэлийн татвараас бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг. Байгууллага нь гишүүнчлэлээ тухайн нийгэмлэг холбоодын эрхэм зорилго, зорилтод нөлөөлөх стратегийн ач холбогдолтой хэмээн үзэж хамтран ажиллах нь өөрийн байгууллагын үйл ажиллагаанд ч чухал ач холбогдолтой байх боломжтой юм.</p>
Ашиглах материал	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 102 ТХЗ 17 Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэл</p>

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тогтвортой хөгжлийн байгаль орчны хэмжүүр нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй амьд болон амьгүй биет, экосистемд үзүүлэх нөлөөллийг илэрхийлдэг. Байгаль орчны орц (эрчим хүч, ус гэх мэт) болон гарц (хүлэмжийн хийн ялгарал, усны бохирдол, хог хаягдал гэх мэт)-тай холбоотой нөлөөлөл хамаарна. Түүнчлэн биологийн олон янз байдал, үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой нөлөөлөл, байгаль орчны хууль тогтоомжийн мөрдөлт, зарцуулалт зэрэг ч мөн орно.

Өсөн нэмэгдэж буй оролцогч талуудад байгаль орны эрсдэл улам бүр чухал болж байна. Тухайлбал, Монгол Улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс байгаль орчны хэтийн төлөвт өндөр эрсдэл учруулж болзошгүй салбарт үйл ажиллагаа явуулж буй аливаа байгууллагыг санхүүжүүлэхдээ өргөтгөсөн хэлбэрээр магадлан үнэлгээ (дью дилиженс) хийх нь түгээмэл болсон. Үнэлгээний байгууллагууд ч бас байгаль орчны асуудал болон тухайн компанийн байгаль орчны эрсдэлийг удирдах чадавхад үнэлгээ хийж дүгнэлт гаргаж байна. Компаниуд ч өөрийн үйл ажиллагааны болон санхүүгийн чадавхад аль алинд нь сөргөөр нөлөөлж болзошгүй байгаль орчны эрсдэлийг судлахын тулд өөрсдөө ч магадлан үнэлгээ хийдэг болсон. Байгаль орчны удирдлага сул байх аваас эрсдэлийг нэмэгдүүлэх, компанийн нэр хүндийг унагах, санхүүгийн байдлыг доройтуулах зэрэгт хүргэж болзошгүй юм.

Байгаль орчны асуудлыг нухацтай тооцсон тогтвортой хөгжлийн удирдлагын сайн тогтолцоог бүрдүүлснээр компаниуд өөрийн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй байгаль орчны нөлөөллийг бууруулахад тууштай ахиц гаргаж, ногоон бизнес, инновацын хөгжүүлэх боломж бий болно.

Компаниудын тайлагнах боломжтой байгаль орчны нийтлэг үзүүлэлтүүдийн багцыг дараах хэсэгт тоймлон орууллаа.

Е1. Эрчим хүч

Яагаад чухал вэ?	<p>Эрчим хүчний эх үүсвэрийг хэрхэн сонгож байгаагаар нь тухайн байгууллагын байгаль орчны ул мөрийг зарим талаараа тодорхойлж болно. Эдгээр эх үүсвэрийг тэнцвэртэй ашиглах чиглэлд гаргаж байгаа өөрчлөлтөөс нь тухайн байгууллагын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах хүчин чармайлт илэрч байдаг. Эрчим хүчийг илүү үр ашигтайгаар ашиглах болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг сонгох зэрэг нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, улмаар байгууллагынхаа байгаль орчны ул мөр, холбогдох зардлыг бууруулахад чухал ач холбогдолтой.</p>
-------------------------	---

<p>Яагаад чухал вэ?</p>	<p>Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиар эрчим хүчний хэрэглээгээ бууруулж, жил бүр эрчим хүчний аудит хийлгэж тайлагнаж байхыг эрчим хүчний томоохон хэрэглэгчдэд үүрэг болгосон. 2020 оны байдлаар энэ хуулийг дагаж мөрдөх үүрэг бүхий 229 аж ахуйн нэгж Designated Entities үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ирэх жилүүдэд энэ тоо нэмэгдэх төлөвтэй байна. Зарим байгууллагын хувьд цахилгаан эрчим хүч нь тэдний эрчим хүчний хэрэглээний цорын ганц эх үүсвэр болж байна. Бусад олон байгууллагын хувьд нүүрс, байгалийн хий зэрэг нь эрчим хүчний гол эх үүсвэр нь байх жишээтэй. Дахин үл сэргээгдэх түлшний хэрэглээ нь хүлэмжийн хий (XX)-н шууд ялгаруулалтад ихээхэн нэрмээс болж байгаа бөгөөд үүнийг Үзүүлэлт E2-д тусгасан болно.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд</p>	<p>E1.1 Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ (кВтц) болон зардал (төг) E1.2 Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ(кВтц), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар) E1.3 Дулааны эрчим хүчний нийт хэрэглээ(Гкал, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар) E1.4 Түлшний нийт хэрэглээ (нүүрс, газрын тос, байгалийн хий гэх мэт) (Литр, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар)</p>
	<p>E1.5 Сэргээгдэх эрчим хүч (СЭХ)-нээс бусад буюу хүрэн эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувийн жин (%) E1.6 СЭХ хэрэглээний хувийн жин, СЭХ эх үүсвэрийн төрөл (%)</p>
<p>Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)</p>	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний үйлдвэрлэлийн эрчмийн коэффициент, орлогоор, үйлдвэрлэлээр, нэг ажилтанд ногдох, нэгж талбайд ногдох, гэх мэт (кВтц) - Эрчим хүчний хэмнэлтийг сайжруулснаар хэмнэгдсэн зардал (төг) - Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тоо мэдээллийг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, бизнесийн нэгж, байгууллага, эх үүсвэрийн төрөл зэргээр задалж гаргах.
<p>Удирдлагын арга барил</p>	<p>Эрчим хүчний хэрэглээг тооцох, улмаар эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлээр компанийн зүгээс баримталсан удирдлагын арга барил, санаачилгууд, ашигласан стандартууд, аргачлал арга зүй, төсөөлөл таамаглал, тооцооллын арга хэрэгслүүд зэргийн талаар тодорхой тайлагнана.</p>
<p>Заавар</p>	<p>Энэ үзүүлэлт нь компанийн нийт эрчим хүчний хэрэглээ болон үйл ажиллагаа, бизнесийн бусад үйл ажиллагаанд эрчим хүчийг үр ашигтай ашиглах талаар ямар арга хэмжээ авсан тухай мэдээллийг илэрхийлнэ. Ингэхдээ байгууллагынхаа хэрэглэсэн эрчим хүчний эх үүсвэрийн төрлийг (түлш, цахилгаан, дулаан, уурын эрчим хүч) киловатт/цаг, төг/m³, төг/Гж зэрэг хэмжигдэхүүнээр тодорхойлно. Эрчим хүчийг өөрийн үйлдвэрлэлээс (өөрөө үйлдвэрлэдэг бол) болон гадаад эх үүсвэрээс худалдаж авдаг байж болно. Эрчим хүчний нийт хэрэглээг дараах томъёог ашиглан тооцно. Үүнд:</p> <p style="text-align: center;">Байгууллагын өөрийн эрчим хүчний нийт хэрэглээ =</p> <p style="text-align: center;">Үл сэргээгдэх түлшний хэрэглээ + Сэргээгдэх түлшний хэрэглээ + Худалдаж авсан цахилгаан, дулаан, уурын эрчим хүч + Өөрийн үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, хөргөлт, уурын эрчим хүч – Нийт гадагш худалдсан цахилгаан, дулаан, хөргөлт, уурын эрчим хүч</p> <p>Хүрэн түлшний эх үүсвэрт тухайн байгууллагын эзэмшлийн буюу хяналтад байдаг уурын тогоо, пийшин, халаагуур, турбин хөдөлгүүр, дохиолол, шатаах зуух, цахилгаан үүсгүүр, тээврийн хэрэгсэл зэрэгт зориулсан түлш орно. Хүрэн түлшний эх үүсвэрт мөн гаднаас худалдаж авсан түлш болон байгууллагын үйл ажиллагаанаас бий болгосон түлш хамаарна. Сэргээгдэх түлшний эх үүсвэрт байгууллагын эзэмшлийн болон хяналтад байдаг эх үүсвэрүүд болон нар, ус, салхи, био эрчим хүчний эх үүсвэрүүд хамаарна.</p> <p style="text-align: center;">Түлшний нийт зарцуулалтын хэмжээ =</p> <p style="text-align: center;">Халаах зорилгоор хэрэглэсэн түл буюу нүүрс, хий + Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель</p>

Заавар	Эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний хэрэглээг бууруулж эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор тайлангийн хугацаанд хэмнэсэн эрчим хүчийг тооцож гаргана. Ийм төрлийн хөтөлбөрүүд нь бизнесийн үйл явцыг дахин загварчлах, тоног төхөөрөмж болон барилга байгууламжийг эрчим хүчээ хэмнэх зорилгоор өөрчлөн, шинэчлэх, ажилтнуудын дадал зуршлыг өөрчлөх, үйл ажиллагаандаа шинэчлэлт хийх зэрэг хэлбэрээр хэрэгжих боломжтой.
Баримт нотолгоо	Мэдээллийн боломжит эх сурвалжид эрчим хүчний аудит, нэхэмжлэхүүд, эрчим хүчний аудитын хийсэн хэмжилт, тооцоонууд, ханган нийлүүлэгчийн мэдээлэл (шинэ машин механизмын эрчим хүч ашиглалтын техникийн үзүүлэлтүүд, эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шилнүүд гэх мэт) зэрэг хамаарна. Хэмжих нэгжийг тайлагнахдаа нэхэмжлэл, тоолуураас мэдээллийг шууд авах, аль эсвэл үндсэн хэмжүүрийн нэгжээс тайлангийн нэгж рүү хөрвүүлж гаргаж болно.
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	 
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 302 ДНИ/ДТХБЗ ХХ-ийн Протокол, Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын стандарт Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан Эрчим хүчний үнийн бүтэц (ERC)</p> <p>Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан Дулааны эрчим хүчний үнэ тариф Монгол Улсын Засгийн газрын тогтоол: Цахилгаан болон дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм Улаанбаатар хотын Цахилгаан түгээх сүлжээний Цахилгаан эрчим хүчний үнэ тариф тогтоох журам ОУСК Гүйцэтгэлийн Стандарт 3</p>

E2. Хүлэмжийн хийн ялгарал


Яагаад чухал вэ?	Хүний үйл ажиллагаанаас үүсэж буй хийн бохирдол нь ур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр нөлөөлж байна. 2015 онд НҮБ-ын гишүүн 200 шахам улс орны тэргүүд Парис хотноо хуралдаж, 'Дэлхийн агаарын дундаж температурыг <u>цельсийн 2 хэмээс хэтрүүлэхгүй байх, улмаар агаарын дундаж температурын өсөлтийг үйлдвэржилтийн эхэн үеийн түвшинд буюу 1.5 хэмээс хэтрүүлэхгүйгээр хязгаарлахын тулд тууштай хүчин чармайлт гаргах</u> ' зорилго дэвшүүлж уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхээр санал нэгдсэн билээ. Үүний мөрөөр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн хууль тогтоомж, бодлого, зоримог санаачилгууд хүчин төгөлдөр болохын зэрэгцээ олон боломж бий болж байна.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>E2.1 Компанийн шууд (Scope 1) болон шууд бус (Scope 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн нийт ялгарал (метр тонн CO2-эқв)</p> <p>E2.2 Компанийн шууд (Scope 1) болон шууд бус (Scope 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт (метр тонн CO2-эқв)</p> <p>E2.3 Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний үр дүнд бууруулсан нүүрсхүчлийн хийн ялгаруулалт (метр тонн CO2-эқв)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<ul style="list-style-type: none"> - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилт, - Компанийн шууд (Хамрах хүрээ 1) болон шууд бус (Хамрах хүрээ 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал (метр тонн CO2-эқв), эх үүсвэрийн төрлөөр, - Шууд бус үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 2) бусад буюу өртгийн сүлжээнд хамаарах бусад шууд бус үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 3) үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал (метр тонн CO2-эқв) - Хүлэмжийн хийн ялгарлын коэффициент, орлогоор, борлуулалтаар, нэг ажилтанд ногдох, нэгж талбайд ногдох, гэх мэт (метр тонн CO2-эқв)

<p>Удирдлагын арга барил</p>	<p>Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад чиглэсэн стратегийн талаар мэдээлнэ. Ингэхдээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах асуудлаарх төлөвлөгөө, амлалт, зорилт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа, мөн ашиглаж буй стандартууд аргачлал арга зүй, төсөөлөл таамаглал, арга хэрэгсэл зэргийг хамруулна.</p>
<p>Заавар</p>	<p>Энэ үзүүлэлт нь компанийн үйлдвэрлэлийн шатаах ноцоох үйл ажиллагаанаас эхлээд бусад бүхий л үйл явцаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг өөрсдөө хэрхэн хэмжиж, хянаж байгааг илэрхийлнэ. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тайлагнахдаа Дэлхийн нөөцийн институт (WRI) болон Дэлхийн Тогтвортой хөгжлийн төлөөх Бизнесийн зөвлөл (WBCSD)-ийн баталсан 'Хүлэмжийн хийг бууруулах тухай Протоколын Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын стандарт' (ХХБ Протокол) –ыг дагаж мөрдөх шаардлагатай. Киотогийн Протокол болон Хүлэмжийн хийг бууруулах тухай Протокол-д туссан хүлэмжийн хийн төрлүүд нь: Нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), Метан хий (CH₄), Азотын исэл (N₂O), Гидрофтор нүүрстөрөгч (HFCs), Перфтор нүүрстөрөгч (PFCs), Хүхрийн гексафторид (SF₆), Азотын трифторид (NF₃) зэрэг юм.</p> <p>Хүлэмжийн хийг бууруулах тухай Протоколд 'Хамрах хүрээ/Scope' буюу Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, Хамрах хүрээ 3 (Scope 1, Scope 2, Scope 3) гэсэн хүлэмжийн хийн ялгаруулалтын ангиллыг тодорхойлсон. Хамрах хүрээ гэдэг нь хүлэмжийн хийг ялгаруулж байгаа үйл ажиллагааны хил хязгаарыг тодорхойлох ангилал юм. Хүлэмжийн хийн ялгарлыг тухайн байгууллага өөрөө үүсгэж байна уу, аль эсвэл түүнтэй холбоотой бусад байгууллага (цахилгаан эрчим хүч нийлүүлэгч) үүсгэж байна уу гэдгийг зааглаж ангилсан гэсэн үг юм. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> • Шууд үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 1) үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал гэдэгт тухайн байгууллагын эзэмшлийн буюу ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, станц, машин техник, агааржуулагч, уурын тогоо, эрчим хүч үүсгүүр зэргээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал хамаарна. • Эрчим хүч ашиглалтаас буюу шууд бус үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 2) үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал гэдэгт тухайн байгууллагын худалдан авч ашигласан цахилгаан, дулаан, хөргөлт, уурын эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал хамаарна. • Бусад шууд бус үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 3) үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал гэдэгт албан томилолт, санхүүжилт олгох зэрэг тухайн байгууллагын үйл ажиллагаанаас гадуурх бусад үйл ажиллагаанаас (Хамрах хүрээ 2-т хамаарах үйл ажиллагаа орохгүй) үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал хамаарна. Хамрах хүрээ 3-ыг тайлагнах эсэхийг тухайн байгууллага өөрийн үзэмжээр шийдэж болно. <p>Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн нийт ялгарлын тооцоог хийхийн тулд юуны түрүүнд хүлэмжийн хийн ялгарлыг хэрхэн нэгтгэж тооцох аргаа (өмчийн эзэмшил, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтын аргууд) сонгох хэрэгтэй. Үүний дараа байгууллагынхаа эзэмшлийн буюу хяналтад байгаа шууд (Хамрах хүрээ 1) болон шууд бус (Хамрах хүрээ 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг тодорхойлно (Хавсралтаас Хүлэмжийн хийг ялгаруулах эх үүсвэрийн талаарх жагсаалтыг үзнэ үү). Ингээд хүлэмжийн хийг үүсгэж буй эх үүсвэрүүдийг тодорхойлмогц, тэдгээр эх үүсвэр тус бүрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын талаарх тоо мэдээллийг (жишээлбэл, нийт худалдан авсан цахилгаан эрчим хүч, ашигласан нийт нүүрсний хэмжээ гэх мэт) цуглуулах хэрэгтэй. Эцэст нь, ДДТБ/GWP-ын аргачлалаар тодорхойлсон коэффициент болон хүлэмжийн хийн ялгаралд нөлөөлөх хүчин зүйлсийн утгыг ашиглан байгууллагынхаа үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг CO₂-экв хэмжих нэгжээр тооцно.</p> <p align="center">Үйл ажиллагааны холбогдох тоо мэдээлэл * ХХ-ийн ялгаралд нөлөөлөх хүчин зүйлсийн утга = ХХ-ийн ялгарал</p>

<p>Заавар</p>	<p>Хүлэмжийн хийн ялгаралд нөлөөлөх хүчний зүйлсийн утгыг засгийн газрын холбогдох журам заавраас авах боломжтой. Энэ талаар Засгийн газраас гаргасан тодорхой журам заавар байхгүй тохиолдолд тухайн компани нь тайлагналын бусад аргачлал, салбарын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хэрэглэгдэж байгаа хүлэмжийн хийн ялгаралд нөлөөлөх хүчин зүйлсийн тооцооны утгыг ашиглаж болно. Шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хөгжихийн хэрээр GWP-ийн тооцоо байнга өөрчлөгдөж байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын зөвлөлөөс (IPCC) гаргадаг Үнэлгээний тайлангуудаас ДДТБ/GWP-ын аргачлалаар тооцсон коэффициентуудыг компаниуд авч ашиглаж болно. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцох нь харьцангуй хялбар мэт боловч тооцоо хийх, тоон мэдээллийн хэмжих нэгжийг хөрвүүлэх ажлыг сайтар төлөвлөх шаардлагатай. Хүлэмжийн хийн ялгарлын тооцоог хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хүлэмжийн хийг бууруулах Протокол-оос үзэх боломжтой.</p> <p>Карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээнд тухайн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй хүлэмжийн хийн ялгарлын тооцоог хийж, улмаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн төслүүдээс зээл авах ажил ч мөн хамаарна. Ийм төслүүд нь өөр хаа нэгэн газар ялгарах нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний нүүрстөрөгчийн давхар ислийн бохирдлоос урьдчилан сэргийлэх буюу арилгах боломж олгоно. Иймээс карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний талаар тусад нь тодорхой тайлагнах хэрэгтэй.</p> <p>Хэрэв ХХ ялгаруулалтыг бууруулах зорилт тавьсан бол үүнийгээ мөн дурдахыг онцгойлон дэмжиж байна.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Компаниуд өөрийн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй хүлэмжийн хийн ялгарлын тооцоог хийхдээ гаднын байгууллага, зөвлөхүүдийн туслалцааг авч болох бөгөөд өөрийн хүчийг ашиглан дотооддоо ч хийж болно. Үйл ажиллагааны талаарх тоо мэдээллийн боломжит эх сурвалжуудыг Эрчим хүчний үзүүлэлт хэсэгт оруулсан болно.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>Холбогдох ТХЗ</p>	 
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ТОУС 302 ДНИ/ДТХБЗ ХХ-ийн Протокол, Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын стандарт IPCC Үнэлгээний тайлан 6 UNFCCC, Монгол Улсын Хүлэмжийн хийн тооллогын тайлан (2017) УАӨСМТАХ Зөвлөмжүүд Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал (Зөвлөмж) Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хэмжих, тайлагнах, нотлох Гарын авлага South Pole зөвлөх компани, БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр ХХБ, ToC Холбоо хамтран боловсруулсан Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тооцоолол (ER Tool) Хүлэмжийн хийн протокол</p>


Е3. Уур амьсгалын өөрчлөлт

<p>Яагаад чухал вэ?</p>	<p>Цаг агаарын эрс тэс үзэгдэл, агаарын температурын өсөлт зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтөд эрсдэл учруулах томоохон аюулын нэг болж байна. Эрсдэл нэмэгдэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалсан боломжууд ч бас гарч байна. Эдгээр эрсдэл, боломжуудыг дагаад олон компаниуд өөрсдийн бизнесийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн цар хүрээ, үр дагаврыг хэдийнээ судалж тайлагнах болсон. Санхүүгийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчид ч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодитой шийдвэр гаргахад тус болохуйц үнэн зөв, ил тод, харьцуулж болохуйц мэдээлэл авахыг ч мөн шаардаж эхэлсэн²³.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>E3.1 Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн бодлого бий юу? (Тийм/Үгүй) E3.2 Танай компани уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл болон боломжийн талаар үнэлгээ (олон хувилбартай дүн шинжилгээ, стресс тест гэх мэт) хийсэн үү? (Тийм/Үгүй) E3.3 Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, онцгой тохиолдлуудын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ (төг) E3.4 Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн дэд бүтэц, дасан зохицох, бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд жилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн (төг) E3.5 Танай компани уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу? (Тийм/Үгүй)</p>
<p>Нэмэлт үзүүлэлтүүд, сонголтоор)</p>	<p>Уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицож даван туулах технологи, дэд бүтэц буюу удирдлагын арга барилыг сайжруулах зэрэгт оруулсан нийт хөрөнгө оруулалт (сая төг)</p>
<p>Удирдлагын арга барил</p>	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломжуудыг удирдахад шаардагдах гүйцэтгэх эрх үүрэг, хүлээх хариуцлага, үйл явц, баталгаа гаргах зэрэг компанийн засаглалын арга барилтай холбоотой мэдээлэл, • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломжуудыг удирдахад шаардагдах төлөвлөгөө, амлалт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа зэргийг хамруулсан компанийн стратеги, • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг хэрхэн тодорхойлж, үнэлгээ хийж, удирдаж байгаа талаарх мэдээлэл, • Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломжуудад үнэлгээ хийх, удирдахад компанийнхаа ашиглаж байгаа хэмжүүр, зорилтуудын талаарх мэдээлэл зэргийг тус тус тодорхой тайлагнана.
<p>Заавар</p>	<p>Энэ үзүүлэлт нь Удирдах зөвлөлийн зүгээс тавьж буй ерөнхий хяналт, удирдлага зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломжуудын талаар танай компанийн баримталж буй байр суурь, бодлогыг илэрхийлнэ. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг биет болон шилжилтийн гэж ангилж болно.</p> <p>Шилжилтийн эрсдэл гэдэг нь хүлэмжийн хий бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийг даван туулах чадвартай эдийн засагт шилжих явцад компанид учирч болох эрсдэл юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бодлого, хууль тогтоомжийн зохицуулалттай холбоотой эрсдэлүүд, тухайлбал, эрчим хүчний хэмнэлттэй байх шаардлагууд, түүхий түлшний үнийг өсгөдөг нүүрсстөрөгчийн ялгаралд үнэ тогтоох механизм, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тайлагнах эрх зүйн шинэ зохицуулалт бий болох зэргээс үүдэх эрсдэлүүд, • Технологийн эрсдэлүүд, жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтийг ихээхэн өдөөж хор хохирол учруулж байгаа технологийг бага хохирол учруулах технологиор орлуулан солих явцад үүсэх эрсдэлүүд.

<p>Заавар</p>	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн эрсдэлүүд, тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтөд бага хохирол учруулах бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгосноор хэрэглэгчид болон бизнесийн үйлчилгээ хүртэгчдийн сонирхол өөрчлөгдөх явцад гарах эрсдэлүүд, Нэр хүндтэй холбоотой эрсдэлүүд, тухайлбал, хэрэв компанийн үйл ажиллагаа байгаль орчныг сүйтгэх нөлөөтэй хэмээх ойлголт төрүүлсэн тохиолдолд тухайн компани үйлчлүүлэгчид, ажилчид, бизнесийн түншүүд, хөрөнгө оруулагчдыг татах, улмаар хамтран ажиллахад бэрхшээлтэй байх болно. <p>Биет эрсдэл гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн физик нөлөөллөөс үүдэж компанид учирч болох эрсдэл юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Салхи шуурга, үер, гал түймэр, хэт хүйтрэх, хэт халуун болох зэрэг цаг агаартай холбоотой гамшигт үзэгдлүүдээс болж үйлдвэрлэлийн барилга байгууламжид гэмтэл хохирол учрах, өртгийн сүлжээ тасалдах зэрэг хүнд хэлбэрийн биет хохирол гарах эрсдэл. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө удаан хугацаагаар үргэлжлэх, тухайлбал агаарын температур өөрчлөгдөх, далайн түвшин нэмэгдэх, усны нөөц багасах, биологийн олон янз байдал алдагдах, газар, хөрсний үржил шим алдагдах зэргээр ужгирсан хэлбэрийн биет хохирол гарах эрсдэл зэрэг хамаарна. <p>Нөгөө талаас, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах буюу дасан зохицоход хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож буй компаниуд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийг ихэвчлэн боломж болгон хувирган ашиглах тохиолдол бий.</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, тэдгээрээс учирч болох хохирлоос урьдчилан сэргийлж, сааруулахын тулд зохих арга хэмжээ авахыг хэлнэ. Тухайлбал, хэдийнээ хомсдоод байгаа усны нөөцийг илүү үр ашигтай ашиглах шинэ технологи нэвтрүүлэх, үерийн хамгаалалтын байгууламжийг шинээр барих зэрэг бизнесийн боломжуудыг нэрлэж болно. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэдэг нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулахтай холбоотой бизнесийн боломжуудын жишээнд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй барилга, тээврийн тогтолцоог хөгжүүлэх зэргийг нэрлэж болно. Олон улсын таксономийн (Европын холбоо, Хятад) адил Монгол Улсын Ногоон Таксономи нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой боломжуудыг тодорхойлж, ангилсан. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг TCFD зөвлөмжөөс үзнэ үү.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөдөлгөөнд нэгдэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах боломжтой.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Компанийн дотоод бодлого, баримт бичгүүд. Уур амьсгалын өөрчлөлтийн биет нөлөөллийн талаарх мэдээллийг барилга байгууламж, эрсдэл/тогтвортой байдлын асуудал хариуцсан газар, нэгжүүд, даатгалын гэрээнүүд зэргээс авах боломжтой.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>Холбогдох ТХЗ</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ТОУС 201 УАУХЗ Үнэлгээний тайлан-6 (IPCC Sixth Assessment Report) УАӨСТАХ Зөвлөмжөөс (TCFD Recommendations) Үнэ цэнийн тайлагналын сан ТБНБСЗ Дэлхийн эдийн засгийн форум (World Economic Forum) IFRS Climate-related Disclosure Prototype Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал (Зөвлөмж) Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хэмжих, тайлагнах, нотлох Гарын авлага НЯМТ Асуулга Хүлэмжийн хийн протокол НҮБ-ийн Тогтвортой Хөрөнгийн Биржийн Загвар, Уур амьсгалын өөрчлөлтийг ил тод тайлагнах удирдамж Шинжлэх ухаанд суурилсан зорилтууд (Science-based targets)</p>


Е4. Ус

Яагаад чухал вэ?	Ус бол хүний хөгжил, хөдөө аж ахуй, аж үйлдвэр зэрэг салбарт зайлшгүй шаардлагатай нөөц билээ. Ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн асуудлыг НҮБ хүний эрхийн асуудал хэмээн үздэг. Монгол Улсын хувьд цэвэр, цэнгэг ус улам бүр хомсдохын хэрээр аж ахуйн нэгжүүдийн усны хангамж тасалдах, өртөг зардал нь ч нэмэгдэх зэрэг эрсдэл бий болж байна. Иймээс цэвэр усны нөөцийг хамгаалах, усыг үр ашигтай олборлох, хэрэглэх, усны чанарыг хамгаалах, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг усны нөөцийн үр дүнтэй удирдлагын тогтолцоо чухал юм. Олон арван компаниуд усны удирдлагын стратегиа боловсруулж, усны хомсдолоос үүсэх эрсдэлийн удирдлагын талаарх ойлголт мэдлэгээ сайжруулж, усны технологийг хөгжүүлэх, усыг дахин ашиглах, усны өөр эх үүсвэрийг (үйлдвэрлэсэн ус гэх мэт) ашиглах зэргээр усны удирдлагын хамтын оролцооны арга хэлбэрийг аж үйлдвэр болон бусад салбарын хүрээнд хөгжүүлж байна.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	<p>E4.1 Ашигласан усны нийт хэмжээ (Л, м³), эх үүсвэрээр E4.2 Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ (Л, м³) E4.3 Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь (%) E4.4 Хаяж зайлуулсан бохир усны нийт хэмжээ (Л, м³)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<p>- Нэг бүтээгдэхүүн/үйлдвэрлэлд ногдох усны хэрэглээ - Хамгаалалтад авсан усны нийт хэмжээ (%) - Ус олборлолтоос эрсдэлд орсон усны эх үүсвэрүүд</p>
Удирдлагын арга барил	Усны хэрэглээг бууруулахад чиглэсэн компанийн удирдлагын арга барил, санаачилга, ашигласан стандарт, аргачлал арга зүй, төсөөлөл, арга хэрэгсэл зэргийг тайлагнана.
Заавар	<p>Энэ үзүүлэлт нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд болон ерөнхий зориулалтаар ашигласан усны хэрэглээ, үр ашгийг илэрхийлнэ.</p> <p>Байгууллагын өөрөө олборлож ашигласан болон ус хангамжийн байгууллага зэрэг бусад байгууллагаар дамжуулан ашигласан усны нийт хэмжээг тодорхойлно. Усны нөөцөд дараах нөөц хамаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Гол, нуур, намгархаг газрын зэрэг гадаргын ус, • Гүний ус, • Байгууллагын өөрийн шууд болон хуримтлуулж ашигласан борооны ус, • Бусад байгууллагын хаягдал бохир ус, • Хот, орон нутгийн ус хангамжийн болон бусад ус түгээх байгууллагын олборлосон ус. <p>Түүнчлэн дахин боловсруулсан болон дахин ашигласан усны хэмжээг тодорхойлно. Усны болон урсгалын тоолуур байхгүй тохиолдолд загварчлал ашиглан тооцох шаардлагатай.</p> <p>Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хаягдал бохир усыг асгаж зайлуулсан тохиолдолд хааш нь асгаж нийлүүлсэн болон хэрхэн цэвэршүүлсэн талаар тайлбарлах хэрэгтэй. Бохир ус зайлуулах болон боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд усны чанарын талаар Биологийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (BOD) буюу Нийт түдгэлзүүлсэн хатуу бодис зэрэг бохир усны стандарт параметруудийг ашиглан бохир усны нийт хэмжээг тооцож тайлагнах хэрэгтэй. Тухайн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хамаарч усны чанарын параметруудийг ялгаатайгаар сонгоно.</p>
Баримт нотолгоо	Байгууллагын ус ашиглалтын талаарх мэдээллийг усны аудит, усны тоолуур, усны төлбөрийн нэхэмжлэх, усны талаарх бусад мэдээлэл болон байгууллагын өөрийн тооцооноос гаргаж авч болно. Тухайн байгууллагын хаягдал усны талаарх мэдээллийн гол эх сурвалж нь урсгал хэмжигч буюу тоолуур (усны хоолойн тодорхой цэгүүдэд буюу ус зайлуулах хоолойд тавьсан) болон холбогдох зөвшөөрөл зэрэг юм.

Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	
Чухал эх үүсвэрүүд	ТОУС 303 ОУСК Гүйцэтгэлийн стандартууд 3


E5. Хатуу хог хаягдал

Яагаад чухал вэ?	Хог хаягдлыг бий болгох, боловсруулах, устгах, улмаар зохисгүй тээвэрлэх зэрэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулах төдийгүй санхүүгийн үр дагаварт хүргэж болзошгүй юм. Хэд хэдэн жилийн хугацаанд бий болсон хог хаягдлын талаарх тоо баримт нь тухайн байгууллага хог хаягдлыг бууруулах талаар ямар хүчин чармайлт гаргаж байгааг нь харуулна. Түүнчлэн үйл явцын үр ашиг, бүтээмжийг сайжруулах боломж байгааг ч харуулах болно. Санхүүгийн талаас нь авч үзвэл хог хаягдлыг багасгаснаар материалын хийгээд боловсруулалт, улмаар устгалын зардлыг ч бууруулахад шууд хувь нэмэр оруулна.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	E5.1 Ялгаруулсан нийт хог хаягдлын хэмжээ, төрлөөр, устгалын аргаар (тонн) E5.2 Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь (%) E5.3 Хортой хог хаягдал (цахилгаан хэрэгслийн хог хаягдал ороод) (тонн)
Нэмэлт үзүүлэлтүүд, сонголтоор	- Нийт бууруулсан хог хаягдлын хэмжээ - Хог хаягдал болон үйлдвэрлэлийн харьцаа - Зорилго, зориулалтыг нь өөрчлөн ашигласан хог хаягдлын харьцаа (жишээ нь, жимс, ургамлын ясан үр, иш үндсийг салгаж ангилж өөр зориулалтаар ашиглах гэх мэт)
Удирдлагын арга барил	Танай компанийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэдэг болон ашигладаг нэр бүхий материал байгаль орчинд нөлөө үзүүлдэг эсэхийг тодорхойлж тайлагнана. Мөн хог хаягдлыг устгах, багасгах, дахин боловсруулах, хог хаягдлыг бий болгохгүй байх зэрэгт чиглэсэн компанийн удирдлагын зүгээс баримталж буй бодлого, санаачилгууд, түүнчлэн аюултай хог хаягдлыг зохицуулах журмын талаар тодорхой тайлбарлана.
Заавар	Хог хаягдлыг аюултай болон аюулгүй хог хаягдал гэж ангилна. <ul style="list-style-type: none"> • Аюулгүй хог хаягдал: Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тухайн үйлдвэрлэл явуулж буй газар дээр болон өөр газар бий болж байгаа үйлдвэрлэлийн хог хаягдал (хатуу болон шингэн). Үүнд үйлдвэрийн байр болон бусад албан тасалгааны хог хаягдал, худалдаа арилжаа, сав баглаа боодолтой холбоотой хог хаягдал зэрэг хамаарна. Харин дээр өгүүлсэн аюултай хог хаягдал энд хамаарахгүй. • Аюултай хог хаягдал: Тухайн улс орон, зохицуулагч байгууллага, эрх бүхий байгууллагаас хортой, аюултай, онцгой гэж тодорхойлсон хог хаягдал юм. Цахилгаан хэрэгслийн хог хаягдал үүнд хамаарна. <p>Аюултай болон аюулгүй хог хаягдлын нийт хэмжээг гаргахдаа хог хаягдлыг зайлуулах доорх аргуудаас тохирохыг нь сонгон ангилан тайлагнана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дахин ашиглах • Дахин боловсруулах • Бордоо болгох • Цэнэглэх, эрчим хүчийг сэргээх • Шатаах (бөөнөөр нь шатаах) • Гүн нүхэнд булшлах • Хогийн цэг дээр хаях • Газар дээр нь хадгалах • Бусад (тодорхой бичих)

Заавар	<p>Хог хаягдлыг зайлуулах аргыг хэрхэн сонгосон талаар тайлбарлаж бичнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын хог хаягдал зайлуулах шийдвэрийн дагуу • Хог хаягдлыг зайлуулах гэрээт байгууллагуудын мэдээллийн дагуу • Хог хаягдлыг зайлуулах гэрээт байгууллагууд үүргээ биелүүлээгүйгээс гэх мэт. <p>Хэрэв хог хаягдлын жин хэмжээний талаарх мэдээлэл байхгүй бол хог хаягдлын нягтрал, цуглуулсан хэмжээ, овор хэмжээг баримжаалах буюу ижил төстэй мэдээллийг ашиглан хог хаягдлын нийт жинг тооцох боломжтой.</p>
Баримт нотолгоо	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид хог хаягдал зайлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд (жишээ нь, албан байгууллагын хог хаягдлыг цуглуулах, гэх мэт) болон байгууллагын дотоод тооцоо, нягтлан бодох бүртгэлийн систем, худалдан авалт, хангамжийн асуудал эрхэлсэн газар хэлтэс зэргээс хийсэн хөндлөнгийн аудитын тайлангууд хамаарна. Түүнчлэн хог хаягдлын хэмжээг хог хаягдал зайлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хог хаягдлыг зайлуулах цэг дээр болон тээвэрлэгчид хог хаягдлыг тээвэрлэх, ачих цэг дээр шууд тогтоож болно.</p>
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 306 ОУСК Гүйцэтгэлийн стандартууд 3</p>

Е6. Биологийн олон янз байдал

Яагаад чухал вэ?	<p>Ургамал, амьтны төрөл зүйлс, экосистем, газар нутгийг хамгаалах нь бизнес эрхлэгчид болон тэдгээрийн ойр орчимд нутаглаж байгаа хүмүүсийн амьжиргаанд чухал нөлөө үзүүлнэ. Компаниудын үйл ажиллагаанаас биологийн олон янз байдалд учруулж болзошгүй шууд, шууд бус болон хуримтлагдах нөлөөллийг тэд хэрхэн яаж удирдах арга барилаа тодорхойлох нь зайлшгүй гэсэн хүлээлт байдаг нь нийтлэг билээ. Биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалд анхаарал хандуулснаар тухайн байгууллагын нэр хүнд сайжирч, байгаль орчин, нөөцийн тогтвортой байдлыг хамгаалах нөхцөл бүрдэж тэдгээрийг түшиглэн оршин суугаа хүн зоны талархлыг хүлээх нь гарцаагүй юм. Биологийн олон янз байдлыг хамгаалах стратеги тухайн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэж байгалийн болон амьтдын амьдрах орчинд учирч болзошгүй хор хохирлоос урьдчилан сэргийлэх, зохицуулах, улмаар хор хохирол учирсан тохиолдолд тэдгээрийг арилгах зэрэг асуудлууд туссан байдаг.</p>
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>Е6.1 Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь (%) Е6.2 Хамгаалагдсан төрөл зүйлийн тоо Е6.3 Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<p>- Сэргээгдсэн амьдрах орчин - Тусгай хамгаалалтад авсан хамгаалалтын өндөр үнэ цэнэ бүхий газар нутгууд</p>
Удирдлагын арга барил	<p>Бодлого, байр суурь, зорилго, стратеги, эрсдэл/нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, үр нөлөө зэрэг биологийн олон янз байдлыг хамгаалах удирдлагын арга барилаа тайлбарлана. Биологийн олон янз байдлыг хамгаалах болон дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлж байгаа газар нутгийн кейс судалгаа буюу жишээг оруулна.</p> <p>Биологийн олон янз байдал, экосистемийн талаарх ойлголтыг сайжруулах, биологийн олон янз байдалд учирч болзошгүй нөлөөллийг шийдвэрлэх зорилгоор хамтран ажиллаж байгаа олон талт хамтын ажиллагаа, түншлэлийн талаар тайлбарлаж бичнэ.</p>

Заавар	<p>Үндэсний хууль тогтоомжийн дагуу компаниуд өөрийн үйл ажиллагааныхаа 20-оос доошгүй хувийг ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайг барьж тохижуулахад зориулах үүрэг хүлээсэн байдаг.</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн хөрш зэргэлдээ газар нутаг, биологийн олон янз байдлын болон соёлын өндөр үнэ цэнэ бүхий газар нутгийн хэдэн хувийг эзэмшиж, түрээсэлж, ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаа тухайгаа болон тухайн газар нутгийн байршлыг тодорхой тайлагнана.</p>
Баримт нотолгоо	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх мэдээллийг тухайн байгууллагын байгаль орчны удирдлагын тогтолцооны баримт бичиг, талбайн төлөвлөгөө, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгууллагын бодлого зэргээс авах боломжтой. Үндэсний хэмжээнд байгаль орчны хадгалалт, хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд нь тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий газар нутгийн талаарх мэдээллийн сантай байдаг.</p> <p>Үндэсний болон бүс нутгийн байгаль хамгаалах байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, байгаль орчны асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагууд нь биологийн олон янз байдлын талаарх мэдээллийг олж болох боломжит эх сурвалжууд юм. Тусгай хамгаалалттай газар нутагт болон түүний хөрш зэргэлдээ биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын төлөвлөлтийн судалгаа болон бусад тусгай зөвшөөрлийн баримт материалд нь тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлын талаарх мэдээлэл мөн туссан байдаг.</p>
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	 
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 304 ОУСК. Гүйцэтгэлийн стандарт 5.6</p>



4.3 НИЙГМИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тогтвортой хөгжлийн нийгмийн шалгуур үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэх нийгмийн хүчин зүйлс үзүүлж буй нөлөөлөлтэй холбоотой. Нийгмийн хүчин зүйлс гэдэгт тухайн компанийн эрх мэдэл, үйл ажиллагаанаас үүдэлтэй ажилтнууд, үйлчлүүлэгчид, тухайн нутгийн хүн амын бүлгүүдийн аж амьдралд нөлөөлж буй байдал хамаарна. Үүнд ажилтнуудтай тэгш шударга харьцах хандлага, ажилтнууд болон хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, суурь үйлчилгээ авах боломж, хүртээмж, нутгийн хүн амд үзүүлэх эдийн засгийн нөлөө, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн амьжиргааг сайжруулах нөхцөл зэрэг багтана. Хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын зүгээс тухайн компани нь хүн амын бүлгүүд, ялангуяа нутгийн уугуул иргэдтэй холбоотой харилцааг хэрхэн зохицуулж байгаа талаар болон ялангуяа КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед энэ нь илүү чухал гэдэгт ихээхэн хүлээлттэй байна.

Компаниудын тайлагнавал зохих нийгмийн асуудлаарх нийтлэг үзүүлэлтүүдийг дараах хэсэгт тоймлон орууллаа.



S1. Хүний нөөц

Яагаад чухал вэ?	<p>Ажилтнууд бол компанийн хамгийн үнэ цэнтэй хөрөнгө билээ. Иймд хүртээмжтэй бодлогоор хандаагүй тохиолдолд, ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл алдагдаж, улмаар ажилтнуудын дунд эргэлзээ, сэтгэл ханамжгүй байдал бий болох, байгууллагын үндсэн үйл ажиллагааны бүтцийг үндсээр нь өөрчлөх зэрэг шаардлага гарч ирнэ. Энэ нь хөдөлмөрийн бүтээмжид шууд нөлөөлөөд зогсохгүй цалин хөлс буурах, шинээр ажилтан авахад илүү их зардал гаргах зэрэгт ч шууд нөлөөлнө. Иймээс ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн тууштай бодлого, журамд тулгуурласан системтэй үйл явцаас компанийн цаашдын амжилт хамаарна.</p>
-------------------------	--

Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>S1.1 Өмнөх жилийнхээс өөрчлөгдсөн үндсэн ажилтнуудын хувийн жин (%)</p> <p>S1.2 Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад шинээр нэмэгдсэн үндсэн ажилтнуудын хувийн жин (%)</p> <p>S1.3 Нэг ажилтанд ногдох сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд, сонголтоор	<ul style="list-style-type: none"> – Гүйцэтгэлийн болон ажил мэргэжлийн өсөлтийн үнэлгээ тогтмол хийлгэдэг ажилтнуудын хувийн жин, хүйсээр – Албан тушаал дэвшсэн ажилтнуудын тоо, хүйсээр – Ажилтнуудын дунд жил бүр явуулдаг сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хүйсээр – Ялгаварлан гадуурхлын тохиолдлын тоо, хүйсээр – Хүүхдийн хөдөлмөрийн тохиолдлын тоо
Удирдлагын арга барил	<p>Ажилтнууд тасралтгүй хөдөлмөр эрхлэхийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олоход нь туслах зорилго бүхий Хүний нөөцийн бодлого, стратеги, бусад хөтөлбөрүүдийн талаар тайлагнана. Эдгээрт сургалтын хөтөлбөрүүд, ажилтнуудыг ажил мэргэжил дээр нь хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд, насан туршийн боловсролын хөтөлбөр, амьдралын даатгал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн хамгааллын (хөгжлийн бэрхшээлийн) хөтөлбөр, хүүхэд асрах чөлөө, өндөр насны тэтгэвэрт гарах, хувьцаа эзэмших зэрэг олон хөтөлбөрүүд хамрагдана.</p>
Заавар	<ul style="list-style-type: none"> • Тайлангийн хугацаанд шинээр ажилд орсон нийт ажилтны тоог тодорхойлно. • Тайлангийн хугацаанд ажлаасаа чөлөөлөгдсөн нийт ажилтны тоог тухайн хугацаанд ажиллаж байсан нийт ажилтны дундаж тоонд хувааж тайлангийн хугацааны ажилтнуудын тогтвор суурьшлын түвшнийг тодорхойлно. • Дараах томъёог ашиглан Тайлант хугацаанд нэг ажилтанд ногдох сургалтын дундаж хугацааг цагаар тодорхойлох: <p style="text-align: center;">Нэг ажилтанд ногдох сургалтын дундаж хугацаа, цагаар = Ажилтнуудын сургалтад зарцуулсан нийт хугацаа, цагаар / Нийт ажилтны тоо</p> • Боломжтой бол дээрх үзүүлэлтийг хүйсээр задалж тооцно.
Баримт нотолгоо	Мэдээллийн боломжит эх сурвалжид ажилтнуудын бүртгэл, сургалтын хуваарь, тайлан хамаарна.
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	 
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 401</p> <p>ОУХБ/ILO Конвенцүүд, стандартууд</p> <p>ОУСБ/ISO Хүний нөөцийн тайлагналын олон улсын стандарт, ISO 30414</p>

S2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Яагаад чухал вэ?	<p>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тодорхойлсноор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) гэдэг нь ажилтнуудын эрүүл мэнд, аж байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй ажлын байран дээр болон ажлын байрнаас үүсэж болзошгүй аюулыг урьдчилан таамаглах, танин мэдэх, үнэлгээ хийх, хяналт тавих үйл ажиллагааг хэлнэ. Эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцөлийг хүний эрх гэж хүлээн зөвшөөрч, үндэсний болон олон улсын хэм хэмжээ, стандартын дагуу байгууллагууд анхаарч ажиллах ёстой. Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нь тухайн байгууллагын ажилтнууддаа анхаарал халамж тавих үүргээ хэрхэн биелүүлж байгаагийн гол хэмжүүр юм. Байгууллагууд нь ажилтнуудынхаа мэдлэг мэдээллийн суурийг өргөжүүлэх, ажиллах хүчин, тэдний гэр бүл, улмаар олон нийтэд урт хугацааны үр өгөөж өгөх сургалт зохион байгуулах замаар аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжин сурталчлах хэрэгтэй. Иймээс хөдөлмөрийн аюулгүй нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгаалалт нь тайлагнавал зохих нөлөөллийн чухал асуудал хэвээр байна.</p>
------------------	--

Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	<p>S3.1 Танай компанид ХАБЭА-н бодлого, журам (тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн) бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>S3.2 Ажил үүрэгтэй холбоотойгоор жилд гарсан осол гэмтлийн тохиолдол, хувиар (%)</p> <p>S3.3 Нэг ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)</p> <p>S3.4 Эрүүл мэндийн үзлэг, сайн дурын эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоо</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<ul style="list-style-type: none"> - Осол гэмтэл, эндэгдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл - Осол гэмтлийн давтамжийн хувь - Хүндрэлийн зэрэг (Severity rate) - Ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн хувь
Удирдлагын арга барил	<p>Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрүүд, сургалтууд, яаралтай тусламж үйлчилгээний үнэлгээ, төлөвлөгөө зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-тай холбоотой бодлого, үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийнхээ талаар тайлбарлана. Аюулгүй нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг удирдан зохицуулах ерөнхий арга барил болон эрсдэлийг бууруулах, гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөөт санаачилга, арга хэмжээнүүдийнхээ талаар тоймлон бичнэ. Удирдлагын тогтолцоо, аудит, баталгаажуулалт, мөн байгууллагынхаа хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх манлайллыг сайжруулах талаар гаргаж буй хүчин чармайлтынхаа талаар тайлагнана. Мөн гарч буй ахиц дэвшил болон хувь хүмүүсийн хөдөлмөр хамгааллыг сайжруулах тоног төхөөрөмжид оруулж буй хөрөнгө оруулалтын талаар тайлагнана.</p>
Заавар	<p>Энэ үзүүлэлт нь хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ аль хэр үр дүнтэй байгааг үйлдвэрлэлийн осол буурснаар хэмжигдэх ёстойг илэрхийлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Бодлого: Энэ нь ажил олгогчийн зүгээс ажилчдынхаа болон ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах талаар бичгээр илэрхийлсэн амлалт юм. Монгол Улсын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж²⁴-ийн дагуу бүх ажил олгогчид ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. • Осол гэмтлийн тоо, хувь: Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах асуудлаас үүдэлтэй осол гэмтлийг бүртгэх, тайлагнах системийг тодорхойлох хэрэгтэй. Энэ систем нь байгууллагын бүхий л үйл ажиллагаа, газар зүйн байршлыг хамарсан байх нь чухал. Зарим тохиолдолд байгууллагын хэмжээнд хэд хэдэн төрлийн системийг ашиглаж болно. Тайлангийн хугацаанд гарсан гэмтэл осол, эндэгдлийн тохиолдлын тоог эдгээр системүүдээс цуглуулж жилээр нэгтгэж гаргана. Боломжтой бүхий л тохиолдолд мэдээллийг хүйсээр задалж гаргах хэрэгтэй. • Сургалтын дундаж хугацаа, цагаар: Дараах томъёог ашиглан Тайлангийн хугацаанд ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалтын дундаж хугацааг, цагаар, хүйсээр тодорхойлно. Үүнд: <p style="text-align: center;">Нэг ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын дундаж хугацаа = Ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалтад зарцуулсан нийт хугацаа /Нийт ажилтны тоо</p> • Эрүүл мэндийн хөтөлбөрүүд: Эрүүл мэндийн үзлэг, эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын эзлэх хувийн жинг тодорхойлно. Эрүүл мэндийн хөтөлбөрийн төрлийн талаар мөн тодорхой тайлбарлана.
Баримт нотолгоо	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид ажилтнуудын бүртгэл, ажилтнуудтай хийсэн гэрээ, ирцийн бүртгэл, осол гэмтлийн бүртгэл, сургалтын хуваарь зэрэг мэдээлэл хамаарна.</p>
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	<div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;"> <div style="text-align: center;">  <p>8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH</p> </div> <div style="text-align: center;">  <p>3 GOOD HEALTH AND WELL-BEING</p> </div> </div>

Чухал эх сурвалжууд	ТОУС 403 ОУХБ Конвенцүүд, стандартууд ОУХБ Үйлдвэрлэлийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бүртгэх, мэдээлэх тухай журам ОУСК Гүйцэтгэлийн Стандарт 2
----------------------------	--

S3. Эрх тэгш байдал

Яагаад чухал вэ?	Байгууллага нь ажилтан бүрийнхээ өвөрмөц шинж байдлыг хүндэтгэх, жендерийн тэгш бус байдлыг арилгах, тэгш боломжийг дэмжих зорилгоор өөрийн үйл ажиллагаа, шийдвэртээ хяналт тавихад идэвхтэй үүрэг гүйцэтгэж чадна. Байгууллагынхаа хэмжээнд эрх тэгш байдлын түвшнийг тогтоосноор тухайн байгууллагын хүний нөөцийн талаар ойлгох нөхцөлийг бүрдүүлнэ. Мэргэшсэн ажилчдыг ажиллах хүчнийхээ эгнээнд үлдээх гол хүчин зүйл бол эрх тэгш байдал юм. Хаана тэнцвэргүй байдал байна тэнд ялгаварлан гадуурхах үзлээс үүдэлтэй компанийн нэр хүнд унах, хууль эрх зүйн асуудал үүсэх эрсдэл учирч байдаг. Иймээс эрх тэгш байдлыг хангахуйц таатай орчныг бүрдүүлэх, зорилгоо тодорхойлох, үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн ахиц дэвшлээ хянах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, бизнесийн үйл хэрэгт дэмжлэг үзүүлэх зэрэг нь аливаа байгууллагын өсөж дэвших үндэс нь болох учиртай.
-------------------------	---

Үзүүлэлтүүд


Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>S4.1 Танай компанид Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)</p> <p>S4.2 Танай компанид Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм /Үгүй)</p> <p>S4.3 Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?(Тийм/Үгүй)</p> <p>S4.4 Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын эзлэх хувийн жин (%)</p> <p>S4.5 Удирдах зөвлөлд эрэгтэй, эмэгтэй гишүүдийн эзлэх хувийн жин (%)</p> <p>S4.6 Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин (%)</p> <p>S4.7 Дунд болон анхан шатны нэгж дэх эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувийн жин (%)</p> <p>S4.8 Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа</p>
--	--

Нэмэлт үзүүлэлтүүд (сонголтоор)	- Албан тушаал дэвшсэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн харьцаа - Хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийн хүйсийн харьцаа
--	--

Удирдлагын арга барил	Ажилтнуудын өвөрмөц ялгаатай байдлыг нь хүндэтгэж оролцоог нь хангахын тулд жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх, дарамт шахалт үзүүлэхгүй байх зэрэг чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, журам зэргийг кейс судалгаа, тодорхой жишээгээр тодорхой тайлбарлана.
------------------------------	--


Заавар	<ul style="list-style-type: none"> Бодлого: Танай компанид Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого, Бэлгийн дарамтын эсрэг бодлого, Ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого зэрэг бодлогын баримт бичгүүд бий эсэхийг тайлбарлана. Хүйсийн тэнцвэрт байдал: Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын түвшин, дунд болон анхан шатны нэгжид ажиллагчдын дунд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эзлэх хувийн жинг тодорхойлно. Зөвхөн бүтэн цагийн ажилтай буюу үндсэн ажилтнуудыг хамруулна. Цалингийн зөрүү: Эмэгтэй болон эрэгтэй ажилтнуудын цалин хөлсийг тодорхойлно. Цалин хөлсийг тооцоходоо тухайн хүйсийн хүмүүсийн авч байгаа дундаж цалингийн хэмжээнд үндэслэнэ. Энэ мэдээллийг ашиглан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж цалин, цалингийн харьцааг тооцно. Ингэхдээ бүх нэмэлт цалин, урамшуулал, нөхөн олговрыг оруулж тооцно.
---------------	--

Баримт нотолгоо	Мэдээллийн боломжит эх сурвалжид ажилтнуудын бүртгэл, цалингийн хэмжээ, төлбөрийн бүртгэл хамаарна.
------------------------	---

Ашигласан материал	
Холбогдох ТХЗ	
Чухал эх сурвалжууд	ТОУС 405 ОУХБ-ын 'Адил тэгш цалин хөлсний тухай' Конвенц №100 Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх тухай зарчмууд ОУСК Жендэрт суурилсан хүчирхийллийн эх сурвалж


S4. Хүртээмжтэй байдал

Яагаад чухал вэ?	Эмзэг бүлгийн хүмүүст хөдөлмөр эрхлэх боломжийг нээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Өөр хоорондоо ялгаа бүхий ажиллах хүчин, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал нь чухал бөгөөд энэ асуудлыг үндэсний хууль журмын дагуу зохицуулж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэдэг нь ажилчид, хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид, хөрөнгө оруулагчид гэх зэрэг бизнесийн түншүүд, мөн тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй нутаг орны хүн амын бүлгүүд, чухамдаа хэн ч байж болно. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирсон хэрэгцээг бизнесийн бүхий л хүрээнд бодолцож идэвхтэй уялдуулахаас эхлээд бизнес эрхлэгчдэд ихээхэн боломж, үр өгөөж нээлттэй байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ч тухайн ажиллаж байгаа байгууллагынхаа онцлог, бүтээлч байдал, ажлын байран дахь ёс суртахууны илэрхийлэл болж байдаг билээ ²⁵ . Энэ бүхнийг хүлээн зөвшөөрч анхдагч болж олон компаниуд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг бизнесийнхээ стратегид тусгаж, шинэлэг ажлууд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж эхлээд байна.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд	<p>S4.1 Та компанид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй)</p> <p>S4.2 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь (%)</p> <p>S4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй хүртээмжтэй орчин бүрдүүлсэн ажлын байр, байгууламж бий юу? (Тийм/Үгүй)</p> <p>S4.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ (төг)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<p>- Хүртээмжтэй гэсэн шошго/үнэлгээ авсан байгууламжийн хувь (%)</p> <p>- Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай бодлого, журмын талаар зохион байгуулсан сургалтын нийт цаг.</p> <p>- 'Бүх хүний хэрэгцээнд нийцсэн загвар' буюу 'нийтлэг загвар' гэсэн санааг агуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо.</p>
Удирдлагын арга барил	Эмзэг бүлгийн хүмүүс, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй барилга байгууламж, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход чиглэсэн арга хэмжээ, санаачилгынхаа талаар тайлагнана. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад тусгай хэрэгцээтэй хүн амын бүлгүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлогын мэдэгдэл, байгууллагын барилга байгууламж нь эдгээр хүмүүсийн тусгай хэрэгцээнд нийцэж байгаа эсэх буюу хүртээмжийн жишиг үнэлгээний үйл ажиллагаа, ажлын байр, хэвлэж нийтэлсэн материалууд, цахим орчин, худалдааны цэг, түгээлтийн цэгийг хүртээмжтэй болгох талаар авсан арга хэмжээ, удирдлага болон нийт ажилтнуудынхаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах талаарх мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалтууд зэрэг хамаарна.

Заавар	<ul style="list-style-type: none"> • Танай компани хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тусгай хэрэгцээтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэж тэднийг үйл ажиллагаандаа оролцуулах боломжийг бүрдүүлэх талаар тусгайлсан бодлого, журамтай эсэх, аль эсвэл эдгээр асуудлыг хүний нөөцийн бодлого, ялгаварлан гадуурхахгүй байх бодлого, худалдан авалтын үйл ажиллагааны бодлого гэх зэрэг бодлогын баримт бичигтээ тусгаж нэгдсэн бодлого баримталдаг эсэхийг тайлбарлаж тайлагнана. • Байгууллагынхаа хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын тоог гаргаж, нийт ажилтны тоонд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын эзлэх хувийн жинг тодорхойлж, боломжтой бол хүйсээр задалж гаргана. • Байгууллагынхаа барилга байгууламжийн хүртээмжийн түвшнийг тодорхойлох үнэлгээ хийсэн эсэхийг тайлбарлана. Ийм үнэлгээг олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн хөндлөнгийн этгээдээр хийлгэх боломжтой төдийгүй ОУХБ-ын Бизнес болон хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх олон улсын сүлжээ (GBDN)-нээс баталж гаргасан Өөртөө үнэлгээ хийх аргачлалыг ашиглан дотооддоо өөрсдөө хийж болно. • Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хүртээмжтэй орчныг сайжруулах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас тайлант хугацаанд компанийн төлж барагдуулсан нийт торгуулийн хэмжээг тодруулж тайлагнана.
Баримт нотолгоо	Мэдээллийн боломжит эх сурвалжид байгууллагын мөрдөж буй бодлогын баримт бичгүүдийн лавлагаа болон ажилтнуудын бүртгэл хамаарна.
Ашиглах материал	
Холбогдох ТХЗ	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 405 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD)) НҮБ-ын Бизнес болон Хүний эрхийн удирдах зарчмууд ОУХБ-ын стандартууд, конвенцүүд Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд ОУСК Гүйцэтгэлийн Стандарт 2</p>


S5. Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо

Яагаад чухал вэ?	<p>Байгууллагын үйл ажиллагаа, дэд бүтцээс үүдэлтэйгээр эдийн засаг, нийгэм, соёлын болон/ буюу байгаль орчны ихээхэн сөрөг үр дагавар нутгийн хүн амын амьжиргаанд нөлөөлж болзошгүй байдаг. Иймээс байгууллага нь боломжтой бүхий л нөхцөлд нутгийн хүн амд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж байх хэрэгтэй. Нутгийн хүн амын амьжиргаанд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг зохицуулах гол элемент бол нөлөөллийн үнэлгээ хийж, төлөвлөх замаар бодит болон болзошгүй нөлөөллийг сайтар мэдэж байх, мөн нутгийн хүн амын бүлгүүдийн оролцоог дэмжиж тэдэнтэй нягт хамтран ажиллах замаар тэдний хүсэл эрмэлзэл, хэрэгцээг сайтар ойлгож байх явдал юм. Хамтын ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ, хөгжлийн хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрхэн тууштай хэрэгжүүлж байгаагаар тухайн байгууллагын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар өгөөж, бодлого журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тодорхойлж болно.</p>
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	<p>S5.1 Танай компанид удирдлагаас баталсан оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу? (Тийм/Үгүй) S5.2 Танай компанид нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх болон газар чөлөөлөлтийн асуудлаарх бодлого журам бий юу? (Тийм/Үгүй)</p>

<p>Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>S5.3 Танай компанид гомдол маргаан шийдвэрлэх бодлого, механизм бий юу? (Тийм/Үгүй) S5.4 Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? (Тийм/Үгүй) S5.5 Олон нийтээс хүлээн авч i) шийдвэрлэж байгаа ii) шийдвэрлэсэн санал гомдлын хувь (%) S5.6 Олон нийтэд чиглэсэн нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрүүдэд зарцуулсан зардлын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-ын ангиллаар (%)</p>
<p>Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)</p>	<p>- Нүүлгэн шилжүүлэлтэд өртөж биет болон эдийн засгийн хохирол учирч, нөхөн төлбөр авсан хүмүүсийн тоо, хүйсээр, байршлаар ангилж гаргах - Тайлангийн хугацаанд албан ёсны санал гомдол хүлээн авах механизмаар дамжуулж нийгэмд учирч буй нөлөөллийн талаар ирүүлсэн санал гомдлын тоо - Хүлээн авсан нийт санал гомдлын хэдийг нь тайлангийн хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байгаа болон хэдийг нь тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн тухай мэдээлэл - Нийгмийн асуудалд оруулсан хөрөнгө оруулалтын зардал, бүс нутгаар ангилж гаргах</p>
<p>Удирдлагын арга барил</p>	<p>Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах талаар баримталж буй бодлого, төлөвлөгөөний талаар тайлбарлана. Үүнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, зөвлөлдөх уулзалтууд, олон нийтэд мэдээллийг нээлттэй болгох, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, олон нийтийн ажил, орон нутгийн иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх арга механизм зэрэг үйл явц хамаарна.</p>
<p>Заавар</p>	<p>Энэ үзүүлэлт нь байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгэм болон орон нутагт үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох зорилготой.</p> <p>Нийгэмд учруулж болзошгүй нөлөөллийн үнэлгээ (хийсэн бол) болон аливаа сөрөг нөлөөллийг сааруулах талаар авч буй өнөөгийн арга хэмжээнүүдээ тодорхой тайлбарлана.</p> <p>Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн санал, асуулгыг хүлээн авч шийдвэрлэх санал гомдлын хүртээмжтэй механизмыг компани нь бүрдүүлсэн эсэх, мөн тайлангийн хугацаанд нийт хүлээн авсан санал гомдлын тоо, тэдгээрийн хэдийг нь i) шийдвэрлэхээр ажиллаж байгаа, ii) шийдвэрлэсэн зэрэгт тайлбар өгнө.</p> <p>Тайлангийн хугацаанд орон нутагт болон нийгмийн асуудалд оруулсан хөрөнгө оруулалтын нийт хэмжээг тодорхойлж, мөн үеийн байгууллагын орлоготой харьцуулж тооцно. Орон нутгийн хөрөнгө оруулалтад ерөнхийдөө байгууллагаас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт болон олон нийтэд чиглэсэн хөтөлбөрүүдэд зориулсан хандив тусламж хамаарна. Үүнд мэргэжлийн тусалцаа үзүүлэх, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтууд болон бусад санхүүгийн бус эх үүсвэрээр хангах зэргээр хамтын үнэ цэнийг бүтээж, орон нутгийн иргэдийн хөгжилд түлхэц өгөх хүчин чармайлтууд хамаарна.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид төслийн суурь судалгаанууд, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлгийн тэмдэглэлүүд, төлөвлөгөө, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх механизм зэрэг хамаарна.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	<p></p>
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ТОУС 413 ОУСК Гүйцэтгэлийн стандартууд ОУСК Компанийн Засаглалын Аргачлал ОУСК Оролцогч талуудын оролоцооГарын авлага</p>

S6. Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээний удирдлага

Яагаад чухал вэ?	<p>Нийлүүлэлтийн сүлжээ нь маш нарийн бөгөөд төвөгтэй байж болзошгүй юм. Ихэвчлэн олон газар нутаг, улс орныг хамарч байдгийн зэрэгцээ олон шатлалтай (tier) байдаг. Нийлүүлэлтийн сүлжээ нь бараг бүх төрлийн бизнесийн амжилтын үндэс болж байдаг төдийгүй үнэ цэнэ, инновацыг бий болгох чухал суурь болж чаддаг. Нийлүүлэлтийн сүлжээ нь компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадуур өрнөдөг үйл явц учир байгалийн нөөцийн хомсдол, хүний эрхийн зөрчил, авлига зэрэг БОНЗ-ын хүчин зүйлээс үүдэлтэй далд бөгөөд хянах боломжгүй эрсдэлд өртөж болзошгүй байдаг²⁶. Нөгөө талаас, салбарын үйл ажиллагаа нь ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчдээс хэр их хамааралтай байдгийг харгалзан үзвэл тухайн байгууллага нь орон нутгаас эх үүсвэрээ бүрдүүлж, ханган нийлүүлэгчдийг дэмжих арга зам нь орон нутгийн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэхээс гадна орон нутгийн тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжих, улмаар олон улсын туршлагыг дотоодын компаниудтай хуваалцахад чухал ач холбогдолтой юм. Энэ үзүүлэлт нь тухайн компани нийлүүлэлтийн сүлжээндээ орон нутгийн болон БОНЗ/ногоон ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн илүү үр өгөөжийг бий болгохын тулд авч буй арга хэмжээнд анхаарлаа хэрхэн чиглүүлж байгааг харуулна.</p>
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	<p>S6.1 Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? (Тийм/Үгүй) S6.2 Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь (%) S6.3 Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь (%)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	<ul style="list-style-type: none"> – Компаниас зохион байгуулсан тогтвортой худалдан авалтын тухай хөтөлбөр/сургалтад хамрагдсан ханган нийлүүлэгчид, хувиар (%) – Эмэгтэй эзэмшигчтэй ханган нийлүүлэгчидтэй хийсэн худалдан авалтын төсөв, хувиар (%) – Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-үүдтэй хийсэн худалдан авалтын төсөв, хувиар (%) – Үнэлгээний үр дүнд сайжруулахаар тохиролцсон, түүнчлэн нийгэмд бодит болон болзошгүй сөрөг нөлөөлөл ихтэй гэж үнэлэгдсэн ханган нийлүүлэгчдийн хувийн жин (%)
Удирдлагын арга барил	<p>Ханган нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм, тогтвортой эх үүсвэрийн стандартыг мөрдөх зэрэг ёс суртахуунтай, тогтвортой бизнесийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах стратеги, хөтөлбөрүүдийн талаар тайлагнана. Мөн ханган нийлүүлэгчийн хөгжил буюу санаачилгыг онцгойлон дэмжихэд чиглэсэн байгууллагынхаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын талаар тайлбар оруулж болно. Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрүүд, эмэгтэй буюу эмзэг бүлгийн хүмүүсийн эзэмшилтэй ханган нийлүүлэгчдийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанууд гэх мэт. Дотоодын аж ахуйн нэгж, эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд хамтарсан бүлгүүд (жишээлбэл, бусад компаниуд буюу худалдааны танхимуудтай)-тэй түншлэлийн холбоо тогтоох зэрэг ханган нийлүүлэгчийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн цаашдын зорилтынхоо талаар тайлбарлах хэрэгтэй. Мөн компаниас явуулж буй үйл ажиллагаа хэрхэн шууд бусаар ажлын байр бий болгох, эдийн засгийг хөгжүүлэхэд дэмжлэг болсныг харуулахуйц жишээг оруулах хэрэгтэй. Тухайлбал, компанийн өнөөгийн хэрэгцээг шууд хангахгүй байсан хэдий ч компаниас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болсон эдийн засгийн үйл ажиллагааны үр дүн болон боломжуудыг тодорхой орон нутгийн бизнесийн хөгжлийн хөтөлбөр, кейс судалгаануудаар тайлбарлах нь чухал²⁷.</p>
Заавар	<p>Энэхүү үзүүлэлт нь орон нутагт явуулж буй үйл ажиллагаа болон түүнээс үүдэж болзошгүй нийгэм, байгаль орчны зэрэг болон сөрөг нөлөөллийн магадлан үнэлгээг үндэслэн сонгосон буюу гэрээ байгуулсан ханган нийлүүлэгчдийн тоо хэмжээг сонирхогч талуудад мэдээлнэ. Тухайн ханган нийлүүлэгчтэй шинэ харилцаа тогтоохдоо аль болох эртнээс ийм үнэлгээг эхлүүлсэн байх хэрэгтэй.</p>

Заавар	<p>Байгууллагад дотоодын худалдан авалтыг дэмжих, мөн нийлүүлэлтийн сүлжээн дэх БОНЗ-ын эрсдэл, боломжуудыг тооцож удирдан чиглүүлэх тусгайлсан бодлого журам бий эсэхийг тодорхой тайлбарлана. Тогтвортой хөгжил/БОНЗ-ын шалгуураар сонгогдсон дотоодын ханган нийлүүлэгчид болон тэдгээртэй хийсэн худалдан авалтад зарцуулсан төсвийг хувиар тооцож тайланд тусгана.</p> <p>Дотоодын болон БОНЗ/тогтвортой ханган нийлүүлэгчдийн тухай ойлголт тодорхойлолт, шалгуурын хувьд, байгууллагууд олон улсын стандартууд, тодорхойлолтыг ашиглах, аль эсвэл өөрсдийн худалдан авалтын бодлогодоо тусгасан ойлголт тодорхойлолт, шалгуурыг ашиглаж болно. НҮБ-ын Даян дэлхийн гэрээний Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ: Тасралтгүй сайжруулах практик зөвлөмжийг мөн компаниуд ашиглаж болно.</p>
Баримт нотолгоо	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид тухайн байгууллагын худалдан авалт, худалдаа, БОНЗ болон хуулийн газар хэлтсүүдийн мэдээлэл, бодлогын баримт бичгийн лавлагаа зэрэг хамаарна.</p>
Ашиглах материал	
ТХЗ-той уялдуулах	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС 204, 414 Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ: Тасралтгүй сайжруулах практик зөвлөмж, Хоёрдугаар хэвлэл</p>

4.4 ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хууль тогтоомжийг зөрчих, үйл ажиллагаандаа хайхрамжгүй хандах, авлига, компанийн дагаж мөрдвөл зохих стандартуудыг мөрдөхгүй байх зэрэг засаглалын асуудлууд нь компанийн нэр хүнд унах, санхүүгийн тогтворгүй байдалд хүргэх аюултай үр дагавартай. Улмаар эдгээр үр дагавар нь зөвхөн ажилтнууд, хувьцаа эзэмшигчдэд төдийгүй хүн амын бүлгүүд, гэр бүл, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчдэд ч нөлөөлнө. Түүнчлэн хөрөнгө оруулагчид ч компанийн засаглал, ёс зүй, авлигатай холбоотой эдгээр сорилтуудыг компаниуд хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх баталгааг хайж эхэлнэ. Энэ хэсэгт өгүүлж буй тайлагналын удирдамж, шалгуур үзүүлэлтүүд нь бизнест ёс зүйтэй хандах, тэр дундаа авлигатай тэмцэх, бизнесийн үйл ажиллагааны бүх түвшинд компанийн удирдлага, ажилтнууд, ханган нийлүүлэгчдийн дагаж мөрдөх зарчим, дүрэм, журмыг тодорхойлоход тусална.

G1. Компанийн засаглал, Удирдах зөвлөл

Яагаад чухал вэ? Хуулийн этгээдүүд нь компанийн засаглалын хүчтэй бодлого, тогтолцоотой байх ёстой. Компанийн засаглал нь оролцогч талууд, удирдлага, компанийн Удирдах зөвлөл хоорондын харилцаагаар тодорхойлогдоно. Сайн засаглал гэдэг нь компани өөрийн зорилгодоо хэрхэн хүрэх, болзошгүй эрсдэлийг хэрхэн хянах, оролцогч талууддаа, тухайлбал, ажилтнууд, ханган нийлүүлэгчид, нутгийн иргэд, байгаль орчин зэрэгт үр өгөөжийг нь хүртэх боломжийг бүрдүүлэх зэргийг удирдан чиглүүлэхийг хэлнэ. Компанийн хүчтэй засаглалын нэг чухал хэсэг нь Удирдах зөвлөлийн зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчидтэй харилцах харилцаатай холбоотой байдаг. Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, улмаар хэрэгжүүлэх, бүх хувьцаа эзэмшигчидтэй, тэр дундаа цөөнх буюу жижиг хувьцаа эзэмшигчид болон гадаадын хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ижил тэгш хандахад чиглэсэн байх ёстой.

Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	<p>G1.1 Танай компани шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, тайлагнал хийдэг үү? (Тийм/Үгүй)</p> <p>G1.2 Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн хувийн жин (%)</p> <p>G1.3 Танай компанид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)</p>
Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)	Гүйцэтгэх удирдлага болон Удирдах зөвлөлийн албан тушаалыг тус тусад нь салгах
Удирдлагын арга барил	<p>Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх үйл явц, цалин хөлсний бодлого, ажилтнуудад зориулсан сургалт, аудит, магадлан үнэлгээ, хяналтын тогтолцоо, зөрчлийн тухай мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дүрэм, журам зэрэг асуудлыг хамруулсан компанийн хүчирхэг засаглал, Удирдах зөвлөлийн зохион байгуулалтыг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийнхээ талаар тайлагнана.</p> <p>Компаниуд санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталсан (145 дугаар тогтоол)²⁸ “Компанийн засаглалын кодекс”-ийг дагаж мөрдөнө. Шинээр батлагдсан Кодекс-д дараах 9 компанийн засаглалын зарчмыг тусгасан. Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар хангана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт 2. Удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг 3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал 4. Аудит, хяналтын тогтолцоо 5. Эрсдэлийн удирдлага 6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал 7. Оролцогч талуудын эрх ашиг 8. Компанийн соёл 9. Хувьцаа эзэмшигчдийн эрх
Заавар	<p>Энэ үзүүлэлт нь компанийн засаглал, Удирдах зөвлөлийн хараат бус байдал, цөөнх буюу жижиг хувьцаа эзэмшигчидтэй хамтран ажиллах үйл явц зэрэг байгууллагын ерөнхий хандлага арга барилыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> • Томоохон хувьцаа эзэмшдэггүй, компанид ажилладаггүй, компанийн шийдвэрт нөлөөлөхүйц албан болон албан бус харилцаа байхгүй, бизнесийн холбоогүй, компанийн удирдлага, хяналт, томоохон хувьцаа эзэмшигчдээс хараат бус гишүүдийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд эзлэх хувийн жинг тооцно. • Танай компанид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тусгайлсан буюу нэгдсэн бодлого журам бий эсэхийг тодорхой тайлбарлана. Хяналтын багц эзэмшигчид шууд болон шууд бус байдлаар жижиг хувьцаа эзэмшигчдийг урвуулан ашиглах аливаа үйлдлээс хамгаалж, болзошгүй хохирлоос сэргийлэх, залруулах үр дүнтэй арга механизмыг тогтоосон байх ёстой. Дур зоргоороо аашлахыг ч хориглох хэрэгтэй. Мөн жижиг хувьцаа эзэмшигчидтэй хамтран ажиллах үйл явц маш тодорхой байх учиртай. Тэд хувьцаа эзэмшигчдийн хурал, хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг зохистой хугацаанд хүлээн авч, хувь нийлүүлэгчдийн хурал зөвлөгөөнд оролцох, санал өгөх эрх эдлэхийг хүлээн зөвшөөрч дэмжиж байх нь чухал. • Танай компанид компанийн засаглалын талаар тусгайлсан буюу нэгдсэн бодлого, дүрэм бий эсэхийг тодорхой тайлбарлана.
Баримт нотолгоо	Мэдээллийн боломжит эх сурвалжид Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх мэдээлэл, бодлогын баримт бичгүүдийн лавлагаа, компанийн нарийн бичгийн даргын алба зэрэг хамаарна.

Ашиглах материал

ТХЗ-той
уялдуулах



Чухал эх
сурвалжууд

[ТОУС 201](#)
МХБ. Компанийн засаглалын удирдамж
ЭЗХАХБ. Компанийн засаглалын зарчмууд
СЗХ (2022) Компанийн засаглалын кодекс
ОУСК Компанийн Засаглалын Аргачлал
ОУСК Мэдээллийг нээлттэй ил тод тайлагнах арга зүйн лавлах

G2. Авлига, ёс зүй

Яагаад чухал
вэ?

Хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд түрүүлж "сайн санааны хүчин чармайлт (good faith effort)" гаргаснаар ёс зүйн алдааны улмаас торгууль төлж, санхүүгийн эрсдэлд орох эрсдэлийг бууруулж чадна. Хээл хахууль, авлигаас урьдчилан сэргийлэх нь бүх ажилтан, бизнесийн түншүүд, ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчид болон бусад зуучлагчид зэрэг бүх талуудын үнэт зүйл юм.

Үзүүлэлтүүд

Гүйцэтгэлийн
үндсэн
шалгуур
үзүүлэлтүүд

G2.1 Танай компанид авлигын эсрэг бодлого болон/буюу ёс зүйн дүрэм, журам бий юу? (Тийм/Үгүй)

Нэмэлт
үзүүлэлтүүд
(сонголттой)


- Байгууллагын авлигатай тэмцэх бодлого, журмын талаар сургалтад хамрагдсан засаглалын байгууллагын гишүүд, ажилтан, бизнесийн түншүүдийн нийт хувийг бүс нутгаар ангилсан.
- Энэ он болон өмнөх онуудад холбогдох авлигын гэмт хэргийн нийт тоо, шинж чанар.
- Мэдээллийн талаар тухайн байгууллагын зохицуулалт, мэдээлэх байгууламжаар дамжуулан тавьсан асуудлын тоо, шинж чанар, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлбар.
- Ёс зүйн болон авлигатай тэмцэх тухай сургалтад хамрагдсан ажилтнуудын хувийн жин (%)
- Авлигатай холбоотой эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагаа (%)
- Авлигын гэмт хэргийн батлагдсан тохиолдлын тоо, түүний мөрөөр авсан арга хэмжээ

Удирдлагын
арга барил

Мэдээлэгчийг хамгаалах бодлого, аудит, тусгай хороод, сургалт зэрэг авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрүүд, ёс зүйн дүрэм, дотоод хяналтын талаар тодорхой тайлагнана. Байгууллагын зүгээс авлигатай тэмцэх бодлого, хөтөлбөрүүдийг сурталчлах механизм, арга хэмжээ, тэр дундаа ажилчид болон бизнесийн түншүүдийнхээ мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр хийж байгаа ажлаа дурдах хэрэгтэй. Түүнчлэн байгууллагынхаа баримталж буй авлигын эсрэг бодлого, түүний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж байх журам ханган нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгчид зэрэг бизнесийн түншүүд тань хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай тайлбарлах хэрэгтэй. Хууль тогтоомж мөрдөхгүй байгаа сэжигтэй тохиолдлыг мэдээлэх, хянаж шалгах, мөрөөр нь арга хэмжээ авах үйл явцынхаа талаар тайланд тусгана.

Заавар

Энэ үзүүлэлт нь байгууллагын зүгээс ажилтнууд болон бизнесийн түншүүдийнхээ хээл хахууль/авлигын эсрэг бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрхэн дагаж мөрдөж байгаад болон бусад үйл явц хэрхэн өрнөж байгаад хяналт тавьж удирдан чиглүүлж байгааг илэрхийлнэ. Авлига гэдэг нь итгэмжлэгдсэн эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах явдал бөгөөд ийм хууль бус үйлдлийг хувь хүн, хуулийн этгээд үүсгэх магадлалтай.

<p>Заавар</p>	<p>Энэхүү Удирдамжид авлига гэдэгт хээл хахууль, төлбөрийн тохиролцоо, залилан, сүрдүүлэг, хуйвалдаан, мөнгө угаах зэрэг үйлдлүүдийг хамруулсан. Түүнчлэн ямар нэгэн бэлэг сэлт, зээл, хураамж, шагнал урамшуулал авах, өгөх, бусдад давуу байдлыг бий болгох зэргээр шударга бус, хууль бус үйлдэл хийх, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг алдагдуулах зэрэг хамаарна. Мөн үнэ төлбөргүй бараа бүтээгдэхүүн, бэлэг сэлт зэрэг бэлэн мөнгө, эд хөрөнгийн ашиг хонжоо авах, өгөх, зүй зохисгүй давуу байдал олгосныхоо төлөө зугаа цэнгэлийн болон хувийн тусгай үйлчилгээ авах, давуу байдал үүсгэхийн тулд бусдад ёс зүйн дарамт учруулах зэрэг үйлдлүүд хамаарна²⁹.</p> <p>Наад зах нь танай байгууллагад авлигатай тэмцэх тухай болон ёс зүйн дүрэм, холбогдох бусад дүрэм журам байгаа эсэх, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлж, хяналт тавьж байгаа талаараа тайлагнах хэрэгтэй. Нэмэлт үзүүлэлт болгон авлигын батлагдсан тохиолдлын тоог мөн мэдээлнэ. Авлигын батлагдсан тохиолдол гэж үндэслэл нь нотлогдсон авлигын хэрэг нэг бүрийг хэлнэ.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид хууль эрх зүйн болон хууль тогтоомжийн мөрдөлтөд хяналт тавих үүрэг бүхий газар нэгжүүд хамаарна</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ТОУС 417 СЗХ (2022) Компанийн засаглалын кодекс ЭЗХАХБ Компанийн засаглалын зарчмууд ЭЗХАХБ-ын Авлигын эсрэг болон шударга ёс судалгааны төв (OECD Anti-corruption and Integrity Hub)</p>

G3. Комплаенс

<p>Яагаад чухал вэ?</p>	<p>Комплаенс нь зах зээлийн шударга байдал болоод үр ашигт маш чухал. Комплаенс сул байснаар компанийн боломж чадавх буурч, санхүүгийн болоод залилангийн эрсдэлд ч хүргэж болзошгүй юм. Комплаенс сайтай компаниуд ихэвчлэн өрсөлдөгчдөөсөө илүү амжилт гаргахын зэрэгцээ бизнесээ тэлэх санхүүжилтэд хөрөнгө оруулагчдыг татах боломж ихтэй байдаг. Эдийн засгийн үүднээс авч үзвэл, комплаенс сайтай байх нь элдэв төлбөр торгуулиар буюу шууд, компанийн нэр хүндэд нөлөөлөх буюу шууд бус замаар үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулна. Байгууллагын комплаенс тогтвортой сайн байх нь түүний үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон тусгай зөвшөөрөл авах чадварт эергээр нөлөөлнө.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>G3.1 Танай компанид комплаенсын бодлого, журам бий юу? (Тийм/Үгүй) G3.2 Танай компанид комплаенсын хөтөлбөр (ажилтнуудад зориулсан сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн тухай мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хориг тавих зэрэг асуудлаарх заавар, журам гэх мэт) бий юу? (Тийм/Үгүй)</p>
<p>Нэмэлт үзүүлэлтүүд (сонголттой)</p>	<ul style="list-style-type: none"> - Танай компанид тусгайлан комплаенс хариуцсан ажилтан бий юу? (Тийм/Үгүй) - Танай компанид тусгайлан бодлого, хөтөлбөрийн мөрдөлтөд хяналт тавих үүрэг хүлээсэн удирдах ажилтан бий юу? (Тийм/Үгүй) - Тайлангийн хугацаанд гарсан хууль, тогтоомжийн мөрдөлтийн томоохон зөрчлийн тохиолдлын тоо, мөнгөн дүн, үүнээс i) торгууль ногдуулсан тохиолдлын тоо; ii) мөнгөн бус шийтгэл ногдуулсан тохиолдлын тоо (төг)

Удирдлагын арга барил	Ажилтнуудад зориулсан сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн тухай мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлаарх заавар, журам зэргийг хамруулсан компанийн комплаенсыг сайжруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийн талаар тодорхой тайлагнана.
Заавар	<p>Энэ үзүүлэлт нь тухайн байгууллагын заавал дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагын зүгээс баримталж буй бодлогыг илэрхийлнэ. Хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөхгүй байх нь тухайн байгууллагын гүйцэтгэлийн зарим үзүүлэлтүүдийг хэрхэн хангах удирдлагынх нь чадварт үнэлгээ өгөх боломж олгодог. Хууль тогтоомжийг бүс, орон нутаг, үндэсний хэмжээний эрх бүхий байгууллагууд, зохицуулагч байгууллагууд, төрийн байгууллагууд зэрэг олон байгууллагууд гаргаж болно.</p> <p>Комплаенсын бодлого, журмын баримт бичиг нь ЭЗХАХБ-ын Хээл хахуультай тэмцэх тухай конвенцийн холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөндотоод хяналт, ёс зүй, комплаенсын хөтөлбөр, арга хэмжээний үр нөлөөг бий болгож, баталгаажуулахад чиглэсэн комплаенсын хөтөлбөрийн суурь үндэс юм. Түүнчлэн, комплаенс нь үнэт цаас, өрсөлдөөн, хөдөлмөр, аюулгүй байдал зэрэг асуудлаарх бусад хууль тогтоомж, дүрэм журамтай ч уялдаа холбоотой. Татвар, хүний эрх, байгаль орчин, залилан, мөнгө угаахтай тэмцэх зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь чухал. Комплаенсын ийм хөтөлбөрүүд нь компанийн ёс зүйн дүрмийн үндэс юм. Үр дүнтэй байхын тулд бизнесийн урамшууллын бүтцийг ёс зүйн болон мэргэжлийн стандартад нийцүүлсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр үнэт зүйлсээ чанд мөрдсөн тохиолдолд шагнал урамшуулал авч, хууль зөрчсөн тохиолдолд харин эсрэгээрээ муу үр дагаварт хүрч буюу шийтгэл ч ногдуулахад хүрнэ. Комплаенс хөтөлбөрүүдэд салбар компаниудыг хамруулах шаардлагатай бөгөөд төлөөллийн газрууд, бусад зуучлагч байгууллагууд, зөвлөхүүд, төлөөлөгчид, борлуулагчид, гэрээт гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчид, хамтарсан үйлдвэрийн түншүүд зэрэг гуравдагч этгээдүүдийг ч аль болох хамруулах хэрэгтэй³⁰.</p> <p>Тайлангийн хугацаанд давж заалдсан захиргааны хэргийн болон шүүхийн шийтгэл, торгууль ногдуулсан томоохон зөрчлийн тохиолдлын тоо нэмэлт үзүүлэлтэд хамаарна. Тайлангийн хугацаанд ямар нэгэн хууль тогтоомж дагаж мөрдөөгүйн улмаас торгууль шийтгэл ногдуулсан томоохон зөрчил гараагүй бол энэ талаар товч тайлбар оруулж тайлагнахад хангалттай.</p>
Баримт нотолгоо	Мэдээллийн эх сурвалжид байгууллагын бодлогын баримт бичгийн лавлагаа, аудитын дүгнэлт, хуулийн хэлтсээс удирддаг эрх зүйн зохицуулалтын хяналтын систем, болон байгаль орчны удирдлагын систем зэрэг хамаарна. Торгуулийн нийт хэмжээг нягтлан бодох бүртгэлийн хэлтсээс авах боломжтой.
Ашиглах материал	
ТХЗ-той уялдуулах	
Чухал эх сурвалжууд	<p>ТОУС/ТОУС 201</p> <p>МХБ. Компанийн засаглалын удирдамж</p> <p>ЭЗХАХБ. Компанийн засаглалын зарчмууд</p> <p>ОУСК Компанийн Засаглалын Аргачлал</p>

4.5 САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төслийн багаас дараах зургаан салбарыг (санхүүгийн үйлчилгээ, хөдөө аж ахуй, текстилийн салбар, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилга) байгаль орчин, нийгэм, засаглалын асуудалд хамгийн их өртөж буй салбарууд хэмээн тодорхойлсон. Эдгээр салбар тус бүр нь салбарынхаа үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж нөлөөллийн цөөнгүй асуудалтай тулгарч байна. Энэ хэсэгт эдгээр зургаан салбарын үйл ажиллагаанаас үүдэлтэй хамгийн чухал гэж үзэх нөлөөллийг тодорхойлж, оролцогч талуудын зүгээс тогтвортой байдлын тайланд ямар мэдээллийг илүүтэй сонирхож буй талаар танилцуулна.

FS. Санхүүгийн үйлчилгээ

Энэ салбар яагаад чухал вэ?

Нүүрстөрөгчийн хий бага ялгаруулдаг, тогтвортой нийгмийг бий болгоход хөрөнгө нөөц гэдэг утгаараа санхүүгийн байгууллагууд онцгой үүрэг гүйцэтгэнэ. Байгаль орчин, нийгэмд хор нөлөө ихтэй үйлчлүүлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих нь хууль эрх зүйн болоод хөрөнгө нөөц, нэр хүндийн эрсдэлд санхүүгийн байгууллагыг оруулж болзошгүй гэдэг нь олон улсад танигдсан. Түүнчлэн, санхүүгийн байгууллагын зээл, бизнесийн үйл ажиллагааг хариуцлагатай удирдахгүй бол байгаль орчин болон түүнийг түшиглэн амьдарч байгаа хүн амын бүлгүүдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Иймээс санхүүгийн салбарын хүрээнд байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь тэдний санхүүжилт, үйлчлүүлэгчид, нэр хүндэд учрах эрсдэлээс сэргийлэх, бууруулах, удирдах боломжийг олгоно. Мөн санхүүгийн байгууллагууд нь харилцагчдадаа олгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ дамжуулан тогтвортой, ногоон хөгжил, санхүүгийн хүртээмжийг дэмжихэд манлайлах үүрэг гүйцэтгэж чадна.

Үүний хүрээнд монголын банк санхүүгийн байгууллагууд Тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг нэвтрүүлж, БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг бизнесийн зээлдээ хэрэгжүүлж байна.

Үзүүлэлтүүд


Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд

FS1.1 Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцогчдын тоо, жилээр
FS1.2 БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний эзлэх хувь (%)
FS1.3 Нийт зээлийн багцад Монгол Улсын ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээл, санхүүжилтийн эзлэх хувийн жин (%)

Тайлбар

Санхүүгийн хүртээмж: Монгол Улсын нийгмийн тодорхой хэсэг нь олон бэрхшээлээс (тухайлбал, тогтвортой орлогогүй, ажлын байр хомс, санхүүгийн суурь мэдлэг сул, банкны үйлчилгээ авах боломж хомс, үйлчилгээний өртөг өндөр, бүтээгдэхүүн оновчгүй, эрх зүйн зохицуулалтын саад бэрхшээл, санхүүгийн байгууллагад итгэх итгэл сул, гэх мэт) шалтгаалан санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байна. Үүнд санхүүгийн байгууллагуудын зүгээс олон нийтэд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалт, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд зэргийг зохион байгуулах замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чухал үүрэг хариуцлага хүлээх болсон. Эдгээр үйл ажиллагааны ашиг шимийг хүртсэн хүний тоогоор энэхүү үзүүлэлтийг тооцно.

БОН-ийн эрсдэлийн удирдлага: тодорхой төслүүд болон компаниудын санхүүгийн гүйцэтгэлд БОНЗ-ын хүчин зүйлсийн үзүүлэх нөлөө улам бүр нэмэгдэж байна. Эдгээр эрсдэл, боломжуудыг шийдэж чадахгүй байгаа санхүүгийн байгууллагуудын өгөөж улам бүр суларч, хувьцаа эзэмшигчдэд очих үнэ цэнэ нь ч буурч болзошгүй юм. Иймээс компаниуд БОНЗ-ын хүчин зүйлсийг зээл олгох үйл явцтай хэрхэн уялдуулж байгаа болон БОНЗ-ын шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтыг үндэслэж үнэлсэн төлбөрийн нийт гүйлгээний зээлийн нийт багцад эзлэх хувийн жин зэргийг тодорхой тайлбарлаж тайлагнах нь чухал.

Тайлбар	Ногоон зээл/тогтвортой санхүүжилт: Парисын хэлэлцээр болон ТХЗ-ыг хэрэгжүүлэхтэй уялдаж дэлхий дахины хөгжлийн хандлагад ихээхэн өөрчлөлт орж байгаа нь санхүүгийн байгууллагуудад ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, шинэ зах зээл, шинэ үйлчлүүлэгчидтэй болох зах зээлийн шинэ боломжийг нээж байна. Монгол Улсын Ногоон/ТХЗ-ын таксономид “ногоон” гэж үзэж болох эдийн засгийн ангиллын үйл ажиллагааны жагсаалтыг оруулсан. Энэ үзүүлэлт нь санхүүгийн байгууллагуудын Монгол Улсын Ногоон/ТХЗ-ын таксономитай нийцсэн зээл, санхүүжилтийн жинг илэрхийлнэ.
Баримт нотолгоо	Санхүүгийн байгууллагуудын зээлийн багцын мэдээлэл, зохицуулагчдад хүргүүлсэн тайлангууд, сургалт, арга хэмжээний мэдээлэл.
Ашиглах материал	
ТХЗ-той уялдуулах	
Чухал эх сурвалжууд	Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд болон Салбарын удирдамж зааврууд Монгол Улсын Ногоон таксономи , Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономи ОУСК Гүйцэтгэлийн стандартууд ТБНББСЗ Салбарын стандартууд Тогтвортой санхүүжилтийн мэдээллийг тайлагнах журам

АФ. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл

Энэ салбар яагаад чухал вэ?	Хөдөө аж ахуйн салбар нь хүнсний тогтолцоог дэмжих, иргэдийг хүнсээр хангагдах эрхийг хамгаалах суурь үндэс нь юм. Тогтвортой хөгжлийн үүднээс авч үзвэл байгалийн нөөцийг эрчимтэй ашиглах, хортон шавж устгал, газар, бэлчээр, түүнчлэн хүнсний чанар, аюулгүй байдал зэрэг тус салбарын үйл ажиллагаанаас үүдэж томоохон үр дагавар гарч болзошгүй юм. Түүнчлэн бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглах, ойн доройтол, уур амьсгалын өөрчлөлт зэргээс шалтгаалан Монгол Улсын газар нутгийн 70 гаруй хувь нь доройтолд ороод байна. Энэ нь үйл ажиллагаа болон ханган нийлүүлэлтийн сүлжээ нь мал аж ахуйн салбарт тулгуурласан бизнес эрхлэгчдэд ихээхэн эрсдэл учруулж байна.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	AF1.1 Танай компанид хортон шавж устгалын бодисын хэрэглээг зохицуулах бодлого, журам бий юу? (Тийм/Үгүй) AF1.2 MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь (%) AF1.3 Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь (%)
Тайлбар	Хортон шавж устгалын бодисын хэрэглээ: Органик болон органик бус бордоо болон хортон шавж устгалын бодис хэрэглэх нь хөрсний эрүүл ахуйд нөлөөлнө. Бордоо, хортон шавж устгалын бодисыг буруу хэрэглэх тохиолдолд урсгал усыг бохирдуулж, нутгийн иргэд, тэр дундаа уугуул иргэдийн эрүүл мэнд, хоол хүнс, ундны ус, амьжиргаа зэрэгт нөлөөлөх эрсдэлтэй. Үүнийг шийдвэрлэхийн тулд компаниуд хортон шавж устгалын бодисын хэрэглээг зохицуулах тусгайлсан буюу нэгдсэн бодлого, журмыг баталж хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд тэр талаараа олон нийтэд нээлттэй мэдээлэх хэрэгтэй. Газар зохион байгуулалт: Монгол Улс нь дэлхийн хамгийн өргөн уудам бөгөөд биологийн олон янз байдлаар баялаг бэлчээрийн экосистемтэй орнуудын нэг юм. Гэсэн хэдий ч энэ экосистем нь хурдацтай доройтож, бэлчээрийг даац хэтрүүлэн ашигласнаас үүдэлтэй бэлчээрийн доройтлын улмаас биологийн олон янз байдал алдагдаж байна. Үүнийг шийдвэрлэх үүднээс олон аж ахуйн нэгжүүд газрын тогтвортой удирдлагын арга барилыг хэрэгжүүлж байна. Иймээс MNS 6891:2020 “Ногоон алт – Хариуцлагатай нүүдэлчин” стандартыг, буюу ижил төстэй бэлчээрийн тогтвортой ашиглалтын стандартыг хангасан бэлчээр нутгийн талбайн хэмжээг хувиар илэрхийлэн тайлагнах хэрэгтэй.

<p>Тайлбар</p>	<p>Хүнсний чанар: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд шууд түүхийгээр нь нийлүүлэхийн зэрэгцээ боловсруулан олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хадгалан хамгаалах шаардлагыг хангаагүй тохиолдолд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ өөрчлөгдөх төдийгүй эрх зүйн зохицуулалтын арга хэмжээ авахад хүргэдэг тул маш чухал асуудал юм. Бүтээгдэхүүн буцаагдах нь тухайн брэндийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, орлого буураад зогсохгүй өндөр өртөгтэй торгууль төлөхөд хүргэнэ. Хөрөнгө оруулагчдад эдгээр эрсдэлийг илүү сайн ойлгоход нь туслахын тулд энэ үзүүлэлтээр компаниудаас хүнсний чанар болон/буюу аюулгүй байдлын асуудлаас болж буцаагдсан бүтээгдэхүүний хувийн жинг тодорхой тайлагнах шаардлагатай.</p> <p>Мөшгөх систем: Гарал үүсэлт нь тогтвортой үйлдвэрлэл, тайлагналын гол асуудал. Ялангуяа, малын гаралтай бүтээгдэхүүн (мах, ноос гэх мэт) салбарт гар утасны програм, блокчэйн программ зэрэг шинэ технологиудыг ашиглахыг санал болгож байна.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн эх сурвалжид байгууллагын бодлогын баримт бичгийн лавлагаа, тогтвортой хөгжил/БОН/ХАБЭА-н асуудал хариуцсан газар, хэлтэс, хуулийн хэлтсээс удирддаг эрх зүйн зохицуулалтын хяналтын систем, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчин, ХАБЭА-н удирдлагын систем зэрэг хамаарна.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>MNS 6891:2020, “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд” ОУСК Гүйцэтгэлийн стандартууд ХХААБ. Стандартууд ТОУС 304</p>

Т. Нэхмэлийн салбар

<p>Энэ салбар ягаад чухал вэ?</p>	<p>Ноолуур, ноосны үйлдвэрлэл давамгайлсан Монгол Улсын нэхмэлийн салбар нь улсын ДНБ болон ажиллах хүчний багагүй хувийг бүрдүүлж байгаа боловч түүхий эдийн гарал үүсэлд тавих хяналт сул, газрын доройтол, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн бусад олон сорилт бэрхшээлээс шалтгаалан ихээхэн эмзэг байна. Түүнчлэн гадаадын боловсруулах үйлдвэрлэгчид болон хөрөнгө оруулагчдын зүгээс олон улсын шилдэг туршлагын дагуу илүү тогтвортой, чанарт суурилсан үйлдвэрлэлийг бий болгох шаардлага тавьж байна.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>T1.1 MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо, бэлчээрийн эзлэх хувь T1.2 Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь T1.3 Танай компанид химийн хорт болон аюултай бодис, материалтай зүй зохистой харьцах талаарх бодлого, журам бий юу (Тийм/Үгүй)</p>
<p>Тайлбар</p>	<p>Бэлчээрийн менежмент: Монгол Улс нь дэлхийн хамгийн өргөн уудам бөгөөд биологийн олон янз байдлаар баялаг бэлчээрийн экосистемтэй орнуудын нэг юм. Гэсэн хэдий ч энэ экосистем нь хурдацтай доройтож, бэлчээрийг даац хэтрүүлэн ашигласнаас үүдэлтэй бэлчээрийн доройтлын улмаас биологийн олон янз байдал алдагдаж байна. Үүнийг шийдвэрлэх үүднээс олон аж ахуйн нэгжүүд газрын тогтвортой удирдлагын арга барилыг хэрэгжүүлж байна. Иймээс MNS 6891:2020 “Хариуцлагатай нүүдэлчин” бэлчээрийн тогтвортой ашиглалтын стандартыг хангасан бэлчээр нутгийн талбайн хэмжээг хувиар илэрхийлэн тайлагнах хэрэгтэй.</p>

<p>Тайлбар</p>	<p>Тогтвортой үйлдвэрлэл: Тогтвортой үйлдвэрлэлийн дадлыг хэвшүүлснээр текстилийн салбарын үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй олон төрлийн БОНЗ-ын эрсдэлийг тодорхойлон хяналт тавьж удирдах, мөн ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжуудыг ч эрэлхийлэхэд тус болно. Иймд энэ үзүүлэлтээр Европын холбооны SWITCH Asia хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн Монгол Улсын текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, Эко шошго STeP EcoLab төслийн хүрээнд боловсруулсан MNS 6926:2021 стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээг тайлагнах шаардлагатай.</p> <p>Химийн бодисын хэрэглээ: Ажилтнууд, хүн амын бүлгүүд, өмч хөрөнгө, байгаль орчин зэрэгт хор хөнөөл учруулахгүйн тулд химийн бодисыг зүй зохистойгоор хадгалж, ашиглаж, хянаж зохицуулах учиртай. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учрах химийн хор хөнөөлийг тэр бүр хянахад хүндрэлтэй байгаа нь зөвхөн үйлдвэрлэлд ашиглаж байгаа асар их хэмжээний химийн бодисоос гадна дэлхий даяар өргөн тархсан нэхмэлийн салбарын олон шатлалтай нийлүүлэлтийн сүлжээний нарийн төвөгтэй байдалтай ч холбоотой юм. Химийн бодис ашиглалтын талаарх мэдээлэл тун хязгаарлагдмал байгаа төдийгүй ханган нийлүүлэлтийн сүлжээний хувьд ч тэр бүр мэдээлэл олдох нь ховор байна. Үйлдвэрлэгчид ч химийн бодисыг зүй зохистой ашиглах талаар мэдлэг, чадвар хомс байна. Энэхүү үзүүлэлт нь ялангуяа үндэсний болон олон улсын хууль тогтоомжоор хориглосон химийн хорт болон аюултай бодис, материалыг зүй зохистой хадгалах, ашиглах талаарх бодлого, журам, үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.</p> <p>Мөшгөх систем: Гарал үүсэлт нь тогтвортой үйлдвэрлэл, тайлагналын гол асуудал. Ялангуяа, малын гаралтай бүтээгдэхүүн (мах, ноос гэх мэт) салбарт гар утасны програм, блокчэйн программ зэрэг шинэ технологиудыг ашиглахыг санал болгож байна.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн эх сурвалжид байгууллагын бодлогын баримт бичгийн лавлагаа, тогтвортой хөгжил/БОН/ХАБЭА-н асуудал хариуцсан газар, хэлтэс, хуулийн хэлтсээс удирддаг эрх зүйн зохицуулалтын хяналтын систем, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчин, ХАБЭА-н удирдлагын систем зэрэг хамаарна.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>MNS 6926:2021, “Нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл” MNS 6891:2020, “Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд” Монгол Улсын Нэхмэлийн салбарын Ногоон зээлийн шалгуур³¹ ОУСК Гүйцэтгэлийн стандартууд ХХААБ-ын Стандартууд ТОУС/ТОУС 304, 307</p>


МА. Боловсруулах үйлдвэрлэл

<p>Энэ салбар яагаад чухал вэ?</p>	<p>Боловсруулах үйлдвэрлэлийн салбар нь материаллаг нөөцийг хамгийн ихээр хэрэглэдэг салбар учир үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ялангуяа материаллаг нөөцийн зүй зохистой ашиглалт, боловсруулалтыг илүү сайжруулах боломж олгодог. Нөгөө талаас, үйлдвэрлэлийн үйл явц нь олон төрлийн эрсдэлийг дагуулж байгаагийн нэг жишээ бол химийн бодистой харьцах асуудал юм.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>МА.1 Танай компанид химийн хорт болон аюултай бодис, материалтай зүй зохистой харьцах талаарх бодлого, журам бий юу? (Тийм/Үгүй) МА.2 Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь (%) МА.3 Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний хувь (%)</p>

<p>Тайлбар</p>	<p>Химийн бодисын хэрэглээ: Ажилтнууд, хүн амын бүлгүүд, өмч хөрөнгө, байгаль орчин зэрэгт хор хөнөөл учруулахгүйн тулд химийн бодисыг зүй зохистойгоор хадгалж, ашиглаж, хянаж зохицуулах учиртай. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учрах химийн хор хөнөөлийг тэр бүр хянахад хүндрэлтэй байгаа нь зөвхөн үйлдвэрлэлд ашиглаж байгаа асар их хэмжээний химийн бодисоос гадна дэлхий даяар өргөн тархсан нэхмэлийн салбарын олон шатлалтай нийлүүлэлтийн сүлжээний нарийн төвөгтэй байдалтай ч холбоотой юм. Химийн бодис ашиглалтын талаарх мэдээлэл тун хязгаарлагдмал байгаа төдийгүй ханган нийлүүлэлтийн сүлжээний хувьд ч тэр бүр мэдээлэл олдох нь ховор байна. Үйлдвэрлэгчид ч химийн бодисыг зүй зохистой ашиглах талаар мэдлэг, чадвар хомс байна. Энэхүү үзүүлэлт нь ялангуяа үндэсний болон олон улсын хууль тогтоомжоор хориглосон химийн хорт болон аюултай бодис, материалыг зүй зохистой хадгалах, ашиглах талаарх бодлого, журам, үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.</p> <p>Дахин боловсруулсан орц материал: Материалыг зөв зохистой сонгож ашиглах нь байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах төдийгүй нөөцийн ашиглалт, өртөг зардлын үр ашгийг дээшлүүлэхэд тустай. Энэ үзүүлэлт нь байгууллагын дахин боловсруулсан орц материал ашиглах чадвар хэр байгааг тодорхойлох зорилготой. Дахин боловсруулсан орц материалыг ашигласнаар үндсэн материалын хэрэгцээг бууруулж, эх дэлхийнхээ нөөцийг аргилан хамгаалахад хувь нэмэр оруулах нь гарцаагүй. Байгууллагынхаа санхүүгийн гүйцэтгэлд санаа тавьж байдаг ажил хариуцсан менежерүүд болон бусад хүмүүсийн хувьд дахин боловсруулсан орц материал ашигласнаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нийт зардлыг бууруулахад хувь нэмэр оруулна гэдэгт анхаарах нь зүйн хэрэг. Энэ үзүүлэлтийн ерөнхий чиг хандлагаас ажиглахад тухайн байгууллага байгалийн нөөцөөс хараат бус болохын тулд удирдлагын зүгээс шийдэмгий алхам хийх шаардлагатайг илэрхийлж байна. Дахин боловсруулсан орц материалын ашиглалтын хувийг дараах томъёогоор тооцно:</p> $\text{Дахин боловсруулсан орц материалын ашиглалт, хувиар} = \frac{\text{Нийт ашигласан дахин боловсруулсан орц материал}}{\text{Нийт ашигласан орц материал}} \times 100$ <p>Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт: Байгаль орчны асуудал үүссэнээр компаниудад шинэ технологи, шийдлүүдийг нэвтрүүлэх, шинэлэг, ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломж бий болно. Тухайн бүтээгдэхүүн ногоон буюу байгаль орчинд ээлтэй эсэхийг ихэвчлэн мэргэжлийн шинжээчдийн хөндлөнгийн үнэлгээ (аудит, гэрчилгээ баталгаа, шошго)-гээр тогтоодог бөгөөд тэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тухайн бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлж баталгаажуулдаг. Энэ үзүүлэлт нь компаниуд өөрийн эко/ногоон шошго/ гэрчилгээ авсан бүтээгдэхүүнийхээ тоог гаргаж, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох чиглэлээр гаргаж буй өөрийн хүчин чармайлтаа ил тод тайлагнах боломж олгоно.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид тогтвортой хөгжил/БОН/ХАБЭА-н газар, хэлтсүүд, худалдан авалт буюу хангамжийн газар, хэлтсүүд, дотоод үйлдвэрлэл, хог хаягдлын бүртгэл тайлан зэрэг хамаарна.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ОУСК Гүйцэтгэлийн стандартууд ТОУС 304, 307, 403, 417</p>


MI. Уул уурхай

<p>Энэ салбар яагаад чухал вэ?</p>	<p>Уул уурхайн салбар нь Монгол Улс зэрэг цөөнгүй улс орны эдийн засгийн гол салбар төдийгүй үйлдвэрлэлийн болоод экспорт, улсын төсвийн орлогын багагүй хувийг бүрдүүлдэг. Тус салбарын олборлож буй ашигт малтмал нь эдийн засгийн томоохон хэсгийн суурь үндсийг тавьж байдаг. Үүний зэрэгцээ уул уурхайн салбар нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл ихтэй бөгөөд энэ нь ихэвчлэн олборлолт явуулж буй нутаг дэвсгэр, түүний орчин тойронд түлхүү үүсэж байдаг. Уул уурхайн үйлдвэрлэл нь өргөн уудам газар нутгийг тусгай эрхтэйгээр ашиглаж, томоохон хэмжээний ажиллах хүчний урсгалыг татахын зэрэгцээ хүний эрхийг зөрчих буюу нутгийн уугуул иргэдийн эрхэд нөлөөлөх эрсдэл өндөртэй бүс нутагт үйл ажиллагаа явуулах нь нийтлэг ажиглагдаж байна.</p>
<p>Үзүүлэлтүүд</p>	
<p>Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд</p>	<p>MI.1 Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь MI.2 Байгаль орчны тусгай зөвшөөрөл, стандартууд, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйтэй холбоотой үүссэн зөрчлийн тоо MI.3 Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн тоо</p>
<p>Тайлбар</p>	<p>Нөхөн сэргээлт: Компаниуд байгаль орчны стандартын дагуу барилга байгууламжийг буулгах, зайлуулах, дахин ашиглахдаа оролцогч талууд болон олон нийтийн эрэлт хэрэгцээг заавал тооцож байх шаардлагатай. Энэ үзүүлэлт нь байгууллагын өнөөгийн хэрэгжүүлж байгаа болон цаашид хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн төслүүдийн талаар мэдээлэл солилцох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, үйл явцыг тайлбарлах боломж олгоно. Компанийнхаа ашиглалтын зориулалттай нийт талбайд нөхөн сэргээсэн буюу сэргээсэн талбайн эзлэх хувийн жинг тодорхойлж хүрсэн түшингээ тайлагнах хэрэгтэй.</p> <p>Байгаль орчны хууль тогтоомжийн мөрдөлт: Компанийнхаа үйл ажиллагааны гүйцэтгэлийн тодорхой параметруудийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих удирдлагынх нь чадвар байгууллага дотроо хууль тогтоомжийг хэр мөрдөж байгаагаар илэрч байдаг. Эдийн засгийн үүднээс авч үзвэл хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх нь шууд буюу торгууль шийтгэл ногдуулахаас эхлээд компанийн нэр хүндэд нь шууд бус нөлөөллөөр үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулахад тусална. Зарим тохиолдолд хууль тогтоомж дагаж мөрдөөгүйн улмаас хүлээсэн үүргээ заавал биелүүлэх, байгаль орчны хариуцлага хүлээх зэрэг өндөр зардал гаргах шаардлага тулгарна. Дотооддоо хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөх соёлыг бат бөх хэвшүүлснээр тухайн байгууллага үйл ажиллагаагаа өргөжүүлэх, тусгай зөвшөөрөл авах зэрэг чадварыг сайжруулахад нөлөөлөх нь гарцаагүй.</p> <p>Нүүлгэн шилжүүлэлт: Аливаа ажлыг эхлүүлэх, өрнүүлэх, дуусгахтай холбоотой зохион байгуулалтын бүхий л үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн хүн амд хэд хэдэн томоохон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдаг. Энэ үзүүлэлт нь тухайн үйл ажиллагаа явуулж буй байгууллага нь орон нутгийн хүн амд учруулж болзошгүй нөлөөллийн талаар тодорхой мэдлэгтэй болохыг оролцогч талуудад мэдээлнэ. Түүнчлэн орон нутгийн хүн амын асуудалд тавих анхаарлыг байгууллагынхаа хэмжээнд чухалчилж сайжруулах боломжийг тухайн үйл ажиллагаа явуулж буй байгууллагад олгоно. Энэ үзүүлэлтээр эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн тоог тодорхойлно.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн боломжит эх сурвалжид байгууллагын баримталж буй бодлого журмууд, эрсдэлийн үнэлгээний журам; байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудитын тайлан, орон нутагт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн мэдээлэл; хөндлөнгийн оролцогч талуудын чуулга уулзалтуудад хийсэн дүн шинжилгээ, орон нутгийнхны хамтарсан бүлэг, хороод, оролцогч талуудын тайлан болон бусад санал зөвлөмжүүдэд хийсэн дүн шинжилгээ зэрэг хамаарна.</p>

Ашиглах материал	
ТХЗ-той уялдуулах	
Чухал эх сурвалжууд	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга ОУСК. Гүйцэтгэлийн стандартууд ТОУС 307, 203

СО. Барилга

Энэ салбар яагаад чухал вэ?	Барилгын салбар нь дэлхийн эрчим хүчний хэрэглээний 40 гаруй хувийг, дэлхийн хүлэмжийн хийн нийт ялгаруулалтын гуравны нэгээс илүү хувийг бүрдүүлж байна. Барилга байгууламжийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь нөлөөллийг бууруулах хамгийн хямд арга гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх болсон. Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Барилга байгууламж, дэд бүтцийг барих, удирдах, ашиглах, нурааж устгахтай холбоотой бүхий л үйл ажиллагааны явцад байгалийн нөөц шавхагдах, газар, агаар, усанд олон төрлийн бохирдуулагчид бий болох зэрэг эрсдэлтэй. Түүнчлэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй барилгын компаниуд нь нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг хүртээмжтэйгээр хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой.
Үзүүлэлтүүд	
Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд	<p>СО1.1 Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувийн жин (%)</p> <p>СО1.2 Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзана) (%)</p> <p>СО1.3 Монгол Улсын ногоон байгууламж, нийтийн талбайн хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (%)</p>
Тайлбар	<p>Ногоон барилга, байшин: Тогтвортой хөгжлийн удирдлагын давуу талыг ашиглах зорилгоор барилгын салбарын олон компаниуд барилга байгууламжийн зураг төсөлд ногоон элементүүдийг тусгаж, ногоон гэрчилгээ буюу ногоон шошго авахыг урьтал болгож байна. ОУСК-ийн EDGE (үр ашигтай шилдэг зураг төсөл), LEED (эрчим хүч, байгаль орчинд ээлтэй шилдэг зураг төсөл), BREEAM (барилгын судалгааны байгууллагын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга) гэх зэрэг гэрчилгээ/шошгыг олон улс орнууд нийтлэг ашиглаж байгаа бөгөөд улс орны дотоодын барилгын компаниудад ч ашиглах боломжтой. Үндэсний түвшинд, компаниуд эрчим хүчний мэргэшсэн аудиторуудаас олгодог эрчим хүчний шошго, эрчим хүчний паспортыг авах боломжтой. Үнэлгээний схемүүд нь ихэвчлэн эрчим хүч, усны хэрэглээ, дотоод агаарын чанар, материалын хэрэглээ, хүртээмжтэй орчин зэрэг асуудлыг болон бусад олон хүчин зүйлсийг хамруулсан байдаг. Компаниуд ногоон барилгын шошго буюу гэрчилгээ авсан барилгын төслүүдийнхээ хувийн жинг тооцож тайлагнах үүрэг хүлээнэ.</p> <p>Хүртээмжтэй орчин: Барилгын компаниуд эмзэг бүлгийн хүмүүст зориулсан хүртээмжтэй орчин, байгууламжийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэснээр эдгээр хүмүүст хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн чадавхаа нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Гэсэн хэдий ч олон компаниуд хүртээмжтэй орчныг бий болгож тэгш оролцоог хангах стандартыг тэр бүр дагаж мөрдөхгүй байгаа учир энэ үзүүлэлтээр барилгын компаниуд дээрх хууль тогтоомжийг хэрхэн мөрдөж байгааг харуулах зорилготой. Барилгын компаниудын комплаенсын түвшнийг олон улсын болон үндэсний стандартын дагуу хараат бус буюу хөндлөнгийн үнэлгээчид хийж болохын зэрэгцээ мөн байгууллагууд дотоодынхоо хүчээр ч ОУХБ-ын Бизнес, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын сүлжээ (GBDN)-ний Дүрмийн Өөртөө үнэлгээ хийх аргачлалыг ашиглан хийх боломжтой.</p>

<p>Тайлбар</p>	<p>Ногоон байгууламж буюу нийтийн эзэмшлийн талбай: Ажилтнууд, хүн амын бүлгүүд, өмч хөрөнгө, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүйн тулд химийн бодисыг зөв хадгалж, ашиглаж, хянаж зохицуулах учиртай. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учрах химийн хор хөнөөлийг тэр бүр хянахад хүндрэлтэй байгаа нь зөвхөн үйлдвэрлэлд ашиглаж байгаа асар их хэмжээний химийн бодисоос гадна дэлхий даяар өргөн тархсан нэхмэлийн салбарын олон шатлалтай нийлүүлэлтийн сүлжээний нарийн төвөгтэй байдалтай ч холбоотой юм. Химийн бодис ашиглалтын талаарх мэдээлэл тун хязгаарлагдмал байгаа төдийгүй ханган нийлүүлэлтийн сүлжээний хувьд ч тэр бүр мэдээлэл олдох нь ховор байна. Үйлдвэрлэгчид ч химийн бодисыг зүй зохистой ашиглах талаар мэдлэг, чадвар хомс байна. Иймд энэхүү үзүүлэлт нь ялангуяа үндэсний болон олон улсын хууль тогтоомжоор хориглосон химийн хорт болон аюултай бодис, материалыг зүй зохистой хадгалах, ашиглах талаарх бодлого, журам, үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.</p>
<p>Баримт нотолгоо</p>	<p>Мэдээллийн эх сурвалжид байгууллагын бодлогын баримт бичгийн лавлагаа, тогтвортой хөгжил/БОН/ХАБЭА-н асуудал хариуцсан газар хэлтсүүд, зураг төсөл болон төлөвлөлтийн газар, хэлтсүүд, байгаль орчин/нийгмийн/хүртээмжтэй орчны нөлөөллийн үнэлгээ, төслийн загвар, төлөвлөгөө зэрэг хамаарна.</p>
<p>Ашиглах материал</p>	
<p>ТХЗ-той уялдуулах</p>	
<p>Чухал эх сурвалжууд</p>	<p>ОУСК. Гүйцэтгэлийн стандартууд ОУХБ. Стандартууд, конвенцүүд ОУСК. EDGE (үр ашгийн шилдэг зураг төсөл)-Ногоон барилгын гэрчилгээ Дэлхийн Ногоон барилгын зөвлөл Монгол Улсын Барилгын эрчим хүчний шошго</p>

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Тайлагнавал зохих БОНЗ-ын үндсэн үзүүлэлтүүд (БОНЗ-ын тайлангийн загвар)

Огноо (он, сар, өдөр):

1	Үнэт цаас гаргагчийн нэр:	
2	Үнэт цаас гаргагчийн код (МХБ симбол):	
3	Салбар/үйлдвэрлэл (МХБ-ийн салбарын ангилал):	
4	Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	
5	Тайлангийн хамрах хугацаа:	
6	Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	
7	Тайланг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, УЗ-ын даргын мэдээлэл (нэр, албан тушаал):	
8	Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд			
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм/Үгүй
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм/Үгүй
MS2.2			Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Тийм/Үгүй
MS3.1		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм/Үгүй
MS3.2			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй
MS3.3			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй

MS3.4	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Бүтэц удирдлага	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй
MS3.5			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Тийм/Үгүй
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм/Үгүй
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	цаг
MS6.1		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм/Үгүй
MS7.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм/Үгүй
MS7.2			Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Тийм/Үгүй
MS7.3			Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Тийм/Үгүй
MS8.1	Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Тийм/Үгүй	
Е	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд			
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	кВт.ц
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	кВт.ц
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Гкал ба Гдж -Гегажоуль эсвэл кВт.ц
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд, 1. Халаах зорилгоор хэрэглэсэн түл буюу нүүрс, хий 2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	%
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	%

E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	CO2/тонн
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	CO2/тонн
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт	CO2/тонн
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм/Үгүй
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Тийм/Үгүй
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Төгрөг
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	Төгрөг
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	м3/Л
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	м3/Л
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	%
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	м3/Л
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	тонн
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	%
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	тонн
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	%

E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Төрөл зүйлийн тоо
E6.3	Биологийн олон янз байдал	Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	%
S Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	%
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	Тоо
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	цаг
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	%
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	цаг
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	хүн
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	%
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%

S3.7	Эрх тэгш байдал	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	харьцаа
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	%
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм/Үгүй
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	Төгрөг
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм/Үгүй
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Тийм/Үгүй
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм/Үгүй
S5.4	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм/Үгүй
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	%
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	%
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	%
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	%

G Засаглалын шалгуур үзүүлэлтүүд				
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм/Үгүй
G1.2		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	%
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм/Үгүй
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм/Үгүй
Салбарын онцлогтой нэмэлт шалгуур үзүүлэлтүүд (зөвхөн өөрийн компанид хамаарах салбарын асуулгад хариулна)				
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	хүн
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	%
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь	%
AF1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	
AF2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	%
AF3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	%
T1	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо, бэлчээрийн эзлэх хувь	но. & %
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь	но. & %
T3		Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм/Үгүй

MA1	Боловсруулах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм/Үгүй
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	%
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	%
MI1	Уул уурхай	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	%
MI2		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Зөрчлийн тоо
MI3		Нүүлгэн шилжүүлэлт	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэлтэд хамрагдсан иргэдийн тоо	Хүн
CO1	Барилга	Ногоон барилгын шошго/ гэрчилгээ	Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувь	%
CO2		Хүртээмжтэй байдал	Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзана)	%
CO3		Ногоон байгууламж, талбай	Монгол Улсын ногоон байгууламж, нийтийн талбайн хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь	%

Хавсралт 2. Олон улсад түгээмэл хэрэглэгддэг Тогтвортой байдлын тайлангийн стандартууд

ТОУС нь даян дэлхийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө гэсэн алсын зорилготойгоор эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэл, түүний нөлөөллийг хариуцлагатайгаар удирдаж олон нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг олон улсын ашгийн бус байгууллага юм. Дэлхийн 90 гаруй орны олон мянган компаниуд, төрийн байгууллагууд ТОУС-ийн удирдамж зааврыг ашиглаж байна. ТОУС-ийн Тогтвортой хөгжлийн нээлттэй мэдээллийн санд 24000 гаруй тайлан бүртгэгдсэн бөгөөд 27 улс орон, бүс нутгууд үндэснийхээ бодлого, журмуудад ТОУС-ийг эх сурвалж болгон ашиглаж байна. ТОУС нь нэгдүгээрт, тогтвортой хөгжлийн тайлагналын удирдамж, аргачлалыг боловсруулан гаргах, хоёрдугаарт, байгууллагуудын тогтвортой хөгжлийн тайлагналын үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд олон талын оролцоог дэмжих хамтын ажиллагаа, бүтээгдэхүүн, түншлэлийг хөгжүүлэх зэрэг хоёр үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

НҮБ Даян дэлхийн гэрээ нь бизнес эрхлэгчдэд зориулсан стратегийн бодлогын санаачилга бөгөөд хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, авлигатай тэмцэх зэрэг чиглэлээр явуулах үйл ажиллагаа, стратегийг бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арван зарчимтай уялдуулах зорилготой. Энэ санаачилгыг дэлхийн улс үндэстнүүдийн 80 гаруй сүлжээний 13000 гаруй байгууллага дэмжиж нэгдсэн байдаг. Бизнес эрхлэгчид нь өөрсдийн үйл ажиллагаа, хүрч буй ололт амжилтын талаарх тайланг тус санаачилгын төв албанд хүргүүлж жил бүр нийтлэгддэг Танилцуулгад оруулж нийтлүүлэх боломжтой.

УАЭСМТАХ нь 2015 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (FSB)-ийн шийдвэрээр байгуулагдсан.

Тэрээр сайн дурын үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бодитой мэдээллийг компаниуд, банкууд, хөрөнгө оруулагчдад зориулан боловсруулж мэдээлэх зорилготой. Улмаар эдгээр мэдээллийг цааш сонирхогч талуудад түгээхэд ашиглах боломж бүрдэж байгаа юм. Санхүүгийн байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжуудын талаарх найдвартай мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснээр санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж болзошгүй эрсдэлийн талаар илүү ойлголттой болох, илүү бэхэжсэн, эдийн засгийн тогтвортой хөгжлийн санхүүжилтийг сайжруулахад түлхэц болно.

НЯМТ нь олон улсын ашгийн бус байгууллага бөгөөд 2000 онд үүсгэн байгуулагдсан, Лондон хотод төвтэй. НЯМТ нь институцийн хөрөнгө оруулагчдын нэрийн өмнөөс “НЯМТ-д гарын үсэг зурсан талууд” болох дэлхийн томоохон хөрөнгийн биржид бүртгэлтэй зарим компаниудад жил бүр асуулга илгээх замаар уур амьсгалын өөрчлөлт, ус, ойн асуудлаарх стандартчилсан мэдээллийг цуглуулдаг. Компаниудыг байгаль орчны эрсдэлийг үнэн бодитой тооцож, ил тод тайлагнахад нь дэмжлэг болох мэдээллийг ч мөн хувьцаа эзэмшигчид шаарддаг.

ТБНББСЗ нь АНУ-д төвтэй ашгийн бус байгууллага бөгөөд үнэт цаас гаргагчдын зүгээс Үнэт цаас, Биржийн хороонд хүргүүлэх тайлан мэдүүлэгт тогтвортой хөгжлийн нөлөөллийн хүчин зүйлсийг тайлагнахдаа ашиглаж болох нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулж, хэрэгжүүлж хэвшүүлэх зорилготой. ТБНББСЗ нь 10 салбарын 80 гаруй дэд салбарыг хамруулсан стандартуудын төслийг боловсруулж, салбаруудын дотоод нөлөөллийн хүчин зүйлсийг судалж, салбар хариуцсан ажлын хэсгүүдийг хуралдуулж, нягтлан бодох бүртгэлийн хэмжигдэхүүнүүдийг боловсруулах зорилгоор олон нийтийн санал асуулга явуулж, санхүүгийн бус нөлөөллийн хүчин зүйлсийг нарийвчлан судлах болон бүртгэж тооцох чиглэлээр сургалт явуулж байна. ТБНББСЗ-өөс боловсруулсан тогтвортой хөгжлийн Нөлөөллийн Зураглал нь хэрэглэгчдэд ТБНББСЗ-ийн заавал тайлагнах сэдвүүдийг салбар тус бүрээр нь тодорхойлж, янз бүрийн салбарууд, дэд салбаруудын тогтвортой хөгжлийн төрөл бүрийн хүчин зүйлсийн болзошгүй нөлөөллийг харьцуулахад туслах маш ойлгомжтой арга зүйн хэрэгсэл юм.

ОУНТЗ нь нэгдсэн тайлагналын хүрээг тогтоох зорилгоор корпораци, хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэл, үнэт цаас, зохицуулалт, эрдэм шинжилгээ, стандарт тогтоох, иргэний нийгэм зэрэг олон салбарыг төлөөлсөн олон улсын манлайлагчдаас бүрдсэн. Нэгдсэн тайлагналын энэхүү стандарт нь байгууллагын стратеги, засаглал, гүйцэтгэл, хэтийн зорилтоос үүсэж болзошгүй нөлөөллийн мэдээллийг товч, тодорхой, харьцуулахуйц хэлбэрээр гаргах боломжийг нээх төдийгүй компанийн тайлагналд үндсэн шинэчлэлт хийж байгаа юм.

ОУСК-ийн Мэдээллийг нээлттэй, ил тод тайлагнах арга зүйн лавлах. Дэлхийн Банкны Группийн зүгээс хөрөнгө оруулагч буюу зөвлөхийн хувиар хамтран ажилладаг улс орон, компаниудынхаа жилийн тайлагнал, ил тод байдлын стандартыг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтыг илүү өргөн утгаар дэмжих зорилгоор энэхүү аргачлалыг боловсруулсан. Энэ нь компаниуд, хөрөнгийн бирж, зах зээлийн зохицуулагч байгууллагууд болон хөрөнгө оруулагчдад зориулсан БОНЗ-ын гол чухал мэдээллүүдийг хамруулсан жилийн тайланг цогц, нэгдсэн байдлаар бэлтгэх зааварчилсан удирдамж юм.

ЕХ-ны Тогтвортой байдлын ил тод байдлын зохицуулалтууд

ЕВРОПЫН НОГООН ТОХИРОЛЦОО (GREEN DEAL)	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	
<p>Санхүүгийн бус тайлагналын удирдамж (NFRD) (2014/95/ЕХ)/</p> <p>Компанийн тогтвортой байдлын тайлагналын удирдамж (CSRD) (санал)</p>	<p>ЕХ-ны Таксономи (ЕХ-ны 2020/852 зохицуулалт)</p>	<p>Тогтвортой санхүүжилтийн мэдээллийг ил тод болгох журам (SFDR) (ЕХ-ны 2020/852 зохицуулалт)</p>
<p>Хэн: 500-гаас дээш ажилтантай томоохон компаниуд</p> <p>Юу: Ил тод байдал нь холбогдох бодлого, үндсэн эрсдэлүүд, мөндю дилижинс процесс, KPI болон компанийн бизнесийн загварыг хамарсан байна.</p> <p>Хэзээ: CSRD-ы санал 2021 оны 4-р сард батлагдсан.</p>	<p>Хэн: Санхүүгийн зах зээлийн томоохон оролцогчид болон удирдамжид заасан санхүүгийн бус компаниуд</p> <p>Юу: ЕХ-ны Таксономи нь байгаль орчны зургаан зорилтын хүрээнд "байгаль орчинд ээлтэй" бизнесийн үйл ажиллагааг тодорхойлоход ашигладаг ангиллын систем юм.</p> <p>Ил тод байдал нь ЕХ-ны Таксономид хэр зэрэг нийцэж байгааг харуулах ёстой.</p> <p>Хэзээ: 2020 оны 7-р сар</p>	<p>Хэн: Санхүүгийн зах зээлд оролцогчид болон санхүүгийн зөвлөхүүд</p> <p>Юу: Ил тод байдал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явц дахь тогтвортой байдлын эрсдэл, болзошгүй сөрөг хүчин зүйлс, түүнчлэн ногоон сангийн талаарх нэмэлт тодруулгыг багтаасан байна.</p> <p>Хэзээ: 2021 оны 3-р сар</p>
<p>Нэмэлт удирдамж:</p> <p>Санхүүгийн бус тайлагналын талаарх заавал биелүүлэх удирдамж (2017)</p> <p>УАӨСМТАХ зөвлөмжийг нэгтгэсэн уур амьсгалтай холбоотой мэдээллийг тайлагнах (2019) удирдамж.</p>	<p>Зохицуулалтын актууд нь практик хэрэгжилтийг хөнгөвчлөх техникийн шалгуурыг (TSC) тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох техникийн шалгуур (2021 оны 4-р сар) Үлдсэн зорилтуудыг хангах техникийн шалгуур (2022 оны эхний хагаст нийтлэгдэнэ) 	<p>Зохицуулалтын техникийн стандартууд (RTS) нь компаниудад тогтвортой байдлын талаарх мэдээллийг илүү тодорхой болгож өгнө.</p> <ul style="list-style-type: none"> Тайлагналын журмын д хууль ёсны мөрдлөг Метрик шалгуур, загвар, аргачлалууд
<p>Хамрах сэдвүүд:</p> <p>Байгаль орчны асуудлууд</p> <p>Нийгмийн болон ажилчдын асуудлууд</p> <p>Хүний эрх</p> <p>Авлига, хээл хахууль</p> <p>Удирдах зөвлөлийн олон талт байдал</p>	<p>Хамрах сэдвүүд:</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицуулах</p> <p>Ус болон далайн нөөцийн хамгаалалт, хэрэглээ</p> <p>Тойрог эдийн засгийн шилжилт</p> <p>Бохирдлоос сэргийлэх, бууруулах</p> <p>Биологийн олон янз байдал болон экосистемийг хамгаалах, сэргээх</p>	<p>Хамрах сэдвүүд:</p> <p>Тогтвортой байдлын эрсдэлүүд</p> <p>Уур амьсгал, байгаль орчин, нийгэм, ажиллах хүчний асуудлууд, хүний эрх, авлига, хээл хахуульд нөлөөлөх сөрөг хүчин зүйлс</p> <p>Ногоон хөрөнгүүд</p>

Эх сурвалж: https://www.bvb.ro/info/Rapoarte/Ghiduri/ESG_Reporting_Guidelines.pdf тайлангийн Б хавсралт.

Хавсралт 3. Тогтвортой байдлын тайлагналын эх сурвалжууд

ТОУС-ын Тайлагналын стандартуудын бүртгэлийн систем нь ТОУС-ын стандартын дагуу боловсруулж, баталгаажуулсан жилийн болон тогтвортой байдлын тайлангийн мэдээллийн санг бүрдүүлдэг. Дараах хүснэгтэд Монгол Улсын болон бусад орны компаниудын тайлангийн зарим жишээг үзүүлээ.

Салбар	Компанийн тайлан
Хөдөө аж ахуй, хүнс, ундааны үйлдвэрлэл	APU (2018; 2020; 2021) Coca Cola Coca Cola HBC Pepsico McDonald's Whitbread
Санхүү	Golomt Bank Khan Bank Allianz AXA UBS HSBC
Эрүүл мэнд	Baxter
Зочид буудал	Edwardian Group London The Hongkong and Shanghai Hotels, Limited
Барилга, дэд бүтэц	REIT
Боловсруулах үйлдвэрлэл	MSC Group Gobi Cashmere Marks and Spencer Group plc Plan A Report GM Ikea Johnson & Johnson L'Oreal
Уул уурхай	Oyu Tolgoi BP Shell
Эрчим хүч	Energy Resources CLP EDF Energy Ofgem requirements for UK electricity suppliers UK Power Networks
Мэдээлэл, технологи	Vodafone Apple Siemens Telefonica
Боловсрол	Stanford University University of California, Berkeley

Хавсралт 4. ТБНББСЗ Тогтвортой хөгжлийн материаллаг байдлын зураглал

■ салбарын 50 гаруй хувьд энэ асуудал нөлөөлөх магадлалтай

■ салбарын 50-иас доош хувьд энэ асуудал нөлөөлөх магадлалтай

○ тус салбарт энэ асуудал ямар ч нөлөө үзүүлэхгүй

		Өргөн хэрэглээний бараа	Олборлолт & Ашигт малтмал боловсруулалт	Санхүүгийн үзүүлэлт	Хоол & Уух зүйлс	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Дэд бүтэц	Сэргээгдэх нөөц & Альтернатив эрчим хүч	Нөөцийн шилжилт	Үйлчилгээ
Хэмжүүр	Ерөнхий асуудлын ангилал									
Байгаль орчин	Хүлэмжийн хийн ялгарал		■		■					
	Агаарын чанар		■							
	Эрчим хүчний менежмент				■					
	Ус & Бохир усны менежмент									
	Хог хаягдал & Аюултай материалын менежмент								■	
	Экологийн нөлөөлөл									■
Нийгмийн капитал	Хүний эрх & Нийгмийн харилцаа									
	Хэрэглэгчийн нууцлал	■								
	Мэдээллийн аюулгүй байдал					■				
	Хүртээмж & Боломжийн үнэ									
	Бүтээгдэхүүний чанар & Аюулгүй байдал	■								■
	Хэрэглэгчийн сайн сайхан байдал									
	Борлуулалтын туршлага & Бүтээгдэхүүний шошгожуулалт				■					
Хүний хөрөнгө	Хөдөлмөрийн дадал, туршлага									
	Ажилтны эрүүл мэнд & Аюулгүй байдал		■							
	Ажилтны оролцоо, олон талт байдал, хамрагдах байдал	■								
Бизнесийн загвар & Инноваци	Бүтээгдэхүүний дизайн & Амьдралын мөчлөгийн менежмент									
	Бизнесийн загварын уян хатан байдал									
	Нийлүүлэлтийн сүлжээний менежмент	■								
	Материалын эх үүсвэр ба үр ашиг				■					
	Уур амьсгалын өөрчлөлтийн биет нөлөөлөл									■
Удирдлага & Засаглал	Бизнесийн ёс зүй			■						
	Өрсөлдөөний зан байдал									■
	Хууль эрх зүй, зохицуулалтын орчны менежмент									
	Аюултай ослын эрсдэлийн менежмент		■							
	Системийн эрсдэлийн удирдлага			■						

Хавсралт 5. Жишээ: Тогтвортой байдлын материаллаг байдлын матриц (Nestle)

Оролцогч талуудад ач холбогдолтой юу?				
Оролцогч талуудад ач холбогдолтой юу?	Маш чухал ач холбогдолтой		<ul style="list-style-type: none"> Хариуцлагатай хэрэглээ Хүний эрх 	<ul style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах
	Ач холбогдол өндөр	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдал 	<ul style="list-style-type: none"> Хуванцар савтай ус, усны менежмент Бөөний борлуулагчдын харилцаа хамтын ажиллагаа Газарзүйн байршил, улс төр, эдийн засгийн үзүүлэлт Бүтээгдэхүүний зохицуулалт, журам/ татвар Хариуцлагатай маркетинг, брэнд сурталчилгаа Бизнесийн ёс зүй Иргэд, олон нийтийн харилцаа 	<ul style="list-style-type: none"> Хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчдийн зан төлөв Бүтээгдэхүүний савалгаа пластик хэрэглээ Шинэлэг бизнесийн модел Дижиталчлал технологийн дэвшил Өрсөлдөх чадвар бүтээмж Портфолио тус бүрээр тооцогдох тэжээллэг чанарын үзүүлэлт Бүтээглэхүүний чанар аюулгүй байдал
	Дунд зэрэг ач холбогдолтой	<ul style="list-style-type: none"> Ан амьтныг хохироохгүй байх 	<ul style="list-style-type: none"> Кибер аюулгүй байдал Худалдан авалт, хөрөнгө оруулалт Хог хаягдлын хэмжээг 0 д хүргэх Төрөлжилт, хүртээмжтэй байдал Тэжээлийг хүртээмжтэй байлгах 	<ul style="list-style-type: none"> Чадварлаг хүний нөөц бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг бий болгох
	Ямар ч ач холбогдолгүй	<ul style="list-style-type: none"> Тэтгэврийн хуримтлалын менежмент 	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн нууцлал 	
	Ямар ч ач холбогдолгүй	Дунд зэрэг ач холбогдолтой	Ач холбогдол өндөр	Маш чухал ач холбогдолтой

Nestle-гийн амжилтад үзүүлэх нөлөө - Дотоод оролцогч талууд

- Хүмүүс болон амьтад
- Эх дэлхий

- Иргэд, олон нийтийн бүлэг
- Урт хугацааны үнэ цэнийг өсгөх

Хавсралт 6. Хүлэмжийн хийн ялгарлын хамрах хүрээ, эх үүсвэрүүд (Хүлэмжийн хийн Протокол)

Хамрах хүрээ, категориуд ⁷	тонн метр CO ₂ -экв
Хамрах хүрээ 1: Эзэмшлийн буюу хяналт тавьж буй үйл ажиллагаанаас шууд ялгарал	
Хамрах хүрээ 2: Худалдаж авсан цахилгаан, уур, дулаан, хэрэглээний эрчим хүчнээс шууд бус ялгарал	
Хамрах хүрээ 3 – өмнөх үеийн	
Категори 1: Худалдаж авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ	
Категори 2: Эд хөрөнгө	
Категори 3: Түлш болон эрчим хүчтэй холбоотой үйл ажиллагаа (хамрах хүрээ 1 болон 2-т ороогүй)	
Категори 4: Тээвэр, түгээлт – өмнөх үеийн	
Категори 5: Үйл ажиллагааны явцад ялгаруулсан хог хаягдал	
Категори 6: Бизнес томиллолт	
Категори 7: Ажилтнуудын зорчих хөдөлгөөн	
Категори 8: Эд хөрөнгийн түрээс - өмнөх	
Бусад	
Хамрах хүрээ 3 – дараах үеийн	
Категори 9: Тээвэр, түгээлт – дараах үеийн	
Категори 10: Борлуулсан бүтээгдэхүүнийг боловсруулах	
Категори 11: Борлуулсан бүтээгдэхүүнийг ашиглах	
Категори 12: Борлуулсан бүтээгдэхүүний ашиглалтын хугацаа дуусаж устгах	
Категори 13: Эд хөрөнгийн түрээс - дараах	
Категори 14: Франчайз (Franchises)	
Категори 15: Хөрөнгө оруулалтууд ⁸	
Бусад	

⁷ Категорийг илүү нарийвчлан задлах шаардлага гарч болно. Түүнчлэн хамрах хүрээ 3-ын категориудыг тодорхойлохдоо холбогдох стандартыг мөрдөөгүй бол хаана оруулснаа тодорхой тайлбарлах хэрэгтэй.

⁸ Хэрэв тайлан гаргаж байгаа компани нь төслийн анхны ивээн тэтгэгч буюу зээлдүүлэгч бол тайлант жилийн хугацаанд санхүүжүүлсэн холбогдох төслүүдийн хэрэгжилтийн нийт хугацаанд төлөвлөсөн хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээг хамрах хүрээ 3-с салгаж тусад нь тайлагнана.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Үзүүлэлтүүдийг боловсруулахад ашигласан эх сурвалжууд:

- Тайлагналын олон улсын санаачилгын стандартууд: <https://www.globalreporting.org/standards/>
- Тайлагналын олон улсын санаачилга G4 Тогтвортой байдлын тайлагналын удирдамжууд – Хэрэгжүүлэх гарын авлага: <https://respect.international/g4-sustainability-reporting-guidelines-implementation-manual/>
- НҮБ Тогтвортой Хөрөнгийн биржийн мэдээллийн сан: <https://sseinitiative.org/data/>
- НҮБ SSEI (2015). БОНЗ-ын мэдээллийг хөрөнгө оруулагчдад тайлагнах загвар журам. <https://sseinitiative.org/wp-content/uploads/2017/06/SSE-Model-Guidance-on-Reporting-ESG.pdf>
- НҮБ Даян дэлхийн гэрээ: <https://www.unglobalcompact.org>
- НҮБ ТХЗ-ууд: <https://sdgs.un.org/goals>
- ОУСК Гүйцэтгэлийн стандартууд: https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/sustainability-at-ifc/policies-standards/performance-standards
- ОУСК БОНУС Гарын авлага: https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/sustainability-at-ifc/publications/publications_handbook_esms-general
- ОУСК БОНУС Аргачлал: https://www.ifc.org/wps/wcm/connect/6147cbba-efe8-4879-ba77-c7af63bede7c/ESMS_Toolkit_General.pdf?MOD=AJPERES&CVID=nzhmvxC
- ОУСК Тайлан тэнцлээс бусад Мэдээллийг нээлттэй тайлагнах ОУСК-ийн арга зүйн лавлах: https://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/ifc+cg/resources/toolkits+and+manuals/beyond+the+balance+sheet+-+ifc+toolkit+for+disclosure+and+transparency
- Бизнесийн зөвлөмж, цаашдын арга зүйн хэрэгсэл: <https://futurefitbusiness.org/companies/>
- Доу Жонсын (Dow Jones) Тогтвортой байдлын Индекс: <https://www.spglobal.com/spdji/en/index-family/esg/core-esg/djsi/#overview>
- ТБНБСЗ Тогтвортой хөгжлийн нөлөөллийн зураглал: <https://www.sasb.org/standards/materiality-map/>
- УАӨСМТАХ Зөвлөмжүүд: <https://www.fsb-tcfd.org/recommendations/>
- ДНИ/ДТХБЗ (WRI/WBCSD). Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын стандарт (Хүлэмжийн хийн Протокол): <https://ghgprotocol.org/sites/default/files/standards/ghg-protocol-revised.pdf>
- ЭЗХАХБ/ОECD Компанийн засаглалын зарчмууд (2015): <https://www.oecd.org/daf/ca/Corporate-Governance-Principles-ENG.pdf>
- IPIECA (Дэлхийн гарын тос, байгалийн хий үйлдвэрлэлийн Байгаль орчныг хамгаалах холбоо) (2020). Тогтвортой байдлын тайлагналын удирдамж, Хэвлэл 4: <https://www.ipieca.org/our-work/sustainability/performance-reporting/sustainability-reporting-guidance/>
- Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх зарчмууд: <https://www.unglobalcompact.org/take-action/action/womens-principles>
- Нэгдсэн нөлөөллийн үзүүлэлтүүд: https://www.edfi.eu/wp/wp-content/uploads/2021/03/2021-03-15-IRIS-JII_R14.pdf
- Малайзын хөрөнгийн бирж (Bursa Malaysia) Тогтвортой байдлын тайлагналын арга зүйн лавлах: <https://bursasustain.bursamalaysia.com/pillar-details/resources>
- Сингапурын Хөрөнгийн бирж. Тогтвортой байдлын Аргачлал, Эх сурвалжууд https://investorrelations.sgx.com/sustainability?field_nir_asset_date_value=2021#views-exposed-form-widget-assets-table
- Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд: https://www.ifc.org/wps/wcm/connect/05296e6c-86e0-4475-ae0e-20200dca900b/MBA_Principles-and-Guidance-Notes-Mongolia_Final.pdf?MOD=AJPERES&CVID=kKZr0cX
- MSE members' annual reports: http://old.mse.mn/en/mse_top_20/30

ЭХ СУРВАЛЖ:

- 1 ОУСК (2018). https://www.ifc.org/wps/wcm/connect/d4bd76ad-ea04-4583-a54f-371b1a7e5cd0/Beyond_The_Balance_Sheet_IFC_Toolkit_for_Disclosure_Transparency.pdf?MOD=AJPERES&CVID=morp0vo
- 2 FC4S (2021). Shifting Gears II: Financial centres set the stage for sustainable finance's exponential growth in the next decade. https://www.fc4s.org/viewpdf.php?pdf_file=wp-content/uploads/2021/01/Shifting-Gears-II_FC4S-Public-Report_2021.01.20.pdf And upcoming global report.
- 3 ТоС Холбоо. Монгол Улсын Тогтвортой Санхүүжилтийн зарчмууд www.toc.mn
- 4 Сантиего Бирж (2016). Үнэт цаас гаргагчдад зориулсан заавар удирдамж: Тогтвортой байдлын тайланг боловсруулах, гаргах заавар <https://sseinitiative.org/wp-content/uploads/2014/08/2017-Design-and-Construction-of-Sustainability-Reports-Santiago-Exchan....pdf>
- 5 CFA Institute (2018), Environmental, Social and Governance (ESG) Survey. <https://www.cfainstitute.org/-/media/documents/survey/esg-survey-report-2017.ashx>
- 6 ОУСК. Вьетнамын Улсын үнэт цаасны хороо (n.d.). Вьетнамын компаниудад зориулсан Тогтвортой байдлын тайлагналын гарын авлага. https://www.ifc.org/wps/wcm/connect/49bf4b6c-9287-4ad1-91a2-60badb7aebb3/vietnam_sustainability-reporting-handbook.pdf?MOD=AJPERES&CVID=jSEleSV
- 7 Бурса Малайз Улс (2018). Тогтвортой байдлыг тайлагнах заавар, 2-р хэвлэл. [https://bursa-malaysia.s3.amazonaws.com/reports/Bursa%20Malaysia%20Sustainability%20Reporting%20Guide%20\(2nd-Edition\).pdf](https://bursa-malaysia.s3.amazonaws.com/reports/Bursa%20Malaysia%20Sustainability%20Reporting%20Guide%20(2nd-Edition).pdf)
- 8 НҮБ SSEI (2015). Model Guidance on Reporting ESG Information to Investors. <https://sseinitiative.org/wp-content/uploads/2017/06/SSE-Model-Guidance-on-Reporting-ESG.pdf>
- 9 Сантиего Бирж (2016). Үнэт цаас гаргагчдад зориулсан заавар удирдамж: Тогтвортой байдлын тайланг боловсруулах заавар . <https://sseinitiative.org/wp-content/uploads/2014/08/2017-Design-and-Construction-of-Sustainability-Reports-Santiago-Exchan....pdf>
- 10 GreenBuzz. Why should business care?. <https://greenbuzzberlin.de/why-should-business-care/>
- 11 Волш, Кассандра, Сулковский, Адам (Walsh, Cassandra & Sulkowski, Adam). (2009). Ногоон компани нь ажилчдаа илүү аз жаргалтай, илүү үнэ цэнтэй болгож байна: Ажилчдын сэтгэл ханамж, байгаль орчны гүйцэтгэл, компанийн санхүүгийн үнэ цэнэ - регрессийн шинжилгээ. Байгаль орчны салбар хоорондын тойм.
- 12 НҮБХХ. 2021. ТХЗ-ын Нөлөллийн Стандарт. <https://sdgimpact.undp.org/practice-standards.html>
- 13 ОУСК. Вьетнамын Улсын үнэт цаасны хороо (n.d.). Вьетнамын компаниудад зориулсан Тогтвортой байдлын тайлагналын гарын авлага. https://www.ifc.org/wps/wcm/connect/49bf4b6c-9287-4ad1-91a2-60badb7aebb3/vietnam_sustainability-reporting-handbook.pdf?MOD=AJPERES&CVID=jSEleSV
- 14 Испаны хөрөнгийн бирж (2016). Бүртгэлтэй компаниудын БОНЗ-ын асуудлын талаарх тайлан гаргахад нь зориулсан сайн дурын зах зээлийн удирдамж http://www.bolsasymercados.es/ing/Media/Document/20161110/BME_guia_voluntaria_eng.pdf/Spanish_Stock_Exchange_s_voluntary_market_guidance_for_listed_companies_for_corporate_reporting_on_ESG_information
- 15 KPMG International Cooperative (2014). Sustainable Insight / The essentials of materiality assessment. <https://assets.kpmg/content/dam/kpmg/pdf/2014/10/materiality-assessment.pdf>
- 16 Коломбын Хөрөнгийн бирж (2018). Тогтвортой байдлын талаарх мэдээлэл. <https://sseinitiative.org/home-slider/sri-lankan-exchange-launches-sustainability-guidance/>
- 17 ОУСК. Вьетнамын Улсын үнэт цаасны хороо (n.d.). Вьетнамын компаниудад зориулсан Тогтвортой байдлын тайлагналын гарын авлага. https://www.ifc.org/wps/wcm/connect/49bf4b6c-9287-4ad1-91a2-60badb7aebb3/vietnam_sustainability-reporting-handbook.pdf?MOD=AJPERES&CVID=jSEleSV
- 18 Ногоон байгууллагын төлөөх хөдөлгөөн (n.d.). Тогтвортой байдлын тайланг хэрхэн бэлтгэх вэ? Эхлэлийн 6 алхам. <https://www.greenofficemovement.org/how-to-write-a-sustainability-report/>
- 19 IPIECA (2020). Sustainability Reporting Guidance 4th Edition. <https://www.iecea.org/our-work/sustainability/performance-reporting/sustainability-reporting-guidance/>

- 20 ОУСК, State Securities Commission of Vietnam (n.d.). Sustainability Reporting Handbook for Vietnamese Companies. https://www.ifc.org/wps/wcm/connect/49bf4b6c-9287-4ad1-91a2-60badb7aebb3/vietnam_sustainability-reporting-handbook.pdf?MOD=AJPERES&CVID=jSEIeSV
- 21 ТООС (2016). Тайлагналын суурь үндэс - Заавар. <https://www.globalreporting.org/standards/media/1036/gri-101-foundation-2016.pdf>
- 22 Сантиего Бирж (2016). Үнэт цаас гаргагчдад зориулсан заавар удирдамж: Тогтвортой байдлын тайлан боловсруулах заавар <https://sseinitiative.org/wp-content/uploads/2014/08/2017-Design-and-Construction-of-Sustainability-Reports-Santiago-Exchan....pdf>
- 23 ИРЕСА (Дэлхийн гарын тос, байгалийн хий үйлдвэрлэлийн Байгаль орчныг хамгаалах холбоо) Тайлагналын удирдамж (Reporting Guideline) 2019 <https://www.iecea.org/our-work/sustainability/performance-reporting/sustainability-reporting-guidance/>
- 24 Монгол Улсын Засгийн газар (2017). Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого. <https://legalinfo.mn/mn/detail/12536/2/207663>
- 25 ТООС болон ONCE Сан (2019). Тогтвортой хөгжлийн тайлагналын сул талууд. https://disabilityhub.eu/sites/disabilityhub/files/gri_disability_reporting_0.pdf
- 26 Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд (PRI). Хувийн компаниудын болон хөрөнгийн ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх БОНЗ-ын эрсдэлийн удирдлага. <https://www.unpri.org/environmental-social-and-governance-issues/managing-esg-risk-in-the-supply-chains-of-private-companies-and-assets/615.article>
- 27 ИРЕСА (Дэлхийн гарын тос, байгалийн хий үйлдвэрлэлийн Байгаль орчныг хамгаалах холбоо) (2020). Тогтвортой байдлын тайлагналын удирдамж. Хэвлэл 4. <https://www.iecea.org/our-work/sustainability/performance-reporting/sustainability-reporting-guidance/>
- 28 СЗХ (2022). Компанийн засаглалын Кодекс. http://www.frc.mn/resource/frc/Document/2022/03/29/g3f6m6xt5wx1rbi3/Corporate_Governance_Code_Mongolia.pdf
- 29 Олон улсын ил тод байдлын санаачилга (2013). Хээл хахуулийн эсрэг бизнесийн зарчмууд. <https://www.transparency.org/en/publications/business-principles-for-counteracting-bribery>
- 30 ЭЗХАХБ. Компанийн засаглалын зарчмууд. (2015). <https://www.oecd.org/daf/ca/Corporate-Governance-Principles-ENG.pdf>
- 31 ТоС Холбоо (2021). Нэхмэлийн салбар- Ногоон зээл олгох аргачлал. <http://toc.mn/post/125>